

БУРХАНЫ ХҮМҮҮСИЙГ ХОНЬЧЛОХ ДУУДЛАГА

**ТҮРГЭВЧИЛСЭН БИБЛИЙН СУРГУУЛИЙН
200 ХИЧЭЭЛИЙН ХУРААНГУЙ**

Хянан тохиолдуулсан Тэлма Браун

Хоёр дахь хэвлэл

Өмнөх үг

Энэ номыг Түргэвчилсэн Библийн Сургуулийн Хөдөлгөөнийг санаачлагч Виллис ба амьдралд маань аз жаргал бэлэглэж үйлчлэлд минь шинэлэг бүхнийг авчирдаг гурван хүүдээ зориулав.

**Хэвлэлтэнд гаргасан: EVANGELISM RESOURCES
425 Epworth Avenue, Wilmore, Kentucky 40390, U.S.A.**

©2020, Зохиогчын эрхийг хадгалана.

ГАРЧИГ

Өмнөх үг.....	4
Библийн номнууд.....	6
- Хуучин Гэрээ.....	8
- Шинэ Гэрээ.....	21
Библийн онол.....	33
Номлолын онол.....	65
Бусдыг хоньчлох.....	80
Ариун амьдрал.....	109
Урсгал чиглэлийн уялдаа холбоо.....	123
Библийн номнууд.....	125

ӨМНӨХ ҮГ

Энэ ном нь хот тосгон, аймаг сумд байгаа хүмүүсийг хоньчлох Түүний онцгой дуудлагыг авсан Христийн дагалдагч нарт зориулан бэлтгэгдсэн. Бурханы таньд өгсөн үүргийг биелүүлэхийн тулд шинийг сурч, залбирч үйлчлэлд өөрийгөө бэлтгэхээр ирсэн та бол онцгой нэгэн юм.

Нийт 200 хичээлийг 40 өдөрт багтаан өдөр бүр таван цаг хичээллэнэ. Доорх хуваарын дагуу хичээллэх ба энэ нь уламжлалт хэлбэрээр 8 долоо хоногт ордог хуваартай адил юм.

7:30-8:00	Мөргөл
8:00-8:50	Библийн номнууд
8:50-9:40	Номлолын онол
10:30-10:50	Завсарлага
10:50-11:40	Бусдыг хоньчлох
11:40-12:30	Ариун амьдрал (эхний 4 долоо хоногт) Урсгал чиглэлийн уялдаа холбоо үлдсэн 4 долоо хоногт

Үдээс хойш үзсэн хичээлээ бататгаж, харилцан ярилцах ба тухайн өдөр сурсан зүйлээ ойр байгаа сургууль болон айлуудаар явж хэрэгжүүлж хүмүүсийн загасчид байх юм. Энэ бол тухайн өдрийн хамгийн чухал цагууд байх болно.

Зарим хичээлүүд их урт нэг цагын дотор зааж амжихгүй тул дараагийн хичээл дээр үргэлжлүүлэх шаардлага гарч болзошгүй юм. Гэвч бид энэ сургалтыг бэлтгэх явцад хичээлийн 200 цагийг үр дүнтэй ашиглахаар хичээлүүдээ хувиарласан тул дахин давтаж орох боломжгүй. Хэрэв хичээл цагтаа багтаж дуусаагүй тохиолдолд үдээс хойш орох ба дараа өдөр нь шинэ сэдэвтээ орно.

Энэ 40 өдөрт Бурханы гайхалтай үгийг судлан Түүний хаант улсын үйлчлэлд бэлтгэгдсэн таны амьдралын хамгийн гайхалтай өдрүүд байх болно. Та энэ сургалтыг дуусах үед сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлж, Эзэнд үйлчилж олон хүмүүсийг Эзэн руу удирдсан, авралд авчирсан мөн бусдыг Түүн дотор өсөж нөхөрлөхөд нөлөөлсөн нэгэн болоосой гэж бид залбирч байна.

БИБЛИЙН НОМНУУД

Библийн 66 номыг 8 долоо хоногт судлаад агуулагыг нь бүрэн дүүрэн ойлгоход хангалтгүй богино хугацаа юм – хорвоо дээр хамгийн урт насалсан хүнд ч энэ хугацаа хангалтгүй. Харин та энэ сургалтаар дамжуулан Библийн хуудас бүр нь ямар их баялаг вэ гэдгийг мэдэрч амьдралынхаа өдөр бүр энэ номыг амтархан судлах дадалтай болж чадна. Библи хэлэхдээ “Өөрийгөө ичих зүйлгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээ” гэсэн (2 Тимот 2:15). Та энэ Ариун номтой хир их нөхөрлөнө тэр чинээгээр Зохиогчийг нь бас үг бүрийг нь хайрлах болно. Тийнхүү тань амьдрал болон үйлчлэл тань хэний ч сонсоогүй ивээлүүдээр дүүргэгдэх болно.

Таны төлөөх Миний залбирал

Тэнгэрлэг хайрын Аав минь, таны бидэнд зориулан бичсэн Ариун Номонд байгаа мөнхийн үнэн үгээр цанган, шимтэн уншиж байгаа энэ хүнийг та ивээж өгөөч.

Энэ хэсгийг бэлтгэхэд Хэнрита С. Меерсийн бичсэн “Библи Чухамдаа Юун Тухай” “Вэ ном, Ж. Вэрнөн МгКеен бичсэн “Библийн Хураангуй” болон Жон Балчний бичсэн “Библийн Хураангуй тайлбар” зэрэг номноос иш татав.

1-р Хичээл ТАНИЛЦУУЛАГА

Библи бол Бурхан өөрийн хүслээ хүн төрлөхтөнд бичгээр илэрхийлсэн хэлбэр. Библийн гол санаа нь Есүс Христээр дамжин ирэх авралын тухай юм.

Библи нь 1600 жилийн турш 40 зохиогчоор бичигдсэн ба нийтдээ 66 номноос бүрддэг.

Хуучин Гэрээ нь ихэнхдээ еврей хэлээр бичигдсэн бол Шинэ Гэрээ нь Грек хэлээр дээр бичигдсэн. Зохиогчид нь хаад, хан хүү, яруу найрагчид, философчид, зөнч нар болон төрийн зүтгэлтэнгүүд байсан. Тэдний зарим нь маш өндөр боловсролтой байсан бол тэдний дунд сургуульд сураагүй загасчид ч мөн байсан.

Хуучин Гэрээ нь дараах 39 номноос бүрддэг.

Хууль	5 ном
Түүхийн	12 ном
Утга уран зохиолын	5 ном
Зөгнөлийн	17 ном (гол-5 ном+туслах-12 ном)

Шинэ Гэрээ нь 27 номноос бүрдсэн ба эдгээр нь 4 группэд хуваагддаг.

Сайн Мэдээ	4 ном
Анхны сүмүүдийн түүх	1 ном
Илгээмж буюу (захианууд)	21 ном
Зөгнөл	1 ном

Библи бол хүн төрлөхтний түүхэн дэх хамгийн агуу бүтээл юм. Тиймээс энэ номыг уншиж, судлаж, итгэж дагах хэрэгтэй.

ХУУЧИН ГЭРЭЭНИЙ НОМНУУД

2-р Хичээл - ЭХЛЭЛ

Библийн эхний таван номыг Мосе бичсэн ба эдгээр нь Хуйлмал номнууд гэж нэрлэгддэг. “Эхлэл” гэдэг нь гарал үүсэл буюу төрөлт гэсэн утгатай. Эхлэл ном нь аливаа зүйлийн анхдагч ном юм - дэлхий ертөнцийн эхлэл (1:1-25), хүний гарал үүсэл (1:26-27), дэлхийн гэм нүгэл (3:1-7), авралын тухай амлалтууд (3:8-24), гэр бүлийн амьдрал (4:1-15), хүний бүтээсэн иргэншил (4:16-9:29), дэлхийн үндэстнүүд (10-11-р бүлгүүд), болон Еврейчүүд (12-50-р бүлгүүд).

Эхлэл ном нь хүн төрлөхтний уналтын түүхийг өгүүлдэг. “Бурхантай” хамт эхэлсэн ч “үхлээр” дуусдаг. Энэ номыг 2 үндсэн хэсэгт хувааж болно:

А. Гэм нүглийн эхлэл, 1-11-р бүлгүүд

1. Бүтээл, 1-2-р бүлгүүд.
2. Уналт, 3-4-р бүлгүүд.
3. Үер, 5-9-р бүлгүүд.
4. Бабел цамхаг болон хэлүүд худтгалдсан, 10-11-р бүлгүүд.

Б. Аврагчийн ирэх замыг бэлдсэн нь - 12-50-р бүлгүүд.

1. Абрам, итгэлийн хүн, 12-23 бүлгүүд.
2. Исаак, хайрлагдсан хүү, 24-26-р бүлгүүд.
3. Иаков, хайрлагдсан ч Эзнээр сахилгажуулагдсан, 27-36-р бүлэг.
4. Иосеф, ах нар нь худалдаж, шоронд зовсон ч Бурханд үнэнч байсан, 37-50-р бүлэг.

3-р Хичээл - ГЭТЛЭЛ

Гэтлэл гэдэг нь “гарах зам” гэсэн утгатай. Тэд ердөө далуулаа Египетэд очсон бол Египетээс гарахдаа гурван сая хүнтэй үндэстэн болоод гардаг. Эхлэл номонд хүмүүсийн уналтын тухай өгүүлдэг бол Гэтлэл номонд Агуу Хүчит Бурханы авралын хүчийг харуулдаг. Эхлэл нь гунигтай ч сүр жавхлантайгаар дуусдаг.

Гэтлэл 12-р бүлэг дээр Алагсал баярын түүх гардаг. Энэ түүх нь бидний хувь хүний итгэл аврал нь Эзэн Есүс Христийн цусаар бидэнд ирдэгтэй адил зураглал юм.

Гэтлэл номын тойм:

1. Бурхан Мосе-г чөлөөлөгч болгон бэлддэг, 1-11-р бүлэг.
2. Цусаар болон хүчээр чөлөөлөгдөх нь, 12-14-р бүлэг.
3. Синай уул руу алхсан хүмүүсийн сүнслэг сургалт, 15-18-р бүлэг.
4. Хууль бидний гэмтэй байдлийг харуулах Бурханий толь болсон, 19-24-р бүлэг.
5. Бурхан өөрийн хүмүүсийн дунд байгааг гэрчлэх асар босгосон, 25-40-р бүлгүүд.

4-р Хичээл - ЛЕВИ, ТООЛЛОГО, ДЭД ХУУЛЬ

Леви ном нь Бурхан Израйлийн хүүхдүүдэд итгэл үнэмшлийн тухай заасан ном. Гол санаа нь Есүс Христийн хийх зүйлд хандсан ба энэ номыг “Зөвт байдлын” ном гэж нэрлэдэг. Энэ ном нь эвлэрлийн өргөлүүдээр дамжин зөвт байдлыг авах тухай өгүүлдэг. Таван төрлийн тахил ба эдгээрт: шатаалт тахил, идээн өргөл, эвийн тахил, нүглийн тахил, нөхөн төлбөрийн тахил ордог. Тослон томилох ёслолууд нь бүгд “Зөвт Байхын” төлөө юм. Нийт найман төрлийн баярын өдрүүд байдаг. Үүнд Амралтын өдөр, Алгасал, Исгээгүй талхны баяр, Бүрээдэлтийн өдөр, Эвлэрлүүлгийн өдөр, Майхан баяр, Амралтын жил, Эвэр бүрээдэлтийн жил. Тахилууд нь цусаар аврагддаг гэдгийг тунхагласан бол баярууд нь хоол хүнсээр дамжин авралаа хадгалах гэсэн утгатай.

Тооллого ном нь Синайн цөлөөс амлагдсан Канаан нутаг хүртэл Цөлийн Замаар туулсан тухай өгүүлдэг. Энэ номыг Гонгинож өнгөрүүлсэн он жилүүд гэж нэрлэсэн ч болно. Гол санаа нь сахилгажуулалт. Тооллого ном нь итгэлийн амьдралын тухай өгүүлдэг.

1-16-р бүлэгт тэнгэрлэг хууль тогтоомжын тухай гардаг.

17-30-р бүлэгт үндэстэн хэрхэн бүтэлгүйтсэн тухай гардаг.

31-36-р бүлэгт Израйлчууд цөлд байхдаа хэрхэн Яавэ Бурхан руу эргэн Түүний таалалыг олж ялалтанд хүрсэн тухай гардаг.

Тооллого номын гол баатрууд бол Мосэ, Аароон, Мириам, Иошуа болон Калев.

Дэд хууль ном нь Санан Дурсах ном юм. Энэ номонд олон илтгэл, Мосе Израйлчуудад хандан хэлсэн эцсийн дуунууд багтдаг. Энэ номонд дуулгавартай байхын ивээл болон дуулгаваргүй байдлаас ирдэг хараалын тухай гардаг. Энэ номонд Мосегээс салах ёс хийх 30 өдрийг оруулаад ердөө хоёр сар болсон үйл явдлын тухай гардаг. Есүс Дэд хууль номноос олонтаа иш татсан. Есүс чөтгөрт соригдож байхдаа энэ номонд бичигдсэнээр хариулдаг. Дэд хууль номыг тэнгэрийн улсын газар дээрх тусгал гэж хэлж болно.

Хураангуй: Эхлэл номонд хүн гэмд унадаг; Гэтлэл номонд хүмүүст аврал ирдэг; Леви номонд тахил болон өргөлөөр хүндэлдэг; Тооллого номонд хүмүүс үйлчилдэг: Дэд хууль номонд хүмүүс дуулгавартай байж сурдаг.

5-р Хичээл - ИОШУА, ШҮҮГЧИД БОЛОН РҮТ

Иошуа ном бол Түүхийн тухай ном юм. Энэ ном сүнслэг үнэнээр, урам зоригоор болон мэргэн ухаанаар баялаг. Мосе өөд болсон ч тэд урагшаа явах ёстой үе байв. Иошуа Мосе-н дуусгаж чадаагүй ажлыг гүйцэлдүүлсэн. Энэ агуу удирдагчын тухай ном үндсэндээ 2 хэсэгт хуваагддаг:

1. Амласан газрыг эзлэн авсан тухай 2-р бүлэг
2. Амласан газарт амьдран суусан тухай 13-24-р бүлэг

Шүүгч номонд Израйлчуудын Хүнд Харанхуй үеийн тухай гардаг. (Шүүгч 2:13). Хүмүүс Бурханыг орхисон ба Бурхан бас хүмүүсийг хаясан үе. (2:23). Шүүгч номонд агуу удирдагч Иошуа-г өөд болсны дараа Саул Израйлын хаан ширээнд залрах үе хүртэлх түүхийг өгүүлдэг. Амлагдсан газарт амьдарсан эхний 350 жил тэд нэг ч хаан байхгүй байсан. Энэ номонд хүн бүр өөртөө юу зөв гэснээ үйлдэв гэсэн үг олонтаа давтагддаг. Энэ ном хүн төрөлхтний байнгын дуулгаваргүй байдал болон Бурханы дуусашгүй нигүүслийн тухай заадаг. Долоон ухралт, долоон боолчлол, долоон буруу урсгалт үндэстнүүд болон долоон удаагын чөлөөлөлтийн тухай гардаг.

Рүт ном Есүс Христийн тухай болон түүний Авралыг зүйрлэн өгүүлсэн ном юм. Шүүгч номонд гардаг түнэр харанхуй мэт номны дараа гэрэл цацруулан Есүс Христ болон сүм чуулганыг гэгээлэгээр зураглан харуулсан. Рүт ном Гидеон болон Иефта нарын удирдагч байсан үеийн тухай өгүүлдэг. Рүт нь Давидын элэнц эх Христийн өвөг дээдэс байсан. Энэ номонд Месаяагийн ирэх замын эхлэлийн тухай гардаг. Рүт нь Лотын удам болох Моаб гаралтай харь үндэстэн байсан боловч Бурхан нигүүслээрээ харь үндэстнүүдийг Христийн гэр бүлд үрчлэн авсан зураглалыг харуулсан түүх юм.

6-р Хичээл - НЭГ, ХОЁРДУГААР САМУЕЛ

Нэгдүгээр Самуел Хаадын тухай бичсэн зургаан номын эхний ном. Нийт гурван номоос бүрдсэн ба ном бүр нь 2 хэсэгтэй.

Нэгдүгээр Самуел номонд Самуелийг төрснөөс эхлээд Саул Хааны он жилүүд болон Давидын хаанчлал хүртэлх ойролцоогоор 115 жилийн хугацаанд болсон үйл явдлыг өгүүлдэг. Энэ номыг дүрүүдийн нэрээр 3 хэсэгт хувааж судлаж болно.

1. Бурханы зөнч Самуел, 1-7-р бүлэг.
2. Саул хаан Бурханд дуулгаваргүй хандан бүтэлгүйтсэн хэсэг, 8-15 -р бүлэг.
3. Бурханы хүн Давид 16-31-р бүлэг.

Хоёр дугаар Самуел - Нэгдүгээр Самуел номонд хүмүүсийн хаан болсон Саулын уналтын тухай өгүүлдэг бол хоёрдугаар Самуел номонд Мессаяа-н замыг бэлдэн “Давидын Гэрийг” босгон Бурханы томилсон Давид Хааны тухай гардаг. Давид бол Бурханы зүрх сэтгэлийг тээсэн нэгэн байсан ба хэдийгээр тэр төгс байгаагүй ч гэм нүглээ гэмшиж чаддаг байсан. Тэр маш олон талын чадвартай нэгэн байв -хоньчин хүү, сүмийн хөгжимчин, цэрэг, сайн найз, цөлөгдөгчдийн удирдагч, хаан, агуу генерал, яруу найрагч, гэм буруутан, сэтгэл нь эмтэрсэн настай хүн гэхдээ ямар ч үед Бурханыг хайрлагч байсан. Энэ номыг үндсэн хоёр хэсэгт хувааж болно.

1. Давидын мандаж явсан үе - 1-10-р бүлэг.
2. Давидын зовлонтой үе - 11-24-р бүлэг.

7-р Хичээл - НЭГ, ХОЁРДУГААР ХААД

Энэ ном нь Самуел номын үргэлжлэл. Хаант улс 400 жилийн хугацаанд хэрхэн дэвжсэн, задарсан болон хуваагдсан тухай гардаг. Өмнө зүгийн хаант улс болох Иуда 20 хаантай байсан бол хойд зүг болох Израйль 19 хаантай байв. Иуда болон Израйль аль аль нь олзлогддог. Энэ үед Бурханы дуу хоолой болох хүчирхэг зөнч Элиа шүүлтийн өдрийн талаар зөгнөдөг бол хоёрдугаар Хаад номонд Элиша нь Бурханы нигүүсэл болон нинжин сэтгэлийн талаар зөгнөдөг. Энэ номын гол агуулгыг дараах хэсэгт хувааж болно.

1. Давидын үхэл, 1 Хаад 1,2.
2. Соломоны хаанчланын оргил үе, 1 Хаад 3-11.
3. Хаант улсуудын хуваагдал, 1 Хаад 12-2, 16-р бүлэг.
4. Израйлчууд Ассирт олзлогдсон нь 2 Хаад 17.
5. Вавилоны хаанчлалыг унагааж боолчлолоос гарсан нь, 2 Хаад 18-25.

8-р Хичээл - НЭГ, ХОЁРДУГААР ШАСТИР

Шастирын номнууд нь Хаадын номонд гарсан үйл явдлуудыг арай өөр өнцгөөс харуулдаг. Хаадын номонд үндэстний түүхийг хаан ширээний өнцгөөс бичсэн бол Шастирын номонд сүмийн зүгээс илэрхийлсэн байдаг. Хаад номонд хааны өргөөнд болж байгаа үйл явдал гардаг бол Шастирын номонд сүмд болж байгаа үйл явдал чухал эзэлдэг. Хаад номонд улс төрд болж буй зүйлийг илүүд харуулсан бол Шастир номонд шашинлаг үйл явдлыг онцлон харуулсан. Хаад ном нь хүний үзэл бодлыг тусгасан байдаг бол Шастир номонд Бурханы байр суурийг голчлодог. Шастирын хоёр ном нь таван гайхалтай сэргэлтийн тухай бичсэн. эдгээр нь: Ассирын боолчлолд байсан үе, 15-р бүлэг, Иехошафат, 20-р бүлэг, Иоаш 23-25-р бүлэг, Хезекиа, 29-31-р бүлэг, Иосиа 35-р бүлэг.

1 Шастирын номын хураангуй:

- 1 Уг гарал удам судлал, 1-9-р бүлэг.
- 2 Саулын хаанчлал, 10-р бүлэг.
- 3 Давидын хаанчлал, 11-29-р бүлэг.

2 Шастирын номын хураангуй:

- 1 Соломоны хаанчлал, 1-9-р бүлэг.
- 2 Иудагын хаант улсын түүх ба уналт, 10-36-р бүлэг.

9-р Хичээл - ЕЗРА, НЕХЕМИА, ЕСТЕР

Езра болон Нехемиа номонд Бурханы сонгосон ард түмэн Вавилионоос гарсны дараа Бурхан руу эргэн ирж байгаа тухай гардаг. Езра тахилч хүн байсан бол Нехемиа жирийн нэгэн байсан. Израйлчуудын эхний гэтлэл нь Египетийн дарлалаас Мосегээр удирдуулж гарч байсан бол хоёр дахь гэтлэл нь **Езрагаар** удирдуулсан Вавилионы боолчлолоос гарах байсан юм. Езра Иерусалимд хүрч ирэх үед зарим еврейчүүд түрүүлж ирээд харийнхантай ураглаж, нутгийн хүмүүсийн тэдэнд заасан жигшүүрт зүйлийг хийж (9:1-4) байгааг харсан Езра маш их гуниглан залбирахад (9:5-15); хүмүүс түүн дээр цуглан ирж гашуунаар уйлцгаадаг. (10:1-44). Езра Израйлчуудыг Бурхантай гэрээ хийлгэн удирдсан.

Нехемиа Езра-г өнгөрснөөс 13 жилийн дараа Израйлд ирдэг. Тэр Пэрсиа хааны зөвшөөрлөөр Иерусалемийн нурсан хэрэм ханыг барихаар ирдэг. Хэдийгээр маш их саад байсан ч тэр бол мундаг инженер байсан ба ханыг 52 хоногын дотор барьж дуусгасан.

Энэ хоёр номын хураангуй.

- 1 Вавилионоос Зеруббабэл-р удирдуулан ирсэн хэсэг, Езра 1-6.

- 2 Вавилионоос Езра-р удирдуулан ирсэн хэсэг, Езра 7-10.
- 3 Ханыг ахин босгосон хэсэг Нех 1-7
- 4 Сэргэлт бол өөрчлөлт Нех 8-13.

Естер - энэ номонд Бурханы нэр дурдагддаггүй ч хуудас бүрийн үг бүрийн цаана Бурхан нуугдсан байдаг. Естер ном Бурхан хангадаг тухай заадаг. Бурхан бол энэ дэлхийн жолоо баригч. Энэ номын гол санаанууд дараах гурван хэсэгт хуваагддаг:

- 1 Ахашверош, Пэрс хаадуудадын таалалд Вашти үл нийцсэн нь Мордехайд өөрийн өсгөсөн өнчин залуу эмэгтэй Естерийг Ахашверош-д сонордуулж хатан болгодог, 1-2-р бүлэг.
- 2 Естер муу санаат Хаманы тухай хаанд хэлснээр Хаман үхэх болж оронд нь Мордехай сонгогддог. 7-8-р бүлэг.
- 3 Еврейчүүд аймшигтай аюулаас ангирсанаа тэмдэглэн Пурим баярыг хийсэн 9-р бүлэг.

10-р Хичээл - ИОВ

Иов ном нь шүлэглэн бичсэн таван номын анхны ном. Эдгээр номнууд нь сэтгэл зүрхний гүндэх зүйлийн талаар өгүүлдэг. Иов ном нь Библийн хамгийн хуучин номны тоонд ордог. Энэ номонд “Бурханлаг хүмүүс яагаад зовлон амсдаг вэ?” гэсэн асуултанд Бурхан хэрхэн хариулдаг тухай гардаг. Номын эхэнд тэнгэрт болж байгаа үйл явдлыг харуулдаг бол дараа хэсэгт Иовын амьдрал сайн сайхан байдлаас гэнэтийн ядууралд орсон тухай бичсэн.

Түүх Иов болон түүний найзуудын харилцан ярианы тухай гардаг.

- 1 Түүх тэнгэрт болж байгаа үйл явдлаар эхэлдэг. 1 бүлэг 1-12.
- 2 Иовын амьдрал элбэг хангалуун байдлаас ядууралд орсон үе. 1-р бүлэг 13-22; 2-р бүлэг 7-10.
- 3 Иов болон түүний найзууд болох Элифаз, Билдад, Зофар, Элиху. 2- бүлэг 11-37; 24.
- 4 Оргил үе буюу Эзэн түүнд хариулж эхэлдэг. Бурхан Иовд бид Яавэг ширтэн харсаар байвал ямар нэг зүйл заавал болдог гэдгийг харуулдаг. Бурханлаг хүн ч зовж болно тэгснээрээ тэд хэн бэ гэдгээ мэдрэх үед Бурхан тэднийг өргөмжилдөг. Бидний зовлон бэрхшээл бүрийн ард зорилго байдаг ба тэр биднийг цэвэр алт мэт галаар цэвэршүүлдэг.

11-р Хичээл - ДУУЛАЛ

Дуулал ном нь магтаал, залбирал болон хүндлэлийн тухай ном. Дуулал ном Эзнийг өндөрт өргөмжлөн магтдаг. Хүний амьдралд болж байгаа бүхэн Түүнтэй хамаатай.

Итгэгч хүний амьдралд тохиолддог баяр хөөр, гуниг зовлон, ялалт болон ялагдлыг тусган харуулсан. Дуулал ном нь Христийн амьдралыг дүрслэн харуулсан ба үхэл хүртэлх туулсан замын тусгал болсон гэж хэлж болно. Дуулал номыг хуулийн таван номын хураангуй ном гэхэд болно.

- 1 Эхлэл хэсэг- хүмүүсийн ивээлээр дүүрэн өдрүүд болон уналт ба сэргэлт, Дуулал 1-41.
- 2 Гэтлэл хэсэг- Израйлчуудын сүйрэл ба сэргэлт, Дуулал 42-72.
- 3 Левитийн хэсэг - Бурхан бол харанхуйд ч үүр цайгад ч бидний орших дугана юм гэдгийг дүрслэдэг, Дуулал 73-89.
- 4 Тооллого хэсэг - энэ хэсэгт газар дэлхийн тухай болон түүнд оршх аюул болон хамгаалалтын тухай өгүүлдэг. Дуулал 90-106.
- 5 Дэд хуулийн хэсэг - эдгээр бүлгүүд нь Бурханы үгийн төгс төгөлдөр байдлыг магтан биширсэн байдаг. Дуулал 107-150.

12-р Хичээл

СУРГААЛТ ҮГС, НОМЛОГЧЫН ҮГ, СОЛОМОНЫ ДУУН

Соломон хаан нь мэргэн ухаан ба эд баялагаараа алдартай агуу хаан байсан. Тэрээр 3000 сургаалт үгс, 1005 дууны зохиогч. (1Хаад 4:31-32). Соломон нь философич, шинлэх ухаанч, дэлхийн хамгийн гайхалтай сүмийн уран барилгач болон хаан байсан. Сургаалт үгс ном нь мэргэн үгсээр баялаг ном юм. Уг номыг дараах хэсэгт хувааж болно:

- 1 Залуучуудад хандсан зөвөлгөө, 1-10-р бүлэг.
- 2 Бүх эрчүүдэд хандсан зөвөлгөө, 11-20-р бүлэг.
- 3 Хаад болон удирдагчид хандсан зөвөлгөө, 21-31-р бүлэг.

Номлогчын үгс ном нь хүмүүсийн өөрсдийн үзэл бодол болон шашины зүгээс амьдралын зорилго, утга учрыг тодорхойлох гэж бичсэн тэмдэглэл юм. Энэ номонд байгаа дүгнэлт нь Бурханаас ирсэн тайлбар биш хүмүүсийн дүгнэлтийг тэмдэглэсэн Бурханы тэмдэглэл юм. Энэ номыг Соломон өөрөө Бурханаас хол байх үедээ бичсэн анхаарал татахуйц намтар. Соломон мэргэн нэгэн байсан боловч байнга ухаалаг байж чадаагүй. Гол санаа нь “тэнгэрийн доорх бүх юм” “утгагүй” гэдгийг онцолсон.

Соломоны дуун бол итгэгч хайрын дуунууд. Энэ номонд дөрвөн чухал утгыг агуулдаг.

- 1 Сүйт бүсгүйн тухай дуун
- 2 Яавэгийн Израйлд хандсан хайрын илэрхийлэл
- 3 Христ болон Чуулганы зураглал
- 4 Христ болон итгэгч хүмүүсийн холбоог харуулсан

Хамгийн агуу тушаал нь юу вэ гэж асуухад Есүс тэдэнд: Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрла” гэсэн нь юм. “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү агуу өөр тушаал байхгүй гэлээ. (Марк 12:30, 31).

13-р Хичээл - ИСАИА

Энэ ном зөгнөлийн 17 номын анхны ном. Израйлийн түүхэнд тохиосон хүнд хэцүү үед Бурхан зөнч нарыг гаргаж ирсэн. Зөнч нар Бурханаас Өөрийн хүмүүст өгсөн үгийг дамжуулагчид байв. Манай эрний өмнөх 9-4-р зууны үед 500 жилийн турш байсан зөнч нарын тухай гардаг. Эдгээр зөнч нар хаадуудад болон хүмүүст тэдний гэм нүглийг сануулж зоригтойгоор ярьдаг байв. Исаиа хоёр чухал зүйлийн тухай бичсэн. Номын эхний хэсэгт Израйлийн тухай гардаг бол сүүл хэсэгт Есүс хэрхэн бидний гэмийг үүрэх ба Христ хэрхэн өндөрт өргөгдөж алдаршуулагдах тухай гардаг.

Исаиа номыг бяцхан библи гэж хэлж болно. Библи 66 номтой бол Исаяа ном 66 бүлэгтэй. Үндсэндээ хоёр хэсэгт хуваагддаг. Библи Шинэ Хуучин Гэрээ гэсэн хоёр хэсэгтэй. Энэ номыг “Исаиагийн Сайн Мэдээ” гэж нэрлэдэг. Христийн онгон төрөлт, Түүний зан, Түүний амьдрал, Түүний үхэл, дахим амилалт, Түүний дахин ирэлт бүгд маш тодоор зөгнөгдсөн байдаг.

14-р Хичээл - ИЕРЕМИА, БОЛОН ГАШУУДАЛ

Иеремиа-г “нулимстай зөнч” гэдэг. Түүнд ирсэн зөгнөлүүд сэтгэлийг нь их зовоосон. Тэдгээр зөгнөлүүд бусдын сонсохыг хүсээгүй үгнүүд байсан. Тэр ард түмэнд хандан Вавилоны хаан цэргийн ахмадууд уруу гарч оч гэж хэлсэн болохоор хүмүүс түүнийг урвагч гэж үзсэн. Израйлчууд нэг л зүйлийг хийх хэрэгтэй байсан ба тэр нь бууж өгөх. Учир нь Даниелийн үзэгдэлд байсан алтан толгой буюу “Харь Үндэстнүүдийн үе” Вавилонд аль хэдийн эхэлсэн байв.

Иеремиа Израйлчууд Вавилоны дарлалд 70 жил боолчлогдоно гэдгийг таамагласан. (25-р бүлэг 9-12). Гэвч тийм харанхуй үеийн дараа гэрэл гэгээтэй үе байгаа гэдгийг маш зоригтойгоор тунхагласан зөнч байсан. (23-р бүлэг 3-8, 30; 33-р бүлэг 15-22). Иеремиа Яавэгаас ирсэн үгийг янз бүрийн зүйрлэлээр хүмүүст хүргэдэг байв. Түүний зөгнөлд хүмүүс дургүй байгаад зогсохгүй үл тоон түүнийг эсэргүүцэгчид түүний амийг авахыг оролдсон.

Тиймээс **Иеремиа Гашуудал** номыг бичсэн гэсэн таамаглал байдаг ч таван шүлэгнээс бүрдсэн энэ ном нь тэр чигтээ уй гашуудал гардаггүй. Хүмүүсийн гэм нүглийг харсан зохиогчийн сэтгэл гашуудаж байсан ч Бурханы нар тэдний дээр гэрэлтдэг гэдэг санааг хэлдэг.

15- р Хичээл - ЕЗЕКИЕЛ

Езекиел нь Вавилионы боолчлолын үеийн зөнч байсан. Езекиел израйлчуудыг Палистийнд удахгүй эргэж очно гэсэн хий хоосон найдлагаа хаяж тэдний хайртай Ирусалемд болох аймшигт зүйлсийн талаар хэлэхийг хичээдэг. Түүний зөгнөлүүд нь Бурханий мөн чанрын тухай маш сүнслэг утга агуулагатай байв. Тухайн үндэстний хамгийн харанхуй цаг үеийн тухай зөгнөсөн байдаг. Хүмүүс түүнийг болон хэлэх үгийг нь тоогоогүй тул өөрөөр буюу сургаалт зүйрлэлээр ярьж эхэлсэн. (24-р бүлэг 24 иш). Езекиел голдуу Бурханы алдрын тухай зөгнөсөн. Ирусалемийн сүйрлийн тухай голчлон өгүүлсэн энэ номыг дараах хэсэгт хувааж болно.

- 1 Бүслэлтийн өмнөх үе. Езекиел Ирусалемийг сүйрэхээс 6 жилийн өмнөөс сүйрэл болох өдөр хүртэл зөгнөсөн 1-24-р бүлэг.
- 2 Бүслэлт - түүний дараа энд гарсан зөгнөлүүд нь Иудагийн дайснуудын талаар болон харь үндэстнийг түлхэн унагаах тухай зөгнөдөг 25-32-р бүлэг.

- 3 Бүслэлтийн дараах үе. Эцэст нь Иудагийн сэргэлт болон ахин босголт болдог 33-48-р бүлэг.

16-р Хичээл - ДАНИЕЛ

Даниел номонд Бурхан олон нууцуудыг илчлэн харуулсан болхоор Даниелийг мөрөөдлийн зөнч гэж дуудаг. Тэр маш холыг харж чадсан ба Илчлэл номонд олон удаа иш татагдсан. Түүний амьдрал үйлчлэлд 70 гаруй жил багтдаг. Тэрээр 16 настай байхдаа олзлогдсон боловч 90 гаран насалсан. Хэдийгээр тэр олзлогдсон нэгэн боловч Вавилионы ёрөнхий сайд хүртлээ дэвшдэг. Хамгийн биширмээр зүйл гэвэл Даниел Яавэ Бурханд үргэлж үнэнч байсан.

Даниел номын тойм:

1. Даниелийн хувийн амьдрал, 1-р бүлэг 1-3, 3-р бүлэг.
2. Даниелийн олны өмнөх амьдрал - Харь үндэстнүүд дунд байсан үеийн дүр зураглал, 2-р бүлэг 4; 7-р бүлэг 28.
3. Даниелийн үзэгдлүүд - Үзэгдэлүүд ба үндэстний түүх, 8-12-р бүлэг.

17-р Хичээл ХОСЕА, ИОЕЛ, АМОС

Хосеа нь богино хэмжээний зөгнөлүүдээс бүрдсэн 12 номын эхний ном. Хосеа нь аврал гэсэн утгатай ба түүнийг хойд хант улсын зөнч гэж дууддаг. Тэр эгэл жирийн нэгэн боловч Бурхан Израйлыг хайрладаг тухай чухал үгийг дамжуулагч байсан. Хосеа Харлоттой гэр бүл болох үүргийг аваад түүнээс хоёр хүү нэг охинтой болдог. Гэвч Харлот садар самуун явдалд орсонд Хосеа түүнийг гэрээсээ хөөх үед Бурхан түүнийг хайрлаж буцаан гэртээ авчир гэсэн тушаал өгсөн. Гол санаа нь Израйль Бурханд итгэмжгүй хандсанд ч Бурхан тэднийг хайрласан хэвээрээ ба Түүн дээр буцан ирэхийг хүлээдэг гэсэн утгатай.

Хосеа номын тойм:

- 1 Зөнч ба түүний итгэмжит эхнэр, Гомер, 1-3-р бүлэг.
- 2 Эзэн ба итгэмжгүй үндэстэн, Израйль, 4-14-р бүлэг.

Иоел нь Иудагийн зөнч байсан ба үлэг гүрвэлийн тахал гарсан гамшиг болж байх үед бичигдсэн. Тэр энэ үеийг шүүлтийн үетэй зүйрлүүлдэг. Тэрээр Эзний Өдөр буюу шүүлтийн өдрийн тухай таван удаа дурдсан. Иоел номын гол санаа нь сүнслэг чөлөөлөлтийн тухай юм. Бурхан өөрийн сүнсийг бүхий л бие махбоди дээр асгах тухай үгийг дамжуулах онцгой үүрэг өгөгдсөн. Түүний зөгнөл нь (Үйлс 2-16) дээр биелэлээ олдог.

Амос малчин хүн байсан ба түүний зөгнөлүүд хойд зүгийн хант улсуудаад хандан өгөгдсөн. Түүний зөгнөлийн гол санаа нь Израйлчууд шашинлаг хоёр нүүр гаргаж байгаа болон ядууст шудрага бусаар хандсан тухай юм. (Амос 5:21-27). Амосоор дамжуулан Бурхан Израйлчуудийг “зөвт байдал нь гол мэт тасралтгүй урссан чин сэтгэлийн мөргөл рүү дууддаг”.

18-р Хичээл - ОБАДИА, ИОНА БОЛОН МИКА

Обадиа ном нь Хуучин гэрээний хамгийн богинохон ном ба нийт 21 ишлэлээс бүрддэг энэ ном өнөөдөр ч чухал үүрэгтэй. Едомын эсрэг шүүлт ирж байгаа тухай хоёр гол санааг илэрхийлдэг. Бардам дураараа хүмүүсийн шийтгэл ба номхон даруу хүмүүсийн авралын тухай өгүүлдэг. Едомчууд Есавын ууган хүүгийн эрхийг булаан Израйлын дайсан болдог. Обадиагын зөгнөснөөр тэр газар устгагддаг.

Обадиа бусад зөнчийн адил Мессиагийн хаант улс бий болох тухай болон Эзний ирэх өдрийг зөгнөн хэлсэн байдаг.

Иона хэдийгээг зөнч байсан ч энэ номонд зөгнөл гардаггүй. Харин Ионагын амьдралд болсон үйл явдлын тухай бичсэн ба энэ үйл явдал нь түүхэнд болох Есүс Христийн дахин амилалтын талаарх агуу үйл явдлын тэмдэг болдгоороо онцлогтой. Энэ номонд Бурхан 4 зүйлийг бэлддэг.; аврага загас (1:17), бут (4:6), хорхой (4:7) болон дорнын халуун салхи (4:8). Бурхан өөрийн зөнчийг анхаарч халамж тавьсан.

Энэ номонд хоёр чухал үйл явдал. Нэг нь Иона аврага загасны аманд ордог бол нөгөө нь Ниневечүүд хэдхэн өдрийн дотор гадны миссионеруудын үгэнд орж хувирдаг.

Энэ номноос хоёр зүйрлэлийг ажиглаж болно. Нэгт, Иона нь Христ адил үхэлд тушаагдаж, живсэн ч дахин амилдаг. Хоёрт, Иона Израйлчууд шиг Бурханд дуулгаваргүй зан гаргаж газар дээрх үндэстнүүдэд залгигдаж Христийг ирэх хүртэл бууж өгөөгүй тул Израиль хаа сайгүй Бурханыг гэрчлэгч болох юм.

Мика ном нь Иерусалем болон Израйль дээр ирэх шүүлтийн тухай зөгнөсөн ч итгэл найдвар бий гэдгийг сануулсаар байсан. Микагийн гол зөгнөл нь намайг сонс гэсэн үгийг дараах гурван бүлэг хүмүүст хэлдэг.

- 1 Эхний удаа бүх хүмүүст хандаж хэлсэн байдаг (1:2).
- 2 Хоёрдахь удаа Израйль болон тэдний удирдагч нарт хандаж хэлдэг (3:1).
- 3 Гуравдахь нь Израйлчуудыг гэмшиж Бурхан руу эргэ хэмээн хувиасаа өчин хэлсэн хэсэг (6:1).

19-р Хичээл - НАХУМ, ХАБАККУК БОЛОН ЗЕФАНИЯ

Нахум номын гол санаа нь Ионагийн хэлснээр Ниневагийн сүйрэл болох тухай гардаг. Ионагийн сэргэлтийн өдрүүдээс 150 жилийн дараа Нахум ном бичигдсэн.

Гэмшил нь удаан үргэлжлээгүй тул Ниневе өөрсдийн гэм нүглээс болж устгагддаг. (Нахум 3:1-7).

Хабаккук нь асуулт хариултаар дүүрэн ном. “Гэм нүгэлтнүүд яагаад дэвжин дээшилдэг вэ” гэдэг талаар бичсэн. Өөрт нь хэцүү байсан ч тэр Бурханы өмнө залбирлаар очин хариултыг тэвчээртэйгээр хүлээдэг. (2:1). Чин сэтгэлээсээ залбирсны эцэст Бурханы алдар түүнд харагддаг. (3:1-16).

“Зөвт хүн итгэлээр амьдрана” гэсэн үг (2:4) үг Протестант урсгалд маш чухал ойлголт. Эдгээр үг нь Шинэ Гэрээний Ром номын 1:17, Галат 3:11 болон Евреи 10-38-д гардаг.

Зефаниа номонд Бурханы уур хилэн болон шүүлтийн тухай гардаг ч Бурханы хайрын тухай сануулдаг. Зефаниа янз бүрийн буруу шүтээнүүдийг буруутгасан. Тэр Иосагийн сэргэлтийн замыг бэлдсэн гэхэд болно. (Зефаниа 1:15; 3:8).

Номын эхэнд уй гашуу гардаг бол дуу хуураар төгсдөг.

20-р Хичээл - ХАГГАЙ, ЗЕХАРИА БОЛОН МАЛАХИ

Хуучин гэрээний зөнч нар боолчлолд орохоос өмнөх цаг үеийн тухай зөгнөдөг. Тэдний дундаас Езекиел ба Даниел хоёр л боолчлолын үед гарч ирсэн зөнчид. Хаггай, Зехариа болон Малахи нар бол чөлөөлөгдсний дараах цаг үеийн зөнчид.

Хаггай номны гол санаа нь Эзэний өргөөг дахин сэргээж босгох тухай юм. Хүмүүс Эзэний Өргөөг удаан босгож байгааг зэмлэн тэднийг дэмжиж тусалдаг. Дөрвөн сарын турш бичигдсэн энэ номын гол санаа нь тэр хүмүүсийг энэ ажилд уриалан дуудсанд хүмүүс нэгдэж Эзэний өргөөг барьж эхэлдэг. (Хаггай -12-15).

Зехариа нь залуу зөнч байсан ба нас өндөр болсон Хаггайтай хамт Израйлийн хүүхдүүдийг Эзэний өргөөг барихад хүчирхэгжүүлж, тэдний өвөг дээдсийн адил Бурханыг гомдоохгүй байх тухай сануулдаг. Израйлийн дээр буух ивээлийн талаарх гэрэл гэгээтэй үзэгдлийг харсан зөнч. Исаиагаас гадна Аврагчийн тухай олонтаа зөгнөсөн зөнчийн нэг бол Зехариа. Олон жилийн дараа Христ хэрхэн зовж, цовдлогдож, дахин амилан алдарт хүрэх талаарх үзэгдлийг тэр авсан.

Малахи бол Хуучин болон Шинэ гэрээний гүүр ном. Малахи номноос хойш 400 жил өнгөрч Иохан баптистийн Эзний замыг бэлдэгтүн гэсэн дуу хоолой гарч ирдэг.

Хуучин Гэрээ “хараалаар” төгсдөг бол Шинэ Гэрээ нь ивээлээр дуусдаг. Сэргэлтийн үеэс хойш, (Нех 10:28-39) хүмүүс сүнсний хувьд хөрч ёс суртахуунгүй эмх замбараагүй болсон үе. Малахи шинэчлэлийг авчирсан ба хэдийгээр тэр зэмлэж байсан ч бас урамшуулж чадсан.

Малахи мөн Христийн дахин ирэлтийн талаар хүчтэй тунхагласан байдаг. (3:16-4:3).

ШИНЭ ГЭРЭЭНИЙ НОМНУУД

21-р Хичээл - САЙН МЭДЭЭНИЙ ТАНИЛЦУУЛАГА

“Госпел” гэдэг нь “сайн мэдээ” гэсэн утгатай. Эдгээрийг бичсэн дөрвөн зохиогч нь авралын зар тараагчид буюу сайн зүйлсийг түгээгч нар гэгддэг.

Матай, Марк, болон Лүк номыг товчоор сайн мэдээний ном гэж нэрлэдэг ба эдгээр номнууд нь Христийн амьдралын түүхийг хураангуйлан бичсэн байдгаараа Иоханы номноос ялгаатай.

Сайн мэдээний хураангуй номнууд нь Христийн Галилд хийсэн үйлчлэлийн талаар мөн Иохан Иуда-д болсон явдлуудын талаар гардаг. Эдгээр номнууд нь Түүний хийсэн гайхамшигууд, сургаалт зүйрлэл болон олон түмэнд хандсан сургаалуудыг агуулдаг бол Иохан арай гүн утгатай ба түүний залбирал харилцан ярианы тухай гардаг. Эхний гурван номонд Христийн хийсэн ажлуудын тухай бичигдсэн бол Иохан Түүний сүнслэг дотоод амьдралын талаар илүү тод бичсэн.

Хуучин гэрээний зөнч нар бүгд Христ энэ дэлхий дээр ирж хийх ажлыг зөгнөсөн байдаг бол эдгээр захидлууд нь тэр юуны төлөө ирсэн яагаад ирсэн тухай тайлбарладаг.

Сайн мэдээний номнууд нь Христ хэзээ хэрхэн ирсэн тухай бичсэн бол захидлууд нь яагаад ирсэн болон юуны төлөө ирсэн гэдэг талаар бичсэн.

22-р Хичээл - МАТАЙ

Матай ном Есүс бол Хаан гэдгийг Еврей хүмүүст зориулж бичигдсэн Абрахамын удам, Давидын удмаас гаралтай угын бичиг энэ номын нэгдүгээр бүлэгт гардаг. Христ нь Мессиа ирнэ гэсэн зөгнөлийн биелэл болж ирсэн тухай болон Хуучин Гэрээнээс хамгын олон удаа буюу 29 удаа иш татсан сайн мэдээний номонд ордог.

Есүс Матайг сонгох үед тэр Ромын хуулийн дагуу Капернаум-д татвар цуглуулагч байсан. (9:9; 10:3). Сайн мэдээний бусад номонд тэрээр Есүст зориулан найр хийсэн явдлаас харахад нилээн эд хөрөнгөтэй нэгэн байсан ч тэр бүхнээ орхиод Есүсийг дагадаг.

Матай ном нь Бурханы тосолсон Нэгэн бопох Аврагчын тухай сайн мэдээний ном. Энэ номын гол санаа нь Мосе болон олон зөнчдийн зөгнөсөн Назарын Есүс бол Аврагч гэдгийг харуулдаг. Зөвхөн Матай номонд дорно зүгээс ирсэн мэргэдийн айлчлалын тухай бичсэн байдаг.

Уулан дээр номлосон сургаалууд нь Хаант Улсын үндсэн зарчмыг зааж сургасан ба Матай номонд хаант улс гэдэг үг 55 удаа давтагддаг тиймээс энэ бол Хааны тухай сайн мэдээний ном юм.

Матай 24-25-р бүлэгүүд Есүсийн дахин ирэх тухай өгүүлдэг. Есүс дээшээ өргөгдсөн тухай Матай номонд гардаггүй. Аврагч дэлхий дээр байх үед сүмийн хөшиг урагддаг нь Давидын хүүгийн хаанчлал дуусаагүй байгаагийн илэрхийлэл болдог.

23-р Хичээл - МАРК

Марк Есүсийг үйлчлэгч нэгэн гэдгийг онцлон харуулдаг. Ромчуудад хандсан бичихдээ ургын бичгийг оруулаагүй. Яагаад? Учир нь хэн ч боол үйлчлэгчийн удам угсааг сонирхдоггүй.

Энэ номыг Барнабасын үеэл, Маригийн хүү Жонн Марк бичсэн. Тэрээр Паул Барнабас хоёртой Антиох ордог ба тэдний дунд үүссэн маргааны эзэн болдог. (Үйлс 12:25; 13:5). Тун удалгүй хүнд байдлаас болж тэр тэднийг орхин явдаг. (Үйлс 13:13). Гэвч тэр Паулд их тус болдог. (Кол 4:10) Петр түүний итгэл рүү иргэхэд нөлөөлсөн ба Маркийг миний хүү гэж хэлсэн байдаг. (1 Петер 5:13). Сайн мэдээний энэ номонд Петрийн нөлөө нилээд байсан.

Энэ ном богинохон боловч адал явдал ололт амжилтаар дүүрэн. Марк энэ номоо Ром хотын Ромчуудад зориулан бичсэн. Тэд маш завгүй хүмүүс байсан ба эрх мэдэл болон хөл хөдөлгөөнтэй байдалд дуртай байв. Тэдний хувьд үгээр ярихаас илүү үйлдлээр харуулах нь чухал байсан. Хуучин Гэрээний цөөн хэдэн ишлэлээс иш татсан. Ердөө дөрвөн сургаалт зүйрлэл гардаг. Урт удаан оршил байхгүй, “даруйхан”, “шулууухан” болон “удалгүй” гэсэн үгнүүд 40 удаа давтагдсан. Марк номонд 20 гайхамшгийн тухай гардаг.

24-р Хичээл - ЛУК

Лук номонд Есүсийг төгс нэгэн гэдгээр илүү харуулдаг. Грек хүмүүст зориулан бичсэн тул ургын бичиг нь Абрахамын үеэс биш Адамаас эхэлдэг. Төгс хүн гэдэг утгаараа Есүс залбирч байгаа болон, элч нар Түүнд үйлчилж байгаа тухай гардаг.

Лук өөрөө эмч хүн байсан ба Паултай найз байсан. Тэрээр Шинэ Гэрээний номыг бичсэн ганцхан харь хүний нэг. Тэр маш боловсролтой хянуур нямбай нэгэн байсан. Лук мөн Үйлс номыг бичсэн. Лук Есүсийг төгс нэгэн байсан гэдгээр харуулдаг.

Сайн мэдээний энэ ном нь гэмтнүүдэд хандсан ба Христ хэрхэн хүний төрхөөр бусдыг аврахаар ирсэн хайр нигүүлслийг харуулдаг.

Лук эмч Христийн гайхамшигт төрөлтийн түүхийг дэлгэрэнгүй бичсэн. Зөвхөн түүний номонд хоньчид түүн дээр ирдэг тухай гардаг. Мөн Есүс 12 хүрээд сүмд ирдэг тухай Лук тэмдэглэн үлдээсэн. Тэр Есүсийг бусдын адил хүн байж өөрийн гараар ажиллаж хөдөлмөрлөж зовж байсан гэдгийг онцолсон. Энэ номонд гардаг 6 гайхамшгийн тав нь эдгэрлийн гайхамшигууд. Зөвхөн Лукийн сайн мэдээнд тахилчийн зарцыг цохиж баруун чихийг нь тасалсан тухай гардаг. (Лук 22:51).

Лукийн сайн мэдээ нь дэлхий дээр төөрсөн хүмүүст хандаж бичигдсэн. Эмэгтэйчүүдийн талаар болон уран яруу шүлэг болон залбирал, тэр дундаа Эзний гуйлтын талаар бусад зохиогч нараас илүү бичиж үлдээсэн.

25-р Хичээл - ИОХАН

Иохан Есүсийг Бурханы Хүү гэдгээр илүү харуулдаг. Сайн мэдээний энэ номонд Түүнтэй харилцах Бурханлаг харилцааны тухай ихэвчлэн өгүүлдэг.

Энэ номын зохиогч Иохан нь “Есүсээр хайрлагдсан дагалдагч” байсан. Түүний аав Зебедэ чадварлаг загасчин байсан бол түүний ээж Саломе нь Бурханы үнэнч дагалдагч байв. Иаков түүний ах байсан.

Бусад сайн мэдээнээс хойш нэг үеийг өнгөрсний дараа Иохан ном бичигдсэн. Есүс түүнийг дуудах үед тэр ойролцоогоор 25 настай байсан. Тэр Иохан баптистын дагалдагч байсан ба Шинэ Гэрээний бусад ном дуусах үед хожим манай эрний өмнөх 80-100 онд Патмос-д цөллөгдсөн. Иоханы дуу хоолой өндөрт өргөгдөж, бусад сайн мэдээний номноос илүүд үзэгдэж байсан. Иохан номонд Есүс Бурханыг “миний Аав” гэж дуудсан байдаг. Нийт 25 удаа “Үнэнээр Үнэнээр” гэж эрх мэдэлтэйгээр хэлсэн байдаг.

Есүс бол Христ гэдэгт хүмүүс итгээсэй гэсэндээ би сайн мэдээний номыг бичсэн гэж Иохан хэлсэн. Иохан үүнийг гэрчлэх долоон гэрч нарыг дурддаг. (1:34; 1:49; 6:69; 11:27; 20:28; 20:30; болон 10:36). Тэрээр мөн дараах долоон гайхамшгийг тэмдэглэсэн байдаг. (2:1-11; 4:46-54; 5:1-47; 6:1-14; 6:15-21; 9:1-41 болон 11:1-57).

Бурханы мөн чанрыг “БИ БОЛ” гэсэн 7 нэрийг энэ номонд буулгасан. (6:47; 8:12; 8:58; 10:7; 10:11, 10:36; 14:6; болон 15:1).

26-р Хичээл - ҮЙЛС

Лукийн сайн мэдээнд Христ энэ дэлхий дээр хийж эхэлсэн зүйлсийн талаар гардаг. Харин Үйлс номонд тэр Өөрийн Сүмээр болон Ариун Сүнсээрээ дамжуулан өөрийн ажлаа үргэлжлүүлэн хийсэн тухай бичсэн. Лук номонд Есүс дээш өргөгдснөөр дуусдаг бол энэ хэсэг Үйлс номын эхлэл хэсэг болдог.

Үйлс ном элч нараар дамжуулан хийсэн Ариун Сүнсний ажлуудыг харуулдаг. Бурханы нэр 70 удаа гардаг бол “гэрч” гэсэн үг 30 гаруй удаа давтагддаг. Номын эхэнд Ирусалемд Евреичүүдийн хотод сайн мэдээ тарааж байгаа тухай гардаг бол төгсгөл хэсэгтээ дэлхийн эрх мэдлийн төв болсон Ром-д сайн мэдээ тарж байгаагаар төгсдөг. Тэр үед элч нар бүх тийшээ таран явж бүх үндэстэнд сайн мэдээг тарааж байсан. (Кол 1:23).

Үйлс номын 1-12-р бүлэгт, Петер Евреичүүдэд гэрчилж байгаа тухай харж болно. Тэр “Гэмшигтүн” гэж номлож байв. Үйлс 13-28-р бүлэгт, Паул Харь Үндэстнүүдэд хандан “Итгэ” гэж хэлж байсан.

Үйлс номыг сайн мэдээ тараах гарын авлага гэж хэлж болно. Бусдыг Есүс Христийн талаарх сайн мэдээнд авчрах авралын хөдөлгөөний хөдөлгөгч хүчийг харуулж өгсөн. Анхны сүм хүмүүсийн төвлөрсөн газрыг сонгон аваад Ариун Сүнсээр удирдуулан маш тэмүүлэлтэйгээр сайн мэдээг тунхагласан. Паулын 3 удаагын авралын зарын аялалууд нь хэрхэн үр дүнтэй байсан нь үүний гэрч юм.

27-р Хичээл - РОМ

Захидал хэлбэрээр бичсэн номны эхний хэсэг. Паулын 13 захидал бичсэн. (Энэ захидалд Евреи ном орсон байдаг гэвч Паул Евреи номыг бичсэн гэдэг нь тодорхой биш). Паул Евреи гаралтай хүн байсан. Тэрээр Ромын иргэн, Грекээр боловсрол эзэмшсэн, Евреи шашинтай Бага Азид байгаа олон үндэстэн ястанг холбоход хамгийн тохиромжтой нэгэн байсан. Ромоос Иерусалемийг зорин ирсэн айлчид Дээгүүр өнгөрөх баярын үеэр итгэгч болон сайн мэдээний үрийг өөрсдийн хот руу аваачиж сүм тарьж эхэлсэн. 28 жилийн дараа Паул тэдэн дээр очихыг маш их хүсч энэ захиаг Коринтод 3 сар байх хугацаандаа бичдэг. Ром ном нь Бурхан гэм буруутай нэгнийг хэрхэн өөрчилдөг талаар өгүүлсэн. Бид хэрхэн аврагдах тухай харуулсан гайхалтай ном.

Тойм: Номлол -1-8-р бүлэг . Эхний гурван бүлэгт (1:18 ба 3:20) хүмүүсийн гэм нүглийн талаар бичсэн. Христийн золилтоор Бурханы нигүүлслээр зөвтгөгдсөн тухай (3:21-5:11).- д хэлсэн. Түүний дараа элч нарийн ариун байдлын талаар сургадаг (5:12-8:39). Израйлийг Бурхан хэрхэн сонгосон ямар зорилгыг тавьсан тухай 9-11-р бүлэгт гардаг. Төгсгөлийн 4-р бүлэг буюу 12-16-р бүлэгт Итгэгчдийн үүрэгийн тухай амьдралд ойроор заасан.

28- р Хичээл - 1-2-Р КОРИНТ

Паулын үед Ромын Хаант Улсын Коринт хот бол гэм нүглийн голомт байсан. Грекийн хамгийн чухал хотуудын нэг байсан ба маш эд баялагтай газар байсан ч ёс суртахууны хувь маш доголдолтой хот байв.

Хэдийгээр ийм асуудалтай хот байсан ч Паул Коринтод сайн мэдээг тарааж, сүм тарьж, энэ хоёр захиаг бичсэн. Коринтчууд захиа бичээд төлөөлөгчөө Паул руу явуулдаг. Нэгдүгээр Коринт номонд Паул тэдний сүм чуулганд болоод байгаа нөхцөл байдлын талаар бичсэн. (7:1; 16:17). Бие махбодын хүсэл тачаалдаа автаж тэдний дунд хуваагдал үүссэн байсан. Итгэгч хүмүүс итгэгч хүмүүсийнхээ эсрэг зогсож ариун зоог барих ширээнд цэвэр ариун байж чадаагүй. Эмэгтэйчүүд нь ёс бус байж, сүмийн гишүүд гэр бүлийн талаар маргалдаж сүнслэг бэлэг авьяасын талаар маргаж байсан.

Паул Христ амилсан тухай болон бидний бие мөн амилагдах тухай 15-р бүлэгт батлан хэлдэг.

Хоёрдугаар Коринт номонд Паул анхны захидлыг хүмүүс таатай хүлээж авсанд баярлан өөрийн элч гэдгээ батлан бичсэн. Энэ захианд тэр өөрийнхөө хувийн амьдралын тухай хамгийн дэлгэрэнгүй бичсэн байдаг. Захиа тайвшралаар эхлээд “тайвширлаар” төгсдөг (1:3; 13:11).

29-р Хичээл - ГАЛАТ

Паул хоёр дахь удаагаа авралын зараар явах үедээ Галатын хөдөөрхүү газар сүм тарьсан. Хуулийн багш нар Паултай дагалдан аврал нь сайн үйлсээр дамжин ирдэг гэж зааж байсан. Түүний хажуугаар буруу сургаал заагч багш нар хүмүүсийг янз бүрийн ёс жаяг барих ёстой хэмээн “ятгаж” эхэлсэн. Тиймээс Паул ямар ч сайн үйлс хийсэн тэр нь Христ рүү авчрахгүй зөвхөн итгэлээр Христ рүү ирдэг гэдгийг хүмүүст заадаг. Паул Галатчууд хуурамч сургаалд итгэн дагахад бэлэн байгаа тухай сонссон Паул энэ захиаг тэдэнд яаран бичсэн (6:11).

Энэ захинд Христчин бие даасан байдлын талаар онцолдог ба хууль ба ивээл хоёрын ялгаатай байдлыг харуулдаг.

Галат ном нь хатуу боловч үнэн үгийг шулуухан хэлсэн захидал. Гэсэн ч ямар нэг буруутгал, магтаал, талархлын талаар дурдаагүй. Захианд хэний ч нэрийг бичээгүй боловч сэтгэл хөдлөгсөн хурц мэдрэмжээр дүүрэн арцалдсан үгтэй захиа. Мартин Лүтер-н дуртай захиануудын нэг байсан. Учир Бичээст итгэснээрээ зөвтгөл ба аврал ирнэ гэсэн тунхаглалыг хүчтэйгээр гаргаж ирсэн ном юм.

30-р Хичээл - ЕФЕС

Энэ ном нь шоронгоос бичсэн 4 захиануудын нэг. (Филипой, Колосай болон Филимон нар нэмэгдэнэ). Энэ номонд сүмийн агуу нууцуудыг харуулдаг. Заримдаа эдгээр захиануудыг Паулын бичсэн “Ариунаас Ариун буюу Паулын Гурав дахь тэнгэрийн захидал” гэж дуудах нь байдаг.

Түүний авралын зарын хоёр дахь удаагийн аялалаар Ариун Сүнс Паулд Ази руу тухай үеийн төв газруудын нэг болох Ефес руу явахыг хориглодог. Хоёр дахь аялалаараа Паул Коринт хүртэл яваад Ефес хүрэлгүй буцдаг, Гэвч дахин гурав дахь аялалынхаа үеэр Эфес-т ирээд хоёр жил үйлчлэл хийсэн. (Үйлс 18:19 болон Үйлс 19:8-10). Ефес хотынхон бусад газрын хүмүүсээс илүүтэйгээр Библийн тухай Паулаас сурсан.. Тэр хэдийгээр эсэргүүцэлтэй тулгарч байсан ч Бурхан түүнийг хамгаалж байв. Тэр Ефес хотын сүмд маш хайртай байсан. Сүнслэг үнэнээр дүүрэн энэ номын тойм гэвэл:

- 1 Христ доторх болон тэнгэрлэг орчинд итгэгчдийн байр суурь- 1-3-р бүлэг.
- 2 Итгэгчдийн алхаа (4-6-р бүлэг).
 - a. Христийн бие дэх нэгдэл - 4-р бүлэг.
 - b. Ёс суртахуун, 5-р бүлэг.

- c. Нийгэмшил - 5:21- 6:9.
- d. Бурханы хуяг дуулга- 6:10-24.

31-р Хичээл - ФИЛИППОЙ БОЛОН КОЛОСАЙ

Энэ хоёр захиа нь Ефес Филимон ном шиг шоронгоос бичсэн захианууд.

Филиппой ном нь Епафродитоор дамжуулан Филиппой хотын сүмд Паул Тимот хоёроос бичсэн “талархлын захиа” юм. Паул Филиппой хотын сүмд онцгой хайртай байсан. Тэрээр голын эргээр явж байсан хэсэг эмэгтэйчүүдтэй уулзах үеэр Лида аврагддаг. Түүний дараа Паул Силас хоёр шоронд хоригдон зодуулдаг. Шөнө дунд тэд магтаж байх үед хүчтэй газар хөдлөлт шоронг хөдөлгөснөөс шоронгын харгалзагч болон гэр бүл нь итгэгч болж аврагддаг (Үйлс 16).

Баяр баясгалан энэ номын гол хэсгүүд: Зовох үедээ ч баяр хөөртэй байх 1-р бүлэг; Үйлчлэлийн баяр хөөр, 2-р бүлэг; Христ доторх баяр хөөр, 3-р бүлэг; Баяр баясгалан ба сэтгэл хангалуун байдал, 4-р бүлэг. Колосай хотынхон буруу сургаал сонсож байсан тул Паул тэднийг залруулахын тулд энэ захиаг бичсэн. Итгэгч нар хөвч хөндүүлэх болон аливаа тэмдэглэлт өдөр идээ ундаа болон элч нарт итгэх талаар сургаал сонсож байсан. Христэд итгэнэ гэдгийн нарын учрыг ойлгоогүй учир тэдэнд хэрэгтэй бүхэн Христ дотор байгаа гэдгийг ойлгоогүй. Паул тэндийг:

- 1 Онлын хувьд
- 2 Практик амьдрал дээр зааж залруулсан.

32-р Хичээл - НЭГ, ХОЁРДУГААР ТЕСАЛОНИК

Паул сайн мэдээний хоёр дахь аялалаа хийж явахдаа Тесалоник хотод сүм тарьдаг (Үйлс 17:1-10). Евреичүүдийн жагсаал цуглаанаас болоод тэд богино хугацаанд тэнд байсан ба тэдний тарьсан шинэ сүм маш хүчирхэг байсан. Сүмийн гишүүдийн ихэнх нь итгэгч биш харь үндэстнүүд байсан боловч сайн мэдээнд итгэсэн хавчлагатай үе байсан. Паул тэдэнд итгэл дотроо хэрхэн амьдарч байгаад их санаа тавьсан. Тимот тэдний итгэлийн талаарх мэдээг түүнд хэлдэг байсан ба итгэл дотроо бат зогсохыг сануулан урамшуулж байсан (3:6). **1-р Тесалоник** номонд онол номлолоос илүү урамшуулан зоригжуулсан захиа байсан. Паул Есүс дахин ирэх тухай нилээд сануулж (1:10; 2:19; 3:13; 4:16-18; 5:23) Түүний ирэх өдрийг хүртэл итгэлийн амьдралаар амьдрахыг уриалсан.

2-р Тесалоник номыг эхний номны дараахан бичсэн. Энэ номын гол санаа нь Христийн дахин ирэлтийн тухай. Тэдний зарим нь эхний номыг уншаад дахин ирэлтийн талаар дутуу ойлголттой байсан тул энэ захианд дахин ирэх өдрийн өмнө болох үйл явдлуудын талаар бичиж итгэгч нарыг тэвчээртэй тууштай байж хавчлага ирэх үед итгэлээ бат захин Христийн дахин ирэлтийг хүлээх талаар уриалсан.

33-р Хичээл - НЭГ, ХОЁРДУГААР ТИМОТ

1-2-р Тимот болон Тит ном нь пастор нарт зориулсан захиа гэж нэрлэгддэг учир нь энэ номонд туршлагатай төлөвшсөн пасторууд шинэ залуу үедээ зааж тэд бусдыг пасторын үйлчлэлд сурган бэлтгэдэг тухай гардаг. Тимотын аав нь Грек гаралтай хүн байсан бол ээж нь Евреи хүн байсан. Тэрээр 15 настай байхдаа Паулыг Листра-д ирэх үед итгэгч болдог (Үйлс 16:1-3, 1Тим 1:2). Долоон жилийн дараа тэрээр Паулын сайн мэдээний хамтрагч болсон юм.

1-р Тимот - Паул анх шоронд хоригдсны дараа Ефест очдог. Тэр буцахдаа Тимотод бүх зүйлийг хариуцуулаад үлдээсэн. Паул Коринтоос Тимотод зааж урамшуулж байв. Энэ номын гол ишлэл нь 3:15. Тимотийг буруу сургаалаас болгоомжлох тухай болон залбирах нь ямар чухал гэдгийг захиж хэлсэн. Сүмд үйлчлэгчид ямар байх талаар заавар өгч үйлчлэл хийхийг хүссэн хүмүүст байх зохистой зан чанрын талаар бичсэн.

2-р Тимот Энэ захидлыг Ромын гянданд байхдаа илгээсэн ба шоронгоос гарах цаг удахгүй ирнэ гэсэн итгэлээр бичдэг. Тэрээр Тройд байхдаа гэнэт баригдсан тул дээл номнуудаа авч явч чадаагүй. (4:13). Тэрээр ганцаараа байсан ба цаазаар авхуулах ялаа хүлээж байсан үе. Паул Тимотыг Марктай хамт түүний орхисон дээл, номнууд, ялангуяа илгэнүүдийг авчруулахыг хүсдэг. (4:10-12). Энэ номын гол санаа нь зовлон бэрхшээл, элчийн үйлчлэл болон Бичээсийн тухай байсан.

34 р Хичээл - ТИТ БОЛОН ФИЛЕМОН

Тит харь үндэстэн байсан боловч Паулаас сайн мэдээ сонсож итгэгч болсон. (1:4). Паул Титэд Коринт хотын сүмд болоод байгаа замбараагүй асуудлыг шийдэх хүнд даалгаврыг өгсөн. (2 Коринт 7:6,7). Паул Тит-т асуудлыг даатгавал зохицуулж чадна гэж итгэсэн болхоор түүнийг Крет-д байдаг асуудалтай чуулганд үлдээж удирдаг үүрэг даалгавар өгдөг. (1:5). Тит маш ээдрээтэй асуудлыг шийдэх чадвартай нэгэн байсан. Тэр Тимотийг бодвол илүү төлөвшсөн бас хүч тэнхээтэй нэгэн байсан.

Энэ захианд хуурамч сургаалын талаар анхааруулсан ба амьдралд хэрэгтэй зөвлөлгөөнүүд олон. Номын гол санаа нь сайн үйлсээ үргэлжлүүлэн эрүүл сургаалын талаар болон үйлчлэгч хүмүүсийн үүрэг хариуцлагын тухай юм.

Филемон ном нь зуучлан гуйлтын талаар тэр тусмаа Паул Филемонийг түүнээс урван явсан Онесим-г уучлах талаар хичээнгүйлэн гуйсан захиа юм. Филемон маш амжилттай нэгэн байсан (5-7, 22) магадгүй Паул-с сайн мэдээ сонсон итгэсэн байх. Онесим Ромоос зугтан явж байгаад Паулын хажууд ирэн итгэгч болдог (10). Энэ номонд Онесим хэрхэн итгэж зан чанар нь өөрчлөгдсөн тухай гэрчлэн ярьдаг бол түүнийг өршөөхийг хүсэн ятган бичсэн тухай гардаг.

35-р Хичээл - ЕВРЕЙ

Энэ захиаг хэн бичсэн нь тодорхой биш ч хүмүүс Паул-г бичсэн гэж итгэдэг. Энэ номыг Еврейн Христ итгэгчидэд зориулан бичсэн ба гол зорилго нь Христийн төлөөс хуучин гэрээний тахилч нарын үйлддэг байсан заншилаас илүү энэрэнгүй үнэ цэнэтэй гэдгийг харуулдаг. Христ өөрөө төгс тахилч байсан ба төгс золиос болсон тухай өгүүлдэг. Эхний 10 бүлэгт, Бурханы хүү бол Мосэгээс, Иошугаагаас, Аароноос, тэнгэр элчээс болон Мэлчидекээс илүү дээгүүр нэгэн гэдгийг харуулдаг бол 11-13-р бүлэгт итгэлийн амьдралын тухай өгүүлдэг.

36-р Хичээл - ИАКОВ

Энэ номын зохиогч бол Есүсийн ах, Иерусалемын сүмийн ахлагч байсан. (Үйлс 12:17; 15:13). Гэвч тэрээр манай эрний өмнөх 62-р онд тамлагдан нас барсан. Энэ захиа нь Ариун Газраас гадна амьдардаг Еврей итгэгч нарт зориулж бичсэн боловч амьдралд хэрэгтэй олон сургаалыг бичсэн байдаг тул бүх итгэгч нарт хүртээлтэй захиа юм. Номын гол санаа нь итгэлийн амьдралаа сайн үйлсээр харуулах тухай юм.

Иаков номонд амьдралын янз бүрийн нөхцөлд байгаа хүмүүст хандан бичсэн сургаал гардаг. Дарамтанд байгаа хүмүүст хандсан бүлэг (1:2-4), баян итгэгч нарт хандсан бүлэг (1:9-11; 5:1-6), сүмийн гишүүдийн хандлага (2:1-9), удирдагч нарт хандсан бүлэг (3:1) болон итгэлээр ганхаж байгаа хүмүүст хэлсэн сургаал (5:19-20) гэх мэт. Иаков сургаалаа маш тод зүйрлэлээр дамжуулж хэлдэг. Жишээ нь (1:6, 11, 17, 23, 3:3, 5, 7, 12; 4:14; 5:1-2; 7).

37-р Хичээл - НЭГ, ХОЁРДУГААР ПЕТР

Нэгдүгээр Петр захидал нь хавчлагад автан зовж зүдэрсэн итгэгч нарт хандан бичигдсэн. Энэ номыг чин сэтгэлээсээ бичсэн болхоор захиа гэхээсээ илүү сургаал шиг сонсогддог. “Зовлон бэрхшээл” гэдэг үг 15 удаа давтагдсан байдаг. Петр Христээс ирдэг агуу авралын талаар болон итгэгчдийн амьдрал, үүргийн тухай бичсэн. Тэрээр иргэн хүний болон нийгэмд үүрэх хариуцлагын тухай мөн хэрхэн дуулгавартай иргэн байж итгэлийн гэр дотор байх үүргүүдийн тухай бичсэн. Тэр Христийг амьд найдвар (1:3), толбогүй хурга (1:19), Сонгогдсон булангын чулуу (2:6); үлгэр дуурайлал (2:21), зовсон ч гэм хийгээгүй (2:23), бидний нүглийг үүрэгч (2:24), Хоньчин (2:25) болон Тэнгэрт залрагч нэгэн (3:22) гэж тодорхойлсон.

Хоёрдугаар Петр ном нь буруу сургаалд автсан багш нар болон увайгүй хүмүүсээс болгоомжлуулан бичсэн захидал. Номын гол санаа нь Бурханы үг руу анхаарах тухай ба тэнгэрлэг амлалтууд биелэгдэх тухай юм. Лук 2, Тимот 2 болон Петр ном нь эцсийн өдрүүд ойрхон байгаа ба амь өрссөн хэцүү цаг үе сүмүүдийн өмнө айсуй тухай гардаг.

Петрийн захиа 7 чухал сэдвийг хөнддөг: зовлонт үе (1:7), Христийн цус (1:19), Амьд чулуу (2:4), Христ өөрөө (2:6), номхон даруу сүнснүүд (3:4), итгэгчдийн итгэл (2 Пет 1:1), болон гайхамшит амлалтууд (2 Пет 1:2).

38-р Хичээл - НЭГ, ХОЁР, ГУРАВДУГААР ИОХАН БОЛОН ИУДА

Элч Иохан энэ 3 захиа бичсэн.

1-р Иохан номыг “маш итгэлтэй байдлын захиа” гэж болно. Энэ захианд нөхөрлөл, мэдэх болон хайрлах гэсэн үгнүүд маш их давтагддаг. Итгэгч хүмүүсийн сүнслэг мэдлэгийн тухай онцлон бичсэн. “Мэдэх” гэдэг үг нийт 30 удаа гардаг. Номын тойм нь:

- 1 Бурхан бол Амь болон Гэрэл (1-2-р бүлэг).
- 2 Бурхан бол Зөвт Хайр (3-4-р бүлэг).

3 Дэлхийн бузар хүчийг даван гарах арга нь Итгэл болон Хайр (5-р бүлэг).

Хоёрдугаар Иохан нь буруу сургаал болон хий хоосон номлолоос хол байхыг сануулдаг. (7-11-р бүлэг). “Хайр” гэдэг үг 4 удаа давтагддаг бол “үнэн” гэдэг үг 5 удаа давтагддаг.

Гуравдугаар Иохан ном нь зочломтгой зантай Гайд зориулан бичигдсэн. Мөн Диотрефийг Иохан зэмлэдэг бол Деметрийн нэр хүндтэй байдлын талаар өгүүлдэг.

Иуда ном нь Есүс болон Иаковын дүүгийн бичсэн ном юм. Иуда хэсэг бүлэг итгэгч нарт хандан тэндий дунд шургалан орж ирсэн сүсэг бишрэлгүй хэсэг хүн Бурханы нигүүслийг гажуудуулж байгаа тухай бичсэн. Тиймээс Иуда эдгээр хүмүүсийг эсэргүүцэх тухай бичихийг зорисон.

39-р Хичээл – ИЛЧЛЭЛТ

Илчлэлт номыг Иохан Патм хэмээг арал дээр байх үедээ бичсэн. Маш хавчлагатай үед бичигдсэн (2:13) Ромын хант улсыг шүтэх нь тогтоол болж нөхцөл байдал түүнээс ч дордох тухай (2:10) өгүүлсэн. Чуулганд хандсан захидал болон итгэгч бүх хүнд хандан бат зогсохыг уриалан урамшуулсан ном юм. Хэдийгээр ойлгоход хэцүү ном боловч бүх зөгнөл биелэлээ олох тухай болон бузар муу бүхэн шүүгдэж Христ өөрөө Хаан болж мөнхийн алдрыг авах тухай өгүүлдэг.

Библийн номон дотроос үгийг сонсогч бүрд хэн нэгэн эдгээрийн дээр нэмэх буюу хасах аваас энэхүү номонд бичигдсэн гамшгуудыг нэмэх болно гэж бичсэн цорын ганц ном юм. (22:18, 19).

40-р Хичээл - ИЛЧЛЭЛТ НОМЫН ТОЙМ

1. Оршил хэсэг (1:1-20).
2. Долоон сүмд хандан бичсэн долоон захидал (2:1-3:22).
3. Тэнгэрлэг мөргөл (4:1-11).
4. Долоон лац 5:1-8:5).
5. Долоон утлага (8:6-11:19).
6. Долоон тэмдэг (12:2-14:20) .

7. Долоон тэнгэр элч (15:1-16:21).
8. Христийг эсэргүүцэгчийн хаанчлал бол уналт (17:1-2-; 15).
9. Бурханы хот (12:1-22:5).
10. Төгсгөлийн үг (22:6-21).

Илчлэлт номын төгсгөлийн бүлгүүд Эхлэл номын эхний бүлгүүдтэй эрс тэс өөр байдлын талаар бичсэн.

Эхлэл ном:	Илчлэлт ном:
Нар бүтээгдсэн	Нар шаардлагагүй орчин
Дэлхийд гэм нүгэл орсон нь	Гэм нүгэл устгагдана
Сатаны ялалт	Сатан хөсөр хаягдана
Хараал ирсэн	Хараал хүчингүй болсон
Амийн модноос буюу Едэн цэцэрлэгээс хөөгдсөн.	Амын модонд орох эрхтэй болно.

“Ирээрэй, Эзэн Есүс ээ!”

БИБЛИЙН ОНЛУУД

Та энэ гарчгийг хараад их хэцүү уйтгартай хүнд сэдэв гэж бодох байх. Гэвч эдгээр хичээлүүд хэрхэн уялдаж Бичээсүүд нь бидний итгэлийн талаарх үнэнийг хэрхэн бататгаж байгааг энэ хэсгээс харж болно. Библийн онол бол товчхондоо сургаал гэсэн утгатай ба эдгээр сургаалууд нь танд тулгардаг асуултуудад болон хүмүүсийн дахин дахин асуудаг асуултын хариулт болж ирээдүйн үйлчлэлд тань бэлдэх болно. Эдгээр онлуудыг сайн сурснаар та бусдад зааж тэднийг хачин жигтэй сургаалд татагдахаас хамгаална. (Еврей 13:9).

Энэ бүлгийн хичээлийг бэлдэхэд Энэтхэгийн Бомбэй хотод байрлах Сайн Мэдээний Материал Бэлтгэх Үйлчлэлээс хэвлэн гаргасан Дуглас Албоний бичсэн Библийн 100 хичээл ба Чикаго хотын Мүүди хэвлэх газраас эрхлэн гаргасан Вюллям Еваний бичсэн Библийн Агуу Онлууд номыг ашиглав.

ЭНЭ ХИЧЭЭЛИЙН АГУУЛАГА

- 1-р Хэсэг - Бурханы тухай онол - хуудас 34
- 2-р Хэсэг - Есүс Христийн тухай онол - хуудас 37
- 3-р Хэсэг - Ариун Сүнсний тухай онол - хуудас 42
- 4-р Хэсэг - Хүний тухай - хуудас 45
- 5-р Хэсэг - Авралын тухай онол - хуудас 47
- 6-р Хэсэг - Сүмийн тухай онол - хуудас 53
- 7-р Хэсэг - Бичээсий тухай онол - хуудас 55
- 8-р Хэсэг - Сүнслэг биетүүдийн тухай - хуудас 57
- 9-р Хэсэг - Сүүлийн өдрүүдийн тухай - хуудас 60

1-Р ХЭСЭГ

БУРХАНЫ ТУХАЙ ОНОЛ

1-р Хичээл - АМЬД БУРХАНЫ ОРШИН ТОГТНОЛ

Бурхан байдаг гэдгийг батлах олон баталгаа байгаа. Үүнээс цөөн хэдийг нь дурдвал:

1. Бичээсээр батлагдсан хэсэг - Библи Бурхан байдаг гэдгээр эхэлдэг (Эхл. 1:1) ба Түүнийг байдаггүй гэх нь мунхаглал юм гэсэн. (Дуулал 14:1).
2. Бүтээлээр батлагдсан хэсэг - Тэнгэр Бурханы сүр жавхланг зарладаг (Дуул. 19:1) ба ертөнцийн бүтээлүүд Түүний мөнх хүч ба Бурханлаг чанрыг илэрхийлдэг. (Ром 1:20).
3. Хүн ухамсраараа баталдаг - Хүн төрөхдөө л энэ дэлхийд бүхнээс дээгүүр Нэгэн байгаа гэсэн итгэлтэй төрдөг.
4. Бусад баримтууд - Үүнээс гадна Бурхан байдгыг гэрчлэх маш олон баталгаа байгаа. Түүнээс заримыг нь дурдвал:
 - Орчлон ертөнцийг хэн нэг бүтээсэн нь гарцаагүй.
 - Дэлхийг бүтээсэн нэгэн нь маш бодолтой төлөвлөгөөтэйгээр энэ бүхнийг бүтээсэн нь илэрхий
 - Хүн оюун ухаантай ёс суртахуунтай байгааг нь үүний цаана Бүтээгч байдаг гэдгийг илэрхийлдэг.
 - Аливаа бүхний эхлэлийг мөнх амьтай Нэгэн л эхлүүлдэг

Дүгнэлт - Еврей 11:6-д Бурханд ойртон буй нь Тэр байдаг гэдэгт итгэх ёстой гэсэн. Хүүхэд адил итгэлээр Түүн дээр ирж Бичээст Бурханыг хэрхэн илэрхийлсэн болон Бурханы зан чанарт бүрэн дүүрэн итгэж найдацгаае.

2-р Хичээл - БУРХАНЫ МӨН ЧАНАР

Библи Бурханы талаарх бүрэн дүүрэн мэдлэгийг заадаг. Түүний талаар бичсэн хэдэн баримтыг олж харье.

1. Түүний мөн чанар - Бурхан бол Сүнс. Сүнсэнд бие, яс болон цус гэж байдаггүй. (Иох 4:24).
2. Түүний зан чанар - Зан чанрыг мэдлэг, мэдрэмж болон сэтгэлийн тэнхээгээр тодорхойлж болно. Бидний Бурхан бол цор ганц, амьд ба өөрийн гэсэн зан чанартай. (Иер. 10:10; 1 Тесал. 1:9)
3. Түүний нэгдмэл байдал - Бидний Бурхан Эзэн бол НЭГ Бурхан ба олон бурхадаас ялгаатай. (Дэд хууль 6:4; Иса. 44:6).

Дүгнэлт: Бид Түүний тухай илүү мэдэх тусам Тэр бол агуу Бурхан гэдгийг мэдэрдэг.

3-р Хичээл - БУРХАНЫ МӨН ЧАНРУУД

Бурханы мөн чанар гэхээр ойлгомжгүй сонсогдож байна уу? Энэ нь товчхондоо аливаа зүйлийн онцлог байдал өвөрмөц чанрын тухай юм. Энэ хичээлээр бид Бурханы мөн чанрын тухай судлана.

1. Бурхан бол Мөнх - Жинхэнэ Бурханд эхлэл ба төгсгөл гэж байдаггүй. (Дуулал 90:20); 1Тим. 1:17).
2. Тэр бол Хувирашгүй - (1Сам. 15:29; Малах. 3:6; (Иаков 1:17).
3. Тэр бол бүхнийг үйлдэж чаддаг - Энэ нь Түүнд бүх хүч чадал байгаа гэсэн үг. (Иов 42:2; Иер. 32:27).
4. Тэр газар сайгүй байдаг - Тэр бүх газарт бүх цагт зэрэг оршдог. (Дуулал 139:7-9).
5. Тэр бүхнийг мэддэг - Тэр бүхний бодол санааг мэддэг. (1 Шастир 28:9; 2 Шастир 16:9; Дуулал 94:11; Иов 42:2; Иса. 40-28).

Дүгнэлт: Энэ хичээлээр сурсан Бурханы мөн чанрууд итгэл найдваргүй төөрсөн хүн төрлөхтөнд маш хэрэгтэй. Эдгээр чанрууд яагаад ийм чухал вэ?

4-р Хичээл - БУРХАНЫ ОНЦЛОГ ЧАНРУУД

Бурханы мөн чанар бүрийг нэг бүрчлэн сургаал болгон зааж болно. Тэдний заримаас онцлон хэлвэл:

1. Бурхан бол ариун (Гэт. 15:11; Иса. 6:3; 1 Пет 1:16).
2. Бурхан бол зөвт (Дуул. 116:5; Езра 9:15; Иер. 12:1).
3. Бурхан бол нигүүлсэнгүй (Дуулал 103:8; Ром 9:18).
4. Бурхан бол хайр (1 Иох. 4:8-16; Иох. 3:16); Иох. 16:27).
5. Бурхан бол итгэмжит (1 Кор. 1:9; 2 Тимот 2:13).

Үүгээр зогсохгүй бид Бурханаа бусад олон мөн чанруудыг судлах болно. Үүнд: Бурхан бол **алдартай** (Гэт. 15:11; Дуул. 145:5); **өрөвч нигүүлсэнгүй** (Гэт. 34:6; Дуулал 116:5); гэм **нүглийг хэлтрүүлэгч** (Тоол. 14:18; Мика 7:18); **хартай** (Иош. 24:19; Нахум 1:2); **нигүүлсэнгүй** (1 Хаад 8:23); агуу (2 Хаад 2:5; Дуул. 86:10); **хязгааргүй, гүн гүнзгий** (Иов 11:7; Дуул. 145:3); **үл үзэгдэх** (Иов 23:8,9; 1 Тим. 1:17); **сайн** (Дуул. 25:8; Дуул. 119:68); зөв **шудрага** (Дуул 25:8; Дуул. 92:15); **мөнх оршигч** (Дуул. 102:26,27; Иак. 1:17); **гэрэл** (Иса. 60:19; 1 Иох. 1:5); **үнэн** (Иер 10:10); **төгс** (Мат. 5:48); **үл муудагч** (Ром 1:23); **үл үзэгдэх** (1 Тим. 1:17; 6:16); **шатаах гал** (Еврей 12:29); **Түүнтэй зүйрлэх хэн ч үгүй** (Гэт. 9:14; Дэд хууль 33:26).

Дүгнэлт: Бурханы ариун байдал нь гэм нүгэлд шийтгэл байх ёстой гэж шаарддаг. Бурхан хайрладаг ч түүний хажуугаар биднээс ариун байдлыг хүсдэг. Тэгвэл Бурхан гэм буруутай нэгэнд яаж шудрага бас нигүүлсэнгүй хандаж чаддаг вэ? Энэ бүхний хариулт нь Гавал хэмээх толгод дээр гэм нүглийн эсрэг ассан Бурханы уур хилэнг гэм нүгэлтнүүдэд хандсан нигүүлсэл болгон өөрчилсөн.

5-р Хичээл - БУРХАНЫ ГУРВАЛ

Бурхан цор ганц боловч Өөрийгөө гурвалаар буюу Эцэг, Хүү болон Ариун Сүнс гэж оршдог. Гурвалын тухай дараах ишлэлүүдийг уншина уу:

1. Матай 3:13-17 номонд гардаг Есүсийн баптисм - Эцэг тэнгэрээс ярьж, Хүү усанд баталгаа хүртэж байхад Ариун Сүнс тагтаа мэт бууж Аврагч дээр ирдэг.
2. Матай 28:19-р ишлэл дээр Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээдэг тухай гардаг. Нэрээр гэдэг нь ганц тоон дээр хэлэгдсэн.

3. Коринт 13:14-т Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай гэж залбирдаг
4. Бид дүр төрхийнхөө дагуу бидэнтэй адилхан хүнийг буй болгоё гэсэн (Эхл. 1:1-3; Эхл. 1:26; болон Иох. 1:1-2).

Дүгнэлт- Бурхан гурвалаар оршдог боловч тэр дундаа төгс холбоо харилцаатай. Үүний адил хүмүүс бас Бурхантай, түүний бүтээлүүдтэй болон бусадтай зөв харилцаатай байхаар бүтээгдсэн.

2-Р ХЭСЭГ

ЕСҮС ХРИСТИЙН ТУХАЙ ОНОЛ

6-р Хичээл - ЗӨГНӨЛ БИЕЛЭЛЭЭ ОЛСОН

Есүсийн тухай хэлэгдсэн бүхэн Хуучин Гэрээнд зөгнөгдөж олон зуун жилийн дараа Шинэ Гэрээнд биелэлээ олсон байдаг. Энэ бол агуу үнэн.

1. Христ Израйлаас төрнө (Тоол. 24:17-19; Матт. 1:17).
2. Иудагийн удам, Давидын гэр бүлээс Есүс төрнө (Эхл. 49:10; Иса. 11:1; Лук 1:31-33).
3. Тэр Бетлехемээс төрнө (Мика 5:2).
4. Тэр онгон нэгнээс төрнө (Иса. 7:14; Матт. 1:18, 22, 23).
5. Цөлд хашгирах нэгэн нь Христийн ирэх тухай хэлсэн (Иса. 40:30; Матт 3:3).
6. Месаяа бол Бурхан (Иса. 9:6; Иох. 1:14).
7. Тэр хүүхэд насаа Египтед өнгөрүүлнэ (Хос. 11:1; Матт. 2:13-18).
8. Тэр зовж гэм нүглийн төлөөс болно. (Иса. 53:46; 2 Кор. 5:21).
9. Тэр илжиг унаад Ирусалемд ирнэ (Зех. 9:9; Матт. 21:2-5).
10. Тэр загалмайд зовж байхад цөстэй хольсон дарсыг Түүн уулгав (Дуул. 69:21; Матт. 27:34).
11. Ромд загалмайн үхлээр үхсэн ч Түүний нэг ч яс хугараагүй. (Дуул. 34:20; Иох. 19:33-36).

12. Хүмүүс шавга хаяж хувцсыг нь хуваан авдаг (Дуул 22:18; Матт. 27:36).
13. Тэр үхэхээр шаналж байхдаа Бурханд хандан хашгирдаг. (Дуул. 22:1; Марк 15:34).
14. Тэр үхлээд дахин амилна. (Дуул. 16:10; Үйлс 2:3).

Дүгнэлт: Энэ бүх зөгнөл биелэлээ олсон нь бидний Бурхан ямар агуу гэдгийг харуулж байна.

7-р Хичээл - ЕСҮС БУРХАН

Бид Есүсийг Бурхан гэдгийг мэддэг ба Түүнд зөвхөн Бурханд байх мөн чанрууд оршдог гэдэг талаар дараах ишлэлүүдийг уншиж судлана уу.

1. Тэр бол **мөнх** (Мика 5:2; Иох. 8:58; Кол 1:17; Илч. 1:8).
2. Тэр бол **хувирашгүй** (Евр. 13:8).
3. Тэр бол **бүхнийг үйлдэж чаддаг** (Лүк. 8:24; Матт. 28:18).
4. Тэр **газар сайгүй байдаг** (Матт 18:20; Иох. 1:48; Иох. 3:13; Матт. 28:20).
5. Тэр **бүхнийг мэддэг** (Марк 11:2-6; Иох. 2:24-25; Лүк 5:22; Матт. 24:3-31).
6. Тэр бол **ариун** (Марк 1:24); гэм нүгэлгүй 1 Петр 2:22; Иох. 19:4).
7. Тэр бол **зөвт** сүмийг шудрагаар цэвэрлэгч (Иох. 2:14-17); зөвт Шүүгч (Үйлс 17:31).
8. Тэр бол **хайрын** Бурхан (Иох. 15:13; Иох. 11:36).
9. Тэр **нигүүлсэнгүй** (Тит 3:5). Тэр бидний төлөө нас барсан.
10. Тэр бол **итгэмжит** (2 Тим. 2:13).

Зөвхөн Бурханы хийдэг таван ажлыг Есүс хийсэн; **бүтээл** (Иох 1:3); **цог жавхлангын гэгээ** (Евр. 1:3); **уучлал** (Лук7:48); **үхэгдсдийг амилуулсан** (Иох. 6:39) болон **шүүлт** (Иох. 5:22).

Дүгнэлт: Есүс дахин амилсан гэдэг нь Бурхан байгааг хамгийн том баталгаа юм.

8-р Хичээл - ХРИСТИЙН ХҮН ЧАНАР

Аврагч байхын тулд онгон хүнээс төрөхөөс гадна Тэр жинхэнэ хүн байх хэрэгтэй байсан. Түүний хүн гэдгийг харуулсан эдгээр ишлэлүүдийг үзэцгээе:

1. Бусдын адил **нэртэй** байсан (Матт 1:21). Хүний хүү гэдэг үг 77 удаа гардаг.
2. Түүнд **удам угсаа** байсан (Матт. 1:1-16).
3. Тэр **өлсөж** (Матт. 4:2) мөн **цангаж** үзсэн (Иох. 4:7; 19:28).
4. Тэр **ядарсан** (Иох 4:6); Тэр **унтдаг** байсан (Матт. 8:24).
5. Тэр **хайрласан** (Марк 10:21, Иох. 11:36); **нигүүлсэнгүй сэтгэлтэй** (Матт 9:36).
6. Тэр **уурласан** бас **гунигласан** (Марк 3:4).
7. Тэр **шаналсан** (Иох. 11:33); уйлсан (Иох. 11:35; Лук 19:41).
8. Түүнд бие махбодь (Иох. 1:14); **сэтгэл** (Матт. 26:38) болон **сүнс** (Лук 23:46) байсан.
9. Тэр **нас барсан** (Евр. 9:27; Лук 23:33).

Дүгнэлт: Бурхан бас хүн - ямар агуу Аврагч вэ!

9-р Хичээл - ХРИСТИЙН АМЬДРАЛ, НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Бидний Эзэн дэлхий дээр амьдарч байх үеийн тухай олон зүйл бичигдсэн байдаг:

1. Есүс Бурхантай хамт байнга оршиж байсан. Тэр өмнө ч байсан дараа нь ч байна.
2. Онгон Мариагаас төрсөн түүх Маттай Лук номонд гардаг.
3. Тэр найман өдрийн дараа хөвч хөндүүлдэг. (Лук 2:21)
4. Тэр Ирусалемийн сүмд 12 настай байхдаа очсон. (Лук 2:41-48).
5. Тэрээр бага байхдаа Ирусалемд мужаан хийдэг байсан. (Марк 6:3).
6. Түүний үйлчлэлийн эхний 6 сар Иуда, Самари болон Галилд өнгөрсөн. (Марк 6:3).
7. Дараагийн 6-8 сард Кафарнаум болон Галилд сургаал зааж өвчтэй хүмүүсийг эдгээж гайхамшигуудыг үйлдсэн.

Есүсийн хийсэн гайхамшгуудыг жагсаавал:

- a. Салхи намдаасан (Матт. 8:26, 27).
- b. Чөтгөрийг хөөсөн (Марк 5:12-13; Матт. 8:28-32, 9:32, 33, 15:22-28, 17:14-18; Марк 1:23-27).
- c. Өвчнүүдийг эдгээсэн - саа өвчин (Матт. 8:13, 9:6); хазгар доголлон хүн (Иох. 5:9); тахир дутуу хүн (Матт. 12:13) бөгтөр нуруутай хүн (Лук 13:12); цус алддаг өвчин (Матт. 9:22); усан хавантай хүн (Лук 14:2); халуурсан хүн (Матт. 8:15); хэлгүй хүн (9:33); хараагүй хүн (Иох. 9:1-38); дүлий хүн (Матт. 11:5); уяман өвчин (Матт. 8:3; Лук 17:19). Есүс арав гаран төрлийн өвчнийг эдгээсэн.
- d. Үхлээс амилуулсан - Лазар (Иох 11:43; 44); Захирагчийн охин (Матт. 9:18-26); бэлэвсэн эмэгтэйн хүү (Лук 7:12-15).
- e. Бусад гайхамшигууд - Усыг дарс болгосон (Иох.2:1-11); 5000 хүнийг эдгээсэн (Иох. 6:1-14); усан дээр алхдаг (Иох. 6:15-21); 4000 хүнийг хооллосон (Матт. 15:32-39); инжрийн модыг хувхайруулдаг (Матт. 21:18-22); загасны амнаас зоос гаргадаг (Матт. 17:27); гэнэт их загас барьдаг (Лук 5:1-1).
- f. Түүний дахин амилалт бол хамгийн агуу гайхамшиг байсан (1 Кор. 15:4; Ром 1:4).

10-р Хичээл - ХРИСТИЙН АМЬДРАЛЫН ХУРААНГУЙ

1. Галилд тэрээс жил гаран үйлчлэл хийсэн ба энэ нь түүний үйлчлэлийн гурав дахь үе байсан. Олон хүмүүс түүнийг дагаж байсан ба Тэр сургаалаа зааж уулан дээрх номлолоо хийдэг. (Матт. 5,6 ба 7-р бүлэг).
2. Түүнээс хойш Фарисайчууд түүний амыг хороохоор хөөх үед тэр Кафарнаум, Таршиш, Бетсайд, Кайсарид болон Филиппи-р тойрж яваад буцаж Галилд ирдэг.
3. Сүүлийн 6 сард аялангаа сургаал номлол зааж явсан.
4. Түүний сүүлчийн долоо хоногт Эзний нэрээр ирж, Сүүлийн зоог бариад, Чидун уулан дээр залбираад зовж загалмайд цовдлогддог.
5. Зөгнөлийн дагуу, гурван өдрийн дараа үхлээс дахин амилдаг.
6. Дахин амилсаны хойш 40 хоногын дараа дээш тэнгэр рүү өргөгддөг. (Үйлс 1:10, 11).

Ярилцах сэдэв - Түүний амьдралд болж байсан үйл явдлаас аль нь Түүнийг Бурхан гэдгийг илэрхийлж байсан бэ? Мөн амьдралынх нь ямар хэсэг Түүнийг хүн байсан гэдгийг харуулдаг вэ?

11-р Хичээл - ЕСҮС ХРИСТИЙН ДАХИН АМИЛАЛТ

Шинэ Гэрээнд дахин амилалт гэдэг үг 104 удаа давтагддаг ба Бичээсийн суурь онлын нэг юм. Христийн шашин бол амьд оршигч Эзэнтэй цорын ганц шашин.

1. Дахин амилалтын баталгаа
 - a. Хоосон булш (Матт. 28:6; Лук 24:3).
 - b. Элч нарын гэрчлэл (Матт. 28:46 болон Лук 24:5-7).
 - c. Петер, Мариа, Клеоп болон Томас нартай амилсанаа дараа ярьдаг.
 - d. Есүс хоол идэж уугаад тэдэнд шархаа харуулдаг.
 - e. 500 хүн Түүнийг нэгэн зэрэг хардаг. (1 Кор. 15:6)
 - f. Тэр Стефанд болон түүний үхэх үед харагддаг. (Үйлс 7:56).
 - g. Тэр Паулыг Дамаск явах замд харагддаг. (Үйлс 9:5).
 - h. Сая сая хүн Түүнийг Аврагч гэдгийг гэрчилдэг.
 - i. Бусад олон олон үнэн баталгаа байгаа.
2. Түүний амилсан бие нь ямар байсан бэ?
 - a. Тэр мах болон яснаас бүрдсэн байсан.
 - b. Түүний бие цог жавхлантай байсан.
 - c. Түүний бие хэзээ ч мөхөшгүй. (Ром 6:9).
 - d. Түүнд сүнслэг бие байсан (1 Кор. 15:44).

Дүгнэлт: Дахин амилалт нь үхлээс ч хүчтэй байж үхлийн хүчийг ялан дийлсэн юм.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

АРИУН СҮНСНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ

12-р Хичээл - АРИУН СҮНСНИЙ ЗАН ЧАНАР

Бид Ариун Сүнснийг яагаад хүнтэй адил гэж үздэг шалтгаанууд:

1. Библи Ариун Сүнсний тухай ярихдаа хувь хүнийг төлөөлсөн үгээр илэрхийлдэг.
 - a. Иохан 16:7-8 болон 13-15 Грекээр эрэгтэй хүнийг төлөөлсөн тэр гэдэг үгээр Ариун Сүнснийг илэрхийлдэг.
 - b. Мөн Иохан 15:26-г харж болно.
2. Түүнд дараах зан чанрууд байдаг.
 - a. Сэтгэлийн тэнхээ (1 Кор. 12:11).
 - b. Оюун ухаан (Нех. 9:20; Ром 8:27).
 - c. Мэдлэг (1 Кор. 2:10-12).
 - d. Хүч (Үйлс 1:8).
 - e. Хайрлах сэтгэл (Ром 15:30).
 - f. Гуниглах сэтгэл (Еф. 4:30).
3. Зөвхөн хүний хийж чадах зүйлийг тэр хийдэг.
 - a. Бурханы гүн зүйлсийг эрэн хайдаг (1 Кор. 2:10).
 - b. Ярьдаг (Илч. 2:7) бас уйлдаг (Гал. 4:6).
 - c. Зуучлан залбирдаг (Ром 8:26).
 - d. Гэрчилдэг (Иох. 15:26) мөн заадаг (Иох. 14:26, 16:12-14)
 - e. Удирдан чиглүүлдэг (Ром 8:14).
 - f. Тушаадаг (Үйлс 16:6-7); хүмүүсийг ажилд дуудаж үүрэг өгдөг. (Үйлс 13:2).

Тэр бол жинхэнэ тайвшруулагч (Иох. 14:16). Грекээр Параклэтос гэдэг нь хажууд явагч нэгэн гэсэн утгатай ба Тэр бидний дотны анд юм.

Дүгнэлт: Ариун Сүнс бол хүнтэй адил боддог, зорьдог, мэдэрдэг, мэддэг, хүсдэг, хайрладаг бас гунидаг. Мөн хүний хийдэг үйлдлүүдийг хийдэг.

13-р Хичээл - АРИУН СҮНС БУРХАН

1. **Ариун Сүнс тэнгэрлэг зан чанруудыг агуулдаг.**
 - a. Тэр бол мөнх (Евр. 9:14).
 - b. Тэр газар сайгүй байдаг (Дуул. 139:7-10).
 - c. Тэр бол бүхнийг үйлдэж чаддаг (Лук 1:35; Эхл 1:2-7).
 - d. Тэр бүхнийг мэддэг. (1 Кор. 2:10-11).
 - e. Тэр ятгадаг (Иох. 16:8).
 - f. Тэр бол Үнэн (1 Иох. 5:6).
 - g. Тэр бол өгөөмөр (Нех. 9:20).
 - h. Түүн дотор бид нөхөрлөдөг (2 Кор. 13:14).
2. **Ариун Сүнд зөвхөн Бурханы хийдэг ажлуудыг хийдэг**
 - a. Бүтээл (Иов 33:4).
 - b. Аврал (1 Кор. 6:11) болон өвийн батлан даагч (Ефес 1:13).
 - c. Амьдрал бэлэглэгч (Иох. 6:63).
 - d. Шинэ амийг бэлэглэгч (Иох. 3:5-6).
 - e. Иш үзүүлэлэгч (2 Пет. 1:21).
 - f. Зөвт байдал болон шүүлт ирнэ гэдгийг хүмүүст сануулдаг (Иох. 16:8-11).

Даалгавар - Дээр дурдсан ишлэлүүдээс гадна Хуучин Гэрээ номонд Ариун Сүнсний тухай бичсэн ишлэлийг олно уу.

14-р Хичээл- АРИУН СҮНСНИЙ НЭР БОЛОН БЭЛЭГ ТЭМДЭГҮҮД

1. Ариун Сүнсний нэрнүүд:
 - a. Ариун Сүнс (Лук 11:13).
 - b. Ивээлийн Сүнс (Евр. 10:29).
 - c. Шүүлтийн сүнс ба шатаагч сүнс (Матт. 3:11, 12; Иса. 4:4).
 - d. Үнэний сүнс (Иох. 14:17; 15:16; 16:13; 1 Иох. 5:6).
 - e. Амийн Сүнс (Ром 8:2).
 - f. Мэргэн ухаан ба мэдлэгийн сүнс (Иса. 11:2, 61:1,2; Лук 4:18).
 - g. Амлалтын Сүнс (Ефес. 1:13).
 - h. Алдрын Сүнс
 - i. Бурханы болон Христийн Сүнс (1 Кор. 3:16; Ром 8:9).
 - j. Тайвшруулагч (Иох. 14:16).

2. Ариун Сүнсний бэлэг тэмдгүүд
 - a. Ус - Ус нь харамгүйгээр үнэгүй боловч амийг өгдөг, сэргээдэг, цэвэрлэдэг. (Иох. 3:5, 7:38-39).
 - b. Гал - Гал шатаадаг, цэвэршүүлдэг бас бохирыг арилгадаг ба шалгадаг. (Матт. 3:11).
 - c. Салхи - Салхи бол хүчтэй, сэргээдэг, хараат бус, үл үзэгдэх ба үр нөлөөтэй. (Иох 3:8).
 - d. Тос - Тос нь ариулдаг, тайвшруулдаг, сэнхрүүлдэг мөн эдгээдэг. Тос (Дуул. 45:7).
 - e. Бороо болон шиврээ бороо (Дуул. 72:6). Бороо нь сэргээж, цэвэрлэж бас шинэ үр жимс гаргадаг.
 - f. Тагтаа - Тагтаа бол зөөлөн. (Матт. 3:16).
 - g. Дуу хоолой - Дуу хоолой нь биднийг удирдан чиглүүлдэг, бидэнтэй ярьдаг бас анхааруулдаг. (Иса. 6:8).
 - h. Тамга - Тамга нь жинхэнэ гэдгийг баталдаг ба баталгаажуулдаг. (Илч. 7:2; Ефес 4:30).

Ярилцах сэдэв: Дээр дурдсан хэлбэрээр хийдэг Ариун Сүнсний ажил итгэгч хүний амьдралд ямар ач холбогдолтой вэ?

15-р Хичээл - АРИУН СҮНСНИЙ ЭСРЭГ ҮЙЛДЛҮҮД

Итгэгч болон үл итгэгч нар Ариун Сүнснийг гомдоодог. Ариун Сүнснийг гомдоох үйлдлүүд буюу Сүнсний эсрэг гэм хийх нь маш хортой үр дагавартай.

1. Үл итгэгчдийн хийдэг алдаа:
 - a. Ариун Сүнсний хийдэг ажлыг үгүйсгэдэг (Үйлс 7:51).
 - b. Ариун Сүнснийг уландаа гишгэдэг (Евр. 10:29).
 - c. Ариун Сүнснийг доромжилдог (Матт. 12:31, 32).
2. Итгэгч хүмүүсийн хийдэг алдаа:
 - a. Ариун Сүнснийг гомдоодог (Ефес 4:30, 31; Иса. 63:10).
 - b. Ариун Сүнсэнд худлаа хэлдэг (Үйлс. 5:3-4).
 - c. Сүнснийг бөхөөдөг (1 Тес. 5:19).

Ярилцах сэдэв: Итгэгч хүмүүс хэрхэн Ариун Сүнснийг гомдоож эсвэл “бөхөөдөг” (тоодоггүй) вэ?

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

ХҮНИЙ ТУХАЙ ОНОЛ

16-р Хичээл - ХҮНИЙ АНХНЫ ТӨРХ БАЙДАЛ

Хүн Бурханы дүр төрхөөр Түүнтэй адилхан бүтээгдсэн. (Эхл. 1:26, 9:6). Дүр төрхөөр гэдэг нь сүүдэр ба хэлбэр гэсэн үг. Түүний адилаар гэдэг нь сүүдрийг дуурайсан гэсэн утгатай.

1. Бурхан сүнс учир Бурханы төрхөөр бүтээгдсэн гэдэг нь биеийн хэлбэр адил гэсэн утгатай биш.
2. Анхны хүн бол маш ухаантай байсан. Тэр амьтдад нэр өгч, хэл яриа, сэтгэн бодох чадвар сайтай нэгэн байсан. (Эхл. 2:19, 20).
3. Тэрээр ёс суртахууны болон сүнснлэг хэм хэмнэлтэй байсан.

Ярилцах сэдэв - Гэм нүгэлд унахаас өмнө хүний амьдрал өнөөдрийнхөөс ямар ялгаатай байсан бэ?

17-р Хичээл - ХҮНИЙ УНАЛТ

Хүмүүс гэм нүгэлд унасан тухай зөвхөн Христийн шашинд гардаг бус бусад шашинууд бас үүний талаар тайлбарладаг. Эхлэл 3-р бүлэгт хүн төрлөхтний түүхэнд болсон аймшигт уналтын талаар өгүүлдэг.

Энэ түүхэнд гэм нүгэл дэлхийд ирсэн тухай ярьдаггүй учир нь Сатан аль хэдийнээ гэм хийж дэлхий рүү унагаагдсан байсан. (Езек. 28:12-15; Иса. 14:9-14). Энэ түүхэнд гэм нүгэл дэлхийд хэрхэн орж хүмүүсийг гэмтэй болгосон талаар өгүүлдэг.

1. Уналтын элч (Эхл. 3:1).
 - a. Сатан өөрийнхөөрөө бууж ирээгүй харин могойн дүрээр ирж худал ярьдаг.
 - b. Тэр хүний хянаж чадаагүй хоол идэх хүслээр дамжуулан дайралтаа хийдэг.
2. Уналтанд хүргэсэн алхамууд.
 - a. Эва хориглосон жимстэй дэндүү ойрхон байсан.
 - b. Эва хориотой зүйлсд татагдсан.
 - c. Эва чөтгөрийн үгэнд орсон.

- d. Эва Бурханы үгэнд өнгөц хандсан. Тэр Бурханы үгэнд нэмж, чөлөөтэй гэдэг үгийг хасч чи идвэл заавал “үхнэ” гэдгийг сулруулсан.

Ярилцах сэдэв -Сатан өнөөдөр ямар аргаар хүмүүсийг мэхэлж байна вэ? Тэрний аргууд нь өөрчлөгдсөн үү эсвэл адилхан хэвээрээ байна уу?

18-р Хичээл – УНАЛТААС ҮҮССЭН ҮР ДАГАВАР

1. Гэм нүглийн шууд үр дагавар:

- a. Тэд гэмтнүүд болсон - тэдний сүнсний амьдрал үхсэн. (Ефес 2:1).
- b. Тэдний нүд нээгдэж нүцгэн байгаагаа мэдсэн.
- c. Тэд Бурханы оршихуйгаас нуугдсан. Ичгүүр гэм нүглийг дагадаг ба гэм нүгэл биднийг Бурханаас холдуулдаг.

2. Бурхан хараалыг тунхагладаг (Эхл. 3:14-19)

- a. Хээрийн талын хамаг зэрлэг амьтдаас илүүгээр могойг хараасан.
- b. Эмэгтэйн жирэмсний бэрхшээл зүдүүрийг ихэсгэсэн
- c. Эрэгтэйд чи хөлсөө дуслуулж хоолоо олж иднэ би чиний төлөө өргөс зангууг ч ургуулна гэв. Мөн чи тоос шороо тул тоос шороондоо буцна гэсэн.

3. Удаан хугацааны үр дагавар:

- a. Бүх хүмүүс Бурханы өмнө гэмтэн болсон. (Ром 5:12).
- b. Энэ дэлхий хараалын дор амьдрах болсон. (Ром 3:19).
- c. Итгээгүй хүмүүс эцэг диаволын хүүхдүүд гэж дуудан Бурханы хүүхэд байхаа больсон. (Иох. 8:44).
- d. Бүх хүн төрлөхтөн Сатаны мэдэлд орсон (2 Кор. 4:4).
- e. Хүний мөн чанар сэтгэлгээний хувьд, ёс суртахууны хувьд болон сүнсний бие махбодын тал дээр гэм нүгэлд автсан. (Ефес 4:18; Ром 7:18).

Дүгнэлт: Хүмүүс гэм нүгэлдээ унасан тул Бурхан Аврагчыг болон түүний төлөвлөгөөг гаргасан. (Эхл. 3:15). Бурхан амлалтаа 4000 гаруй жилийн дараа Голгатын толгод дээр биелүүлсэн.

ТАВДУГААР ХЭСЭГ
АВРАЛЫН ТУХАЙ ОНОЛ
19-р Хичээл - ГЭМШИЛ

Бичээст гэмшлийн тухай 100 гаран удаа давтан чухалчлан хэлсэн байдаг.

1. Гэмшлийн тухай ойлголт:
 - a. Буруу ойлголт- Энэ нь гэмээс болж шаналах тухай биш юм. Маш олон хүмүүс гэм хийсэндээ шаналдаг ч тэд дахиад л хийдэг. Иудас болон Есау гэм хийсэндээ шаналсан ч тэд гэмшээгүй.
 - b. Зөв ойлголт - өөрийн бодол болон үйлдлээ өөрчлөх нь юм. (Мат. 21:28-32).
2. Яагаад гэмшил чухал вэ:
 - a. Гэмшил бол Иохан баптистын сургаалын гол санаа байсан. (Матт. 3:1-2).
 - b. Есүс гэмшлийн тухай номлол хийсэн. (Матт.4:17).
 - c. Тэр дагалдагч нартаа гэмшлийн тухай заахыг тушаасан. (Марк 6:12).
 - d. Пентакостын дараа дагалдагч нар гэмшлийн тухай заасан. (Үйлс 2:38, 20:21).
 - e. Бурхан бүх хүмүүсийг гэмшээсэй гэж хүсдэг. (2 Пет.3:9).
 - f. Бурханд дуулгаваргүй хандах нь мөнхийн хараал авчрах аюултай. (Лук 13:3).
3. Гэмшлийн үр дагавар:
 - a. Тэнгэрт их баяр хөөр болно. (Лук 15:7, 10).
 - b. Гэмийн уучлал болон өршөөл авчирдаг (Иса 55:7; Үйлс 3:19).
 - c. Нүгэл уучлагдаж Ариун Сүнсний бэлэг авах болно. (Үйлс 2:38).

Даалгавар: Дээр дурдсан ишлэлээс оруулаад гэмшлийн талаар сургаал бэлдэнэ үү.

20-р Хичээл - ИТГЭЛ

Итгэл бол Христ итгэлийн суурь ойлголт учир нь бид итгэлээр аврагдсан. (Ефес 2:8). Христ хүмүүсийн дунд байхдаа нэг л зүйлийг тэндээс хардаг байсан нь итгэл юм.

Та дараах болсон явдлуудыг санаж байна уу?

1. Сирофоеник гаралтай эмэгтэйн тууштай итгэл гардаг. (Марк 7:26).
2. Зуутын даргын даруу итгэл (Матт. 8:8-10).
3. Хараагүй боловч чин сэтгэлээсээ итгэсэн хүн (Марк 10:51).

1. Итгэлийн тодорхойлолт

- a. Итгэл бол найдах, үнэнч байдал шудрага байх юм. (Евр. 11:1) Эзэн Есүс Христэд итгэх хувийн итгэлээр бид аврагддаг.
- b. Авралд хүргэх хоёр төрлийн итгэл байдаг:
 - i. Бодол санаандаа итгэх - Христийн тухай түүхийг судлаад Библийг хүлээн зөвшөөрөх итгэл.
 - ii. Зүрхэндээ итгэх - Зүрхэндээ итгэн хүлээж аваад түүнийхээ дагуу үйлддэг итгэл. Христэд итгэх жинхэнэ итгэл нь Түүнийг хүлээн авч итгэх юм. (Иох. 1:12; Кол. 2:6). Мэдлэг болон хүлээн зөвшөөрөлтөөр итгэх нь хангалтгүй юм. Жинхэнэ итгэл бол үйлдэлтэй байдаг. (Иак. 2:26).

2. Итгэлээс гардаг үр дүн:

- a. Бид итгэлээр аврагдсан. (Эхл. 15:6; Ром 5:1; Гал. 3:26).
- b. Бид итгэлээр ариусгагдсан (Үйлс 26:18).
- c. Амралт, амар тайван, баталгаатай байдал болон баяр хөөр итгэлээс ирдэг (Иса. 26:3; Фил 4:6; Евр. 4:1-3; 1 Пет. 1:5).
- d. Бид итгэлээр дамжуулан Бурханы ажлыг хийдэг. (Евр. 11:32-40; Мат. 21:21; Иох 14:12).

Ярилцах: Бодол санаандаа болон зүрхэндээ итгэхийн жишээг ярилцана уу.

21-р Хичээл - ДАХИН ТӨРӨЛТ БА ШИНЭЭР ТӨРНӨ ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

Дээрээс дахин төрөхгүйгээр итгэгч болно гэдэг боломжгүй.

1. Дахин төрөлт гэж юу вэ?

- a. Дахин төрөлт гэдэг нь баптисм биш юм. Баптисм бол тэр хүн Итгэгч гэдгийг харуулсан сүмийн ёслол.
 - b. Энэ бол зүгээр нэг өөрчлөлт биш юм. Өөрчлөлт бол хүн өөрөө гэм нүглээсээ эргэх үйлдэл.
 - c. Дахин төрөлт гэдэг нь сүнсээр сэргэх, эргэлт хийж шинэ бүтээл шинээр төрөх юм. (2 Кор. 5:17; Ефес 2:1).
- 2. Яагаад шинээр төрөх хэрэгтэй вэ?**
- a. Хүн бүр дахин төрөх хэрэгтэй энэ бүх хүнд хамаатай. (Иох 3:3-7); Гал. 6:15).
 - b. Хүний гэмт байдал шинэ төрөлтийг шаарддаг. (Иох. 3:6; Иер. 13:23; Ром 7:18; Ром 8:8).
 - c. Бурханы ариун байдал шинэ төрөлтийг хүсдэг (Евр. 12:14).
- 3. Дахин төрөх замууд**
- a. Дахин төрөлт бол дээрээс ирдэг. (Иох. 1:13; Тит 3:5; Иох. 3:5). Энэ бол тэр чигээрээ Бурханы хийх ажил.
 - b. Дахин төрхийн тулд хүн өөрөө бас алхам хийх хэрэгтэй. Иохан 1:12, 13-т хүний зүгээс болон Бурханы зүгээс гэсэн хоёр элементийг ийнхүү хэлсэн: Түүнийг хүлээж авсан нэгэн нь Бурханаас төрсөн юмаа.

Дүгнэлт: Хүн сайн мэдээний тухай сонсоод хүлээн авснаараа дахин төрдөг. (1 Кор. 4:15; Иак. 1:18; 1Пет. 1:23), мөн хувьдаа Есүс Христийг хүлээн авснаараа дахин төрнө. (Иох 1:12, 13; Гал. 3:26).

22-р Хичээл - ЗӨВТ БАЙДАЛ

- 1. Утга агуулга**
- a. Зөвт байдал гэдэг нь Бурханы өмнө ямар байр суурьтай зогсох тухай юм. Дахин төрөлт нь итгэгчийн дотоод байдалд гардаг өөрчлөлт бол зөвт байдал бол Бурханы өмнө ямар байр суурин дээр зогсох тухай юм. Энэ нэг зүгээр нэг уучлал бус харин Бурханы өмнө зөв гэж тооцогдох нь юм.
 - b. Зөвт байдал гэдэг нь Христэд итгэлээ тавьсан хүмүүс Бурханаар зөвтгөгдөж Түүний нүдэнд гэм нүглээс чөлөөгдсөн гэсэн утгатай юм.
- 2. Зөвт байдал нь хоёр элементээс бүрддэг:**
- a. Гэм нүглээс уучлагдаж шийтгэл, гэм буруугаас чөлөөлөгдөнө. (Мика 7:18; Үйлс 13:38; Ром 8:1, 33, 34).

- b. Христийн зөвт байдлаар Бурханы таалалыг олох (2 Шастир 20:7; Иак. 2:23, Ром 5:17-21).

3. Зөвт байдалд хүрэх арга зам

- a. Хуулийг дагаснаар зөвтгөгдөхгүй (Ром 3:20, 28, Гал. 2:16, 3:10). Бурханаас ирэх үнэгүй ивээлээр (Ром. 3:24)
- b. Есүс Христийн цусаар - ивээлээр зөвтгөгдөнө. (Ром 3:24; 5:9; 2 Кор. 5:21; Евр. 9:22).
- c. Есүс Христэд итгэснээр - зөвт байдалд хүрэх нөхцөл (Гал. 2:16; Ром. 3:26; Гал. 3:10; Үйлс 13:39).

Ярилцах сэдэв - Зөвт байдал нь уучлалаас хэрхэн ялгаатай вэ?

23-р Хичээл - ҮРЧЛЭЛ

1. Үрчлэл гэдэг нь ямар утгатай вэ?

Үрчлэл гэдэг нь Ромчуудын тодорхойлсноор өөр хэн нэгний хүүг өөрийн болгож аваад төрсөн хүүхэд шигээ хандахыг хэлдэг. (Гал. 4:5; Ром 8:15, 23; Ром 9:4; Ефес 1:5).

Гэтлэл 2:10-т болон Еврей 11:24-т хоёр төрлийн үрчлэлийн тухай өгүүлдэг.

2. Үрчлэлээр ирэх ивээлүүд:

- a. Бид Бурханаар хайрлагдах болсон (Иох. 17:23) мөн Бурхан Эцгийн хайр халамжийг хүртэгчид болсон. (Лук 12:27-33).
- b. Бид овогтой болсон (1 Иох. 3:1; Ефес 3:14, 15), Бурханы гэр бүлд багтсан (Ром 8:29); гэр бүлийн хайр (Иох. 13:35; 1 Иох. 3:14); үрчлэлийн сүнсийг авсан (Ром 8:15; Гал. 4:6); гэр бүлийн үйлчлэл (Иох. 14:23, 24 ба 15:8).
- c. Бид Бурхан аавын сахилгажуулалт (Евр. 12:5-11); Аавын тайвшрал (Иса. 66:13; 2 Кор. 1:4) болон өв залгамжлал (1 Пет. 1:3-5; Ром 8:17) хүртэх болсон.

3. Бурханы гэр бүлд үрчлэгдсэн нэгний амьдрал:

- a. Сүнсээр удирдуулна (Ром 8:4; Гал. 5:18).
- b. Аавдаа очсон хүүхэд адил итгэл дүүрэн байна (Гал. 4:5, 6).
- c. Бурхан руу хэзээ ч хандаж чадна (Ефес 3:12).
- d. Ахан дүүсдээ хайртай болно (1 Иох. 2:9-11, 5:2).
- e. Дуулгавартай болно (1 Иох. 5:1-3).

Ярилцах сэдэв - Бурханы боол байх болон Бурханы хүү байхын ялгаа юу вэ?

24-р Хичээл - АРИУСГАЛ

Зөвт байдал гэдэг нь Бурхан бидний төлөө юу хийсэн тухай байдаг бол ариусгал нь Бурхан бидний дотор хэрхэн ажлаа хийдэг тухай юм.

1. **Ариусгалын утга учир.** Ариусгалд хоёр ойлголт багтана.
 - a. Бузар муугаас салах. Ариусгал гэдэг нь сүнс болон биеийг бохирдуулах бүх зүйлсээс эргэлт хийх юм. (2 Шастир 29:5; 15-18; 1 Тес. 4:3).
 - b. Бурханд өөрийгөө зориулах (Лев. 27:14, 16; Тоол. 8:17; Иох. 10:36). Бурханы үйлчлэлд тусгайлан зориулагдсан бүхэн ариусгагдсан.
 - c. Бурханд ашиглагдахын тулд (Езек. 36:23).
2. **Ариусгалд хүрэх хугацаа.** Ариусгал нь өнгөрсөн, одоо, ирээдүй үед байж болох ба мөн аажмаар ариусах эсвэл нэг дор ариусгагдаж болно.
 - a. Тухай мөчид ариусгагдах (1 Кор. 6:11; Евр. 10:10, 14). Христэд итгэх энгийн үйлдээр дамжуулан ариусгагдсан нэгэн болж болно.
 - b. Аажмаар ариусгагдах (2 Пет. 3:18; 2 Кор. 3:18; 1 Тес. 3:12). Бид нэг түвшингээс нөгөө түвшинд, алдраас алдарт шинэчлэгддэг.
 - c. Бүрэн төгс ариусгал (1 Тес. 5:23; 1 Тес. 3:13).
3. **Ариусгалд хүрэх арга.** Ариусгал нь Бурхан ба хүн хоёрын хамтын хүчээр хүрдэг зүйл.
 - a. Бурханы талаас Гурвалаар оршигч түүний хийх ажил
 - i. Бурхан Аав (1 Тес. 5:23, 24; Иох. 17:17).
 - ii. Түүний Хүү Есүс (Евр. 10:10; Ефес 5:25, 27; 1 Кор. 1:30).
 - iii. Ариун Сүнс (1 Пет. 1:2; 2 Тес. 2:13).
 - b. Дотроосоо ариусах
 - i. Христийн зөвт байдал дотор Бурханы тааллаар сэргэх. (2 Шастир 20:7; Иак. 2:23; Ром 5:17-21).
 - ii. Есүс Христийн хийсэн авралаар дамжуулан ариун амьдралаар амьдарч өөрт байгаа бүх хэрэгцээг Христийн алдар дотор хангагдана хэмээн мөч бүрийг Есүс Христэд таалагдан амьдрах (1 Кор. 1:30).
 - iii. Бичээсийг судлан дуулгавартай амьдрах (Иох. 17:17; Ефе. 5:26; Иох. 15:3).

Ярилцах сэдэв: Ариусгалын хугацаа болон ямар дараалалаар явагддаг талаар ярилцана уу.

25--р Хичээл - ЗАЛБИРАЛ

Итгэгч хүний амьдрал залбиралгүйгээр оршин тогтнох боломжгүй юм. Залбирал бол Христэд итгэгчдийн амьсгал мөн.

1. Залбирлын ач холбогдол

- a. Залбирахгүй байхад Бурхан гунигладаг. (Иса. 43:21, 22; Иса. 64:6,7).
- b. Залбираагүйгээс болж маш олон бузар муу зүйл болдог. (Зеф. 1:4-6; Дан. 9:13, 14).
- c. Залбирлыг тоохгүй байх нь гэм. (1 Сам. 12:23).
- d. Байнга залбир гэдэг нь залбиралд өөрсдийгөө зориул гэсэн үг. (Кол. 4:2; 1 Тес. 5:17).
- e. Залбирал нь Бурханаас бидэнд өгөх бэлгийг авах арга зам юм. (Дан. 9:3; Матт. 7:7-11; 9:24-29; Лук 11:13).
- f. Элч нар залбирал бол хамгийн чухал ажлуудын нэг байсан. ((Үйлс 6:4; Ром 1:9).

2. Хэрхэн залбирах вэ? Залбирал 4 хэсгээс бүрддэг. товчилсон АСТС гэсэн үгийг санаарай.

- a. Түүний хүндлэх - Бурханыг магтан хүндлэх (Дуул. 95:6).
- b. Гэм нүглээ улайх - (Дуул. 32:5).
- c. Талархах - (Фил. 4:6).
- d. Хүсэлтээ мэдүүлэх - бусдын төлөө гуйх, залбирал, зуучлан залбирал болон талархал өргөх (1 Тим. 2:1).

3. Залбиралд саад болдог зүйлс

- a. Итгэлгүй байдал (Иак. 1:6-7).
- b. Үл уучлалын сүнс (Марк 11:25).
- c. Хорон муу санаа (Дуул. 66:18).

- d. Буруу хандлагаар залбирдаг (Иак. 4:3).
4. **Залбиралтай холбоотой амлалтууд** - Марк 11:24; Иох. 15:7; 1 Иох. 5:14, 15; Еф. 3:12, 20; Фил. 4:6; Мат. 7:7,8; Ликэ 11:9-13; Евр. 4:16.

Ярилцах сэдэв: Сүүлийн үед Бурхан таны залбиралд хариулсан гэрчлэлээ хуваалцана уу. Мөн одоо юуны төлөө залбирч байна вэ?

ЗУРГААДУГААР ХЭСЭГ

ЧУУЛГАНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

26-р Хичээл - Чуулганы суурь ба ойлголт

Бурханы хамгийн нэн тэргүүний ажил бол чуулганууд цуглах юм.

1. Сүмийн тухай ойлголт

- a. Христийн сүм нь Шинэ Гэрээний Пентокостийн үеэс үүссэн ба Христийн дахин ирж дээш аваачих өдөр хүртэл төгсгөл болох нэгдэл юм.
- b. Түүхээс үзвэл чуулган Пентокостийн үер Сүнс дээш өргөгдөх үед үүссэн гэж үздэг. (Үйлс 2:47; 1:13; 5:12, 2:46, 12:12).
- c. Сүм гэдэг үг нь Грекээс гаралтай Еклесиа гэдэг үгнээс гаралтай ба дуудагдсан хүмүүсийн цугларалт гэсэн утгатай. Христ итгэлт хүмүүс дэлхийн системээс тусдаа Христ дотор байх тухай ойлголт юм. (1 Кор. 1:2).
- d. Сүм гэхээр хэсэг бүлэг итгэгч нарын цуглах газар гэж ойлгож болно. (Кол. 4:15)
- e. Мөн дэлхий дээр байгаа бүх итгэгчдийн цугларалтыг ч хэлж болно. Үүнд дэлхийн өнцөг булан бүрт байгаа итгэгч хүмүүс орно.
- f. Бидний нүдэнд харагдах сүм нь тухайн цуглаанд нэр нь орсон хамрагдаж байгаа итгэгч мөн итгэгч бус хүмүүсээс бүрддэг. Мөн үл үзэгдэх сүм буюу Хурганы амийн номонд нэр бичигдсэн хүмүүс бас орно. (Илч. 21:27).
- g. Чуулганы ялагчид гэдэг нь аль хэдийн тэнгэрийн улс руу явсан хүмүүс юм.

2. Чуулганыг байгуулагчид

- a. Чуулган нь Петрийн хэлсэнчлэн Есүс Христ дээр тулгуурлан байгуулагдсан байсан, байгаа байх Аврагч Бурханы Хүү дээр үндэслэн байгуулагдсан. Бидний Эзэн Петр дээр үндэслэн сүмээ байгуулаагүй харин Петрийн хэлсэн үнэн дээр тулгуурлан байгуулсан.
- b. Түүхэнд Пентокостийн үеэр Сүнс тэдэн дээр буух үед сүм чуулган үүссэн гэж үздэг. (Үйлс 2:47, 1:13, 5:12, 2:46, 12:12).

Ярилцах сэдэв: Чуулганы гишүүн байх тал дээр ямар алдаа мадагтай ойлголт байдаг вэ?

27-р Хичээл - ЧУУЛГАНЫ ЗОРИЛГО БОЛОН ГИШҮҮНЧЛЭЛ

1. Чуулганы гишүүн болох нөхцлүүд

- a. Гэмших (Үйлс 2:38).
- b. Эзэн Есүс Христийг Бурханы Хүү гэж хүлээн зөвшөөрч итгэх (Матт. 16:16-18).
- c. Аврагдаж, дахин төрөлт болон шинээр төрөх (Үйлс 2:47).
- d. Гурвалын нэрээр баптисм хүртэх (Үйлс 2:38).
- e. Элч нарын сургаалыг дагах (Үйлс 2:42).

2. Чуулганы зорилго

- a. Христийг энэ дэлхий дээр магтан алдаршуулах (Ефес 1:4-6).
- b. Сайн мэдээг бусдад тараах (Матт. 28:19-20; Марк 16:15).
- c. Христэд итгэгч нарт заах сургах (Ефес 4:11-15; 1 Тес. 5:11; 1 Кор. 12:1-31).
- d. Хаа сайгүй гэрчлэх (Үйлс 1:8).

Ярилцах сэдэв: Чуулганы гишүүнчлэлийн талаар ямар буруу ойлголтууд байдаг вэ?

28-р Хичээл - ЧУУЛГАНЫ БЭЛЭГ ТЭМДЭГ, ЁСТ ҮЙЛДЭЛ

1. Библид гардаг чуулганы бэлэг тэмдэг

- a. Христийн бие - Христ бол толгой харин бид бол түүний эрхтэнүүд (Кол. 1:18; Ефес 1:22, 23; Кол. 2:19).
- b. Сүм цуглаан, байшин, Бурханы сүнсний орших газар (Ефес 2:20, 21). Христ өөрөө булангын чулуу бид харин барилгын хэсгүүд нь гэсэн.
- c. Христийм сүйт бүсгүй (2 Кор. 11:2). Христ бол сүйт залуу (Иох. 3:29). Тэдний хуримыг Илч. 19:1-т дүрсэлсэн байдаг.

2. Чуулганы ёст үйлдэл

- a. Баптисм - (Матт. 28:19, 20; Марк 16:16; Үйлс 2:38-41; Үйлс 8:36-40; Үйлс 10:47, 48).
- b. Эзний зоог барих (Үйлс 2:42-46; Үйлс 20:7; 1 Кор. 11: 20-34).

Ярилцах сэдэв: Чуулганы гишүүн байна гэдгийг дээр дурдсан хэсгүүдтэй уялдуулан тайлбарлана уу.

ДОЛДУГААР ХЭСЭГ

БИЧЭЭСИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТУУД

29-р Хичээл - БИБЛИЙН ГОЛ УХАГДАХУУН

1. Библийн тухай тоо баримтууд

- a. Библи нийт 66 номноос бүрддэг ба 39 номтой Хуучин гэрээ, 27 номтой Шинэ гэрээ гэсэн хоёр хэсэгт хуваагддаг.
- b. Нийт 1600 жилийн турш дэлхийн өнцөг булан бүрт байгаа янз бүрийн ажил мэргэжилтэй 36-40 хүн бичсэн гэж үздэг.
- c. Хуучин гэрээний Даниел, Езра номноос бусад нь Еврей хэлээр бичигдсэн бол Шинэ Гэрээ нь Грек хэлээр бичигдсэн.
- d. Эхний таван хуулийн ном нь шашины гаралтай хамгийн олон жилийн өмнө бичигдсэнд тооцогддог.
- e. Библи 16 зууны турш бичигдсэн ба анхны бичсэн хүн библийн сүүлийн номыг бичсэн хүнийг төрхөөс 1450 жилийн өмнө нас барсан байна.

2. Библийн утга санаа

- a. Грекээр теопностос буюу Бурхан амьсгалсан гэсэн утгатай. (2 Тим. 3:16).
- b. Бурханы ариун хүмүүс Ариун Сүнсээр удирдуулан Түүний тушаасны дагуу алдаа мадаггүй бичигдсэн бичээс юм.

3. Бурханы амьсгал эдгээр зүйл дээр байсан:

- a. Зохиогч нарт (2 Пет. 1:21)
- b. Бичээс дээр (2 Тим. 3:16).
- c. Үгнүүд дээр (1 Кор. 2:13; 2 Пет. 3:2)

Ярилцах сэдэв: Библи таньд юугаараа илүү өвөрмөц санагддаг вэ?

30-р Хичээл - БИБЛИ ДЭЭР ХОЁР УДАА ДАВТАГДДАГ ДОЛООГИЙН ТОО

1. Библийн долоон гайхамшиг

- a. Библи бичигдсэн гайхамшиг - Библийн нэг ном нэг газар нэг хэл дээр бичигдсэн ба хэдэн зууны дараа өөр ном өөр хэл дээр бичигдсэн ч зөрдөггүй.

- b. Маш нэгдмэл ном - Хэдийгээр 66 номноос бүрддэг ч Ариун Сүнсээр удирдуулсан нэг ном ба утга агуулга нь уялдмал.
- c. Маш урт настай ном - Хамгийн эртний номонд ордог.
- d. Бүх хүмүүсийн анхаарлыг татдаг - Энэ номыг хүн төрлөхтөн нас, гарал үүсэл, хөгшин залуугүй уншсан ном.
- e. Маш баялаг үгтэй - хэдийгээр боловсролгүй хүмүүсээр бичигдсэн ч утга зохиолын дахин давтагдашгүй бүтээл болсон.
- f. Хүний өөрийгөө харах толь (Иак. 1:23, 25).
- g. Шатаах гал мэт (Иер. 20:9 ба 23:29).

2. Бурханы үгийн бэлэг тэмдэг болсон долоон илэрхийлэл

- a. Хоёр талдаа иртэй сэлэм (Евр. 4:12).
- b. Чулуу бутлах алх (Иер. 23:29).
- c. Дахин төрүүлэх амьд үр (1 Пет. 1:23).
- d. Сүнсний хоол (1 Пет. 2:2; 1 Кор. 3:2; Ром 10:17).
- e. Итгэгчдийг өдөр бүр удирдах гэрэл (Дуул. 119:105).
- f. Устгагдаж үгүй болоогүй - Хаадууд, эрх мэдэлтнүүд энэ номыг шатааж устгах гэж оролдсон ч Бурхан хамгаалсаар ирсэн.
- g. Итгэгч нэгнийг өдөр ч шөнө ч удирдах дэнлүү (Дуул. 119:105).

Даалгавар: Дээр дурдсан шинжүүдээс нэгийг нь ашиглан зүйрлүүлсэн үзүүлэнтэй хичээл бэлдэнэ үү.

31-р Хичээл - ЯАГААД БУРХАНЫ ҮГИЙГ ТУНХАГЛАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

1. Бурханы үг тунхаглагдаж байхад хүмүүс гэм нүглээ хүлээн зөвшөөрдөг. (Үйлс 2:14; 37) Пентекостын үеэр Петр 23 ишлэл иш татсаны 9 ишлэл нь Хуучин Гэрээ номноос байсан.
2. Итгэл нь Бурханы үгийг сонсохоос ирдэг. (Ром 10:17).
3. Бурхан үг биднийг ариусгадаг (2 Кор. 7:1). Бурханы үг амлалтуудыг өгсөн.
4. Мөнх амьтайг баталгаажуулдаг (1 Иох. 5:13).
5. Библид бичигдсэн үгээр Бурханы тайвшрал ирдэг. (1 Тес. 4:18).
6. Бурханы үгээр үнэн ирдэг. (Үйлс 17:11).
7. Шинэ төрөлт Бурханы үгээр ирдэг (1 Пет. 1:23).

Дүгнэлт: Есүс болон Ариун Сүнсийг Бурхан бидэнд бэлэг болгон өгснөөс гадна Түүний үг бол энэ дэлхийд өгсөн агуу бэлэг юм.

НАЙМ ДУГААР ХЭСЭГ СҮНСЛЭГ БИЕТҮҮДИЙН ТУХАЙ

32-р Хичээл - ТЭНГЭР ЭЛЧ НАРЫН ТУХАЙ БИБЛИ ЮУ ХЭЛДЭГ ВЭ?

1. Тэнгэр элч нарын тухай Библид

- a. Сара Хагартай ширүүн харьцсаны дараа Эзэний тэнгэр элч Хагарт тусалдаг. Эхлэл 16:7-д Тэнгэр элч гэдэг үг анх удаа бичигдсэн.
- b. Хуучин гэрээнд элч нарын тухай олон тохиолдолуудыг бичсэн байдаг. (Дуул. 104:4; Дан. 10:12, 13; 2 Сам. 14:20; Дуул. 103:20; 2 Хаад 19:35; 2 Сам. 24:15, 16).
- c. Есүс тэнгэр элч нарт итгэсэн (Матт. 18:10; Марк 13:32 болон Матт. 13:41, Матт. 26:53).
- d. Паул элч нарт болон тэнгэр элчид итгэсэн (2 Тес.1:7; Кол. 2:18; Иох 1:51; Илч. 12:7 болон 22:9; 1 Пет. 3:22; 2 Пет 2:11; Иуда. 9).

2. Тэнгэр элч нарын мөн чанар

- a. Тэд Түүгээр бүтээгдсэн биетүүд болхоос өөд болсон нэгний сүнс биш. (Кол. 1:16).
- b. Тэд үл үзэгдэх биетүүд боловч (Дуул. 104:4) заримдаа бодит байдлаар үзэгддэг. (Эхл. 19; Шүүгч 2:1 болон 6:11-22; Матт. 1:20; Иох. 20:12).
- c. Тэд хүч чадалтай (Дуул. 103:20); 2 Хаад 19:35; 2 Сам. 24:15, 16).
- d. Тэд үхэшгүй (Лук 20:35, 36).
- e. Тэд тоо томшгүй (Илч. 5:11; Евр. 12:22; Матт. 26:53).
- f. Тэд Бурханыг магтан алдаршуулдаг: бүтээлийг магтана (Иов 38:6,7); Бүтээгчийг төрөх үед магтдаг (Лук 2:13, 14) мөн Сэнтийд залрах үед магтана (Илч. 5:11).

3. Тэнгэр элчийн уналт

Тэнгэр элчүүд анх сайнаар бүтээгдсэн боловч тэдний зарим нь унадаг. (2 Петр 2:4; Иуда 6). Тэдний унасан шалтгааныг бид мэдэхгүй ч, Сатаны хувьд түүний бардам зан, дуулгаваргүй байдлаас болж унасан. (Езек. 28, Иса. 14:12).

Ярилцах сэдэв - Сатаны уналтын тухай өгүүлсэн ишлэлүүдийг судлаад, яагаад унагаагдсан тухай ярилц.

33-р Хичээл - ТЭНГЭР ЭЛЧҮҮДИЙН ҮҮРЭГ

1. Унагаагдсан тэнгэр элчүүд хамаг хүчээ дараах ажилд хандуулдаг:
 - a. Бурханы зорилгыг няцаах (Дани. 10: 10-14).
 - b. Бурханы хүмүүсийг хүлэх (Лук 13:16; Матт. 17:15-18).
 - c. Сатан өөрийнхөө зорилгыг биелүүлэх (Матт. 25:41 болон 12:26, 27).
 - d. Бурханы хүмүүсийн сүнслэг амьдралд саад бэрхшээл авчрах (Ефес 6:12).
 - e. Бурханы хүмүүсийг мэхлэх (1 Сам. 28:7-20).
 - f. Тэд нарт аврагдах найдвар байхгүй, тэдний төгсгөл бол мөнхийн галт нууранд хаягдах. (Иуда 6:2; 2 Пет 2:4; Матт. 25:41).
2. Бурханы итгэмжит тэнгэр элч нарын ажил
 - a. Тэнгэрт: Эзэн Бурханыг хүндэлж, магтан үйлчлэх (Илч. 5:11-12, 8:3-4).
 - b. Газарт: Эзнийг ажлыг гүйцэлдүүлэх; жишээ нь Хагарт булаг гаргаж өгөх, Иошуад сэлэмтэй үзэгдсэн; Петрийн гинжийг таслан шоронгийн хаалгыг нээсэн; Бурханыг хүмүүсийг хооллож, хүчирхэгжүүлж хамгаалсан.
 - c. Бурханы зорилгыг болон шүүлтийг биелүүлэх. (Тоол. 22:22; Үйлс 12:23; Матт. 13:41).
 - d. Итгэгчдийг удирдах (Үйлс 8:26).
 - e. Элч нарт туслах, хамгаалах болон хүчирхэгжүүлэх: Кармел ууланд байсан Елиа-д тусалсан (1 Хаад 19); Арслангын торонд орсон Даниелд тусалсан (Дан. 6:22); Гэтсэмен-д байсан Есүст тусалсан.
 - f. Тэд Бурханы хүүхэд нас барахад тэнгэр өөд авч явдаг. (Лук 16:22).
 - g. Бидний Эзэн буцан ирэх үед тэд даган ирнэ. (Матт. 25:31; 1 Тес.1:7-8).

Ярилцах сэдэв: Та тэнгэр элчийн тусламжыг амьдралдаа авч үзсэн үү?

34-р Хичээл - САТАН БОЛ БУРХАНЫ БОЛОН ХҮМҮҮСИЙН ХАМГИЙН ТОМ ДАЙСАН

1. Сатаны гарал үүсэл
 - a. Езекиел 28:12-19 хэсэгт Сатаны тухай гардаг. Тэр маш үзэсгэлэнтэй тэнгэр элч нарын тэргүүн байсан. Гэвч түүний бардам зан, гэм нүгэл тоо томшгүй хилэнцээсээ болоод тэнгэрээс хөөгддөг.
 - b. Исаяа 14:12-17-р хэсэгт Үүрийн хүү, гялбаат цолмон гэж дуудагдсан. Түүний бардам зан Бурхантай адил болох гэсэн хүсэл нь түүний хөөгдөх шалтгаан болсон.

- c. Сатан нь өөрийн гэсэн бодит оршихуйтай, амьдралтай, ухаантай, сэтгэлийн тэнхээтэй бас мэдрэмжтэй.

2. Сатаны зан чанар

- a. Бурханы үгийг бидний сэтгэлээсээ хулгайлдаг хулгайч (Матт. 13:19).
- b. Тэр зальтай (2 Кор. 11:14).
- c. Тэр бол алуурчин (Иох. 8:44).
- d. Тэр худалч (Иох. 8:44).
- e. Тэр бол мэхлэгч (Илч. 12:9).
- f. Тэр ялагдсан (Лук 10:18).

Ярилцах сэдэв: Танд сатаны энэ дэлхий хийж байгаа зүйл илүү хүчээ авч байна гэсэн мэдрэмж төрж байсан уу? Тийм бол таны бодлоор яагаад ийм байдал болж байгаа вэ?

35-р Хичээл - САТАН БОЛ ЯЛАГДСАН ДАЙСАН

1. Сатаны нэрнүүд:

- a. Гэрлийн элч (2 Кор. 11:14).
- b. Архирах арслан (1 Пет. 5:8).
- c. Агаарын хүчний ноёрхогч (Ефес 2:2).
- d. Харанхуйн хүч (Кол. 1:13).
- e. Хүчит арслан, могой, чөтгөр, Сатан (Илч. 12:9).
- f. Ертөнцийн захирагч (Иох. 14:30).
- g. Эрин үеийн Бурхан (2 Кор. 4:4).
- h. Ёроогүй гүнийн тэнгэрэлч (Илч. 9:11).

2. Сатаны хувь тавилан

- a. Ертөнцийн захирагч зайлуулагдсан (Иох. 12:31; 16:9,10; 1 Иох. 3:8; Кол. 2:15).
- b. Тэр мөнхөд хараагдсан (Эхл. 3:14; Иса. 65:25).
- c. Түүнд бэлтгэгдсэн мөнх галт нууранд хаягдана (Матт. 25:41; Илч. 20:10).

Дүгнэлт: Сатанд хүч байгаач Бурхан түүнээс ч илүү Хүчит Нэгэн. Сатан Голгатын толгод дээр бүрэн ялагдсан. Хурганы цусаар дамжуулан ялалт биднийх гэдгээ байнга тунхаглан амьдарцгае.

ЕС ДҮГЭЭР ХЭСЭГ ЭЦСИЙН ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

36-р Хичээл - ХРИСТИЙН ДАХИН ИРЭЛТ

Христийн дахин ирэх тухай Шинэ Гэрээний 260 бүлэгт 318 удаа давтагддаг ба 25 ишлэл бүрт дурдагдсан. Библийн 30 ишлэл тутамд энэ ойлголтыг гаргаж ирдэг. Эзэн дахин ирэх тухай гарах бүрд түүний дахин ирэлтийн тухай 8 удаа давтан баталгаажуулсан.

1. Христийн дахин ирэлтийн тухай Библи бидэнд юу хэлдэг вэ?
 - a. Тэр өдөр хулгайч ирэхдээ адил гэнэт ирнэ гэсэн. (1 Тес. 5:2).
 - b. Христ бидний бодоогүй цаг үед ирнэ гэсэн. (Матт. 24:44, 50).
 - c. Эзэн үүлэн дээр бууж ирэхэд нүд бүхэн түүнийг харна гэсэн (Илч. 1:7).
 - d. Эзэн бүрэн дуунаар тэнгэрээс бууж ирэхэд үхэгсэд эхлээд амилан агаарт уулзаж дараа нь амьд үлдсэн хүмүүс агаарт Эзэнтэй уулзана гэсэн (1 Тес. 4:16-17).
 - e. Зарим хүмүүс Христийн ирэлт 2 хэсэгт хуваагдана гэж үздэг. Эхэн хэсэг нь 1 Тес. 5:2-т хэлснээр итгэгч хүмүүст зориулж ирэх ба 1 Тес. 4:16-17 хэлснээр долоон жилийн дараа ирж эцсийн шүүлтийг хийнэ гэж үздэг.
 - f. Сайн мэдээ бүх үндэстэнд хүрсэн цагт төгсгөл ирнэ. (Матт. 24:14).
2. Түүний ирэх шинэ тэмдэг
 - a. 2 Тимот 3:17-д Түүнийг ирэхээс өмнөх 23 тэмдгийн талаар бичсэн. Эдгээр тэмдгүүд нь хэдийнээ биелэлээ олж эхэлсэн. Матай 24:5-7 болон 12-38 дугаар хэсэгт 10 тэмдгийн тухай бичсэн.
 - b. Есүс иртэл нэгэн зуун байгаа гэж бодож төлөвлөж ажиллаж болох ч өдөр бүр Эзний ирэх өдөр мэт цэвэр ариун амьдралаар амьдрах хэрэгтэй. (1 Тес. 3:12-13).
 - c. Библийн хамгийн сүүлийн залбирал бол “Тиймээ Би удахгүй ирнэ гэж айлдаж байна, Амэн Ирээрэй Эзэн Есүс ээ” байсан (Илч. 22:20).

Ярилцах сэдэв - Түүний ирэх үеийн тэмдэгүүдээс өнөөдөр биелэлээ олж байгаа тэмдэг байна уу?

37-р Хичээл - ҮХЭГСДЭЭС АМИЛУУЛАГДАГСАД

1. Энэ ойлголт нь Библи дээр тод бичигдсэн.

- a. Хуучин Гэрээний ишлэлүүд - Иов 19:25-27; Дуулал 16:9 болон Даниел 12:1-3. 1 Хаад 17; 2 Хаад 4:32-35 болон 13:21 дээр дахин амилсан түүхүүд бичигдсэн.
- b. Шинэ Гэрээний ишлэлүүд - Есүсийн сургаал (Иох 5:28, 29 болон 6:39, 40, 44, 54; Лук 14: 13, 14 болон 20:35, 36) мөн элч нарын сургаал (Үйлс 24:15; 1 Кор. 15:1; 1 Тес. 4:14-16; Фил. 3:11; Илч. 20:4-6, 13).

2. Биеийн амилал

- a. Итгэгчид - 1 Кор. 15
 - i. Мах цустай бие биш (1 Кор. 15:50).
 - ii. Сүнс юмуу үл үзэгдэх зүйл биш (Лук 24:39).
 - iii. Үл муудах байдал дотор амилуулагдана. Ямар ч өвчин шаналал зовиур байхгүй болно.
 - iv. Алдар дотор амилуулагдана (1 Кор. 15:43), Гэрэлтэн хувирна (Матт. 17; Илч. 1:13-17).
 - v. Ядрахгүй, сул дорой биш хүчирхэг байна (1 Кор. 15:43).
 - vi. Сүнслэг биер амилуулагдана (1 Кор. 15:44).
 - vii. Тэнгэрийн нэгэн мэт байна (1 Кор. 15: 47-49).
- b. Бичээс итгэгч биш хүмүүсийн амилалтын тухай бичээгүй.

3. Дахин амилах цаг

- a. Зөвт хүмүүс буюу итгэгч нарын дахин амилалт нь Христийг ирэх үетэй холбоотой. (1 Кор. 15:13; 1 Тес. 4:14-17).
- b. Иохан 5:28-29, Даниел 12:2; Илч. 20:5; Илчлэлт 20:12-т хэлсний дагуу Эзний өдөр ойртох үед бузар мууг үйлдэгчид шүүлтийн өдөр дахин амилуулагдана. Илчлэлт 20:4-6-д хэлэхдээ зөвт хүмүүсийн амилалт бузар муу хүмүүсийн амилалтын хооронд 1000 жил байна гэсэн.

Дүгнэлт: Бидний амилсан бие одоо байгаа биеэс ямар ялгаатай байх вэ?

38-р Хичээл - ШҮҮЛТИЙН ӨДӨР

Бузар мууг үйлдэгчид шүүгдэж, зөвт хүмүүс шагналаа авах шүүлтийн өдөр тогтоогдсон. (Үйлс 17:31; Евр. 9:27). Загалмайд цовдлогдсон нэгэн Хаан ширээндээ суух шүүгч бол Христ. (Иох. 5:22, 23, 27; 2 Тим. 4:1; 2 Кор. 5:10; Үйлс 10:42 болон 17:31).

Дахин амилалт нэгээр дуусаагүйн адил шүүлтийн өдөр ч бас нэгээр дуусахгүй. Ноагийн өдрүүдэд үер болж шүүгдэж байсан бол Бабелийн цамхагт хэлийг хутгалдуулан самууруулдаг.

Библи дээр долоон өөр төрлийн шүүлтийн тухай өгүүлдэг:

1. **Загаламай дээрх шүүлт:** Итгэгч хүмүүсийн дээр байдаг Сатаны хүчийг таслан итгэгчдийн гэм нүглийг модон дээр биедээ үүрсэн. (Иох. 5:24; 1 Пет. 2:24).
2. **Итгэгчид өөрсдийгөө шүүх өдөр** (1 Кор. 11:31-32).
3. Итгэгчид үйлсийнхээ төлөө шүүгдэхээр Христийн шүүх суудлын өмнө гарч ирнэ (2 Кор. 5:10). Христийн хоёр дахь ирэлтийн үед **итгэгч нар** хийсэн үйлсийнхээ төлөө **шүүгдэнэ**. Тэдний зарим нь итгэл үйлс нь галар шалгагдсан ч итгэмжиж байсныхаа төлөө шагналаа хүртэх болно. (1 Кор. 3:13).
4. Сүүлчийн өдрүүдэд **еврейчүүдэд ирэх шүүлт** (Езек. 20:34-38; Иер. 33:7; Лук 23:18; Үйлс 7:51).
5. Христийн хоёр дахь ирэлт Иехошафатын хөндийд **бүх үндэстнүүдийг цуглуулан шүүнэ**. (Иоел 3:2; Матт. 25:41 ба 34).
6. **Унагаагдсан элч нарын шүүлт** (1 Кор. 6:3; Иуд. 6; 2 Пет. 2:4).
7. Дахин төрөөгүй, эхний амилуулалт дээр амилагдаагүй, дээш авагдаагүй **үхэгсдийн шүүлт**. (Илч. 20: 12) Энэ н; Цагаан өнгөтэй агуу сэнтийд (Илч 20:11) болох ба мянган жилийг дуустал амилахгүй (Илч 20:5). Амийн номд нэр нь байхгүй хүмүүст галт нуурт хаягдана. (Илч. 20:15).

Ярилцах сэдэв - Аль шүүлт таны санааг хамгийн их зовоож байна?

39-р Хичээл - БУРХАНГҮЙ ХҮМҮҮСИЙН ЭЦСИЙН ХУВЬ ТАВИЛАН

Шинэ гэрээнд гэм нүглээ хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсийн тухай 162 ишлэлд гардаг ба тэдний 70 нь Есүсийн үг байдаг. Христийг эсэргүүцэгч гэм буруутнууд тамд хаягдана гэсэн. (Дуул. 9:17).

1. Там гэж юу вэ?

- a. Бурханы оршихуйгаас хөөгдсөн газар (2 Тес. 1:9).
- b. Зовж тарчилсан газар (Лук 16:23).

2. Тамын дүр зураг

- a. Анхнаасаа диавол болоод түүний тэнгэр элч нарт бэлтгэсэн мөнх гал. (Матт. 25:41). Мөн Аврагчаар дамжуулан тэнгэрийн улсад орно гэдгийг эсэргүүцэгчид сатантай хамт тамд очно.
- b. Мөнхөд шийтгэгдсэн газар (Матт. 25:46).
- c. Зовж тарчилах газар (Лук 16:23).
- d. Мөнх галтай газар (Матт. 13:42, 50; Илч. 20:15; Илч. 14:10; Матт. 3:12; Иса. 33:14).
- e. Өт хорхойтой газар (Марк 9:44, 46, 48).
- f. Лук 16-р бүлэгт тамд очсон хүн хэрхэн залбирч, ус хайж, ах дүү нараа тийшээ ирүүлэхгүй байх талаар хүсдэг ч хариултаа авдаггүй. (Лук 16:23, 24-27).
- g. Там бол мөнхийх

Дүгнэлт - Мөнхийн шийтгэлийн тухай мэдсэнээр бид төөрсөн хүмүүст хүрэх ажлаа илүү эрчимтэй хийх хэрэгтэй.

40-р Хичээл - ЗӨВТ НЭГНИЙ ШАГНАЛУУД

Итгэгч хүний үхэл бол Бурханы оршихуйд очих замдаа Есүс Христтэй хамт унтаж байгаатай адил юм. (1 Тес. 4:14; Фил. 1:23).

1. Итгэгч хүмүүсийн ирээдүйн алдар

- a. Христтэй хамт байна (Иох. 14:3).
- b. Түүний царайг харна (Дуул. 17:15; Рэв. 22:4).
- c. Христийн алдрыг харна (Иох. 17:24).
- d. Христтэй хамт алдаршуулагдана (Ром. 8:17, 18).
- e. Христтэй хамт хаанчлана (2 Тим. 2:12).
- f. Бүх зүйлийн өв залгамжлагч болно (Илч. 21:7).
- g. Од мэт гялалзана (Дан. 12:3.).

2. Итгэгч хүмүүсийн хүлээн авах титэм

- a. Ялзардаггүй титэм (1 Кор. 9:24-25).
- b. Сүнснүүдийг дагуулагч титэм (1 Тес.2:19).
- c. Зөвт байдлын титэм (2 Тим. 4:8). Бүх хүн энэ титмийг авах боломжтой.
- d. Үхэх хүртлээ итгэмжтэй байсан амийн титэм (Иак. 1:12; Илч. 2:10). Сорилтыг тэсвэрлэгчдийн титэм.
- e. Пастор, миссионер, багш нар болон хоньчдод өгөгдөх титэм. (1 Пет. 5:4).

3. Тэнгэрийн улс гэж юу вэ?

- a. Бурханы орших гэр. (Матт. 6:9; 2 Кор. 12:2). “Анхны тэнгэр” нь шувууд нисэх газар бол хоёр дахь тэнгэр нь сансрын нисгэгчид нисдэг орон, “Гурав Дахь Тэнгэр” буюу Бурхан гэр.
- b. Хүний гараар бус Бурханаар бүтээгдсэн байшин. (2 Кор. 5:1).
- c. Аавын гэр (Иох. 14:2).
- d. Нулимс, уйтгар гуниг, өвчин зовлон, үхэл байхгүй газар. (Илч. 21:4). Шөнө гэж байхгүй, өлсгөлөн, цангаа болон аймшигт халуун гэж байхгүй (Илч. 7:16).
- e. Амын гол, амын мод, шинэ гэрэл, үйлчлэл бүх юм шинээр бүтээгдсэн газар (Илч. 22:4).

Дүгнэлт: Тэнгэрийн улс бол бол итгэгчид зориулан бэлдсэн газар. Түүний төлөө хичээнгүй зүтгэсэн итгэлийн ахан дүүстэйгээ энэ газар хамтдаа очихын төлөөр урагшаа!

НОМЛОЛ

Толь бичигт дурьдсанаар номлол нь сургаал заах болон номлол хийх гэсэн утгатай үг бөгөөд энэхүү хичээл нь оюутан бүрд хэрхэн үр бүтээмжтэй номлол хийх болон сургаал заахад өөрийгөө хөгжүүлэх тал дээр туслах зорилготой юм. Номлол номлох нь зөвхөн олон хүний өмнө гарч зогсоод ярихаас илүү утга учиртай зүйл гэдгийг энд онцгойлон тэмдэглэн үлдээх нь зөв юм. (1Коринт 2:1,4,5) Номлол нь Бурханы үгийг сонсож буй хүмүүсийн зүрхэнд хүрэх ажил гэж хэлж болно (Иеремиа 1). Паул энэ талаар итгэлтэйгээр онцлон хэлэхдээ: Загалмайн үг нь мөхөгсдийн хувьд мунхаг явдал боловч аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн. (1 Коринт 1:18) Энэхүү хичээлээр дамжуулан та бүхэн номлолийг хэрхэн төгс, үр бүтээмжтэй хийх талаар маш сайн суралцаж, түүгээрээ дамжуулан Бурханы аврал болон сургааль олон хүнд хүрээсэй хэмээн хүсч байна.

Номлолын тухай бүрэн ойлголтыг энэ цөөхөн хуудсанд багтаах боломжгүй ч номлол хийх заавар, арга барил, биеийн хилэмж, дуу хоолойн өнгөний талаар багштай танхимд байгаа мэт ярилцах засч залруулах болох байхгүй ч энэ хичээлээр дамжуулан номлол сургаалийн утга агуулгын талаар зааж тусгай бэлтгэгдсэн номлолуудыг жишээ болгон үзэх болно.

Түргэвчилсэн Библи Судлалын хичээлүүд өдөр өдрөөр хуваарилагдсан байдаг боловч номлолын тухай хичээл нь долоо хоногоор сунаж хуваарилагдсан болно. Тэгснээр оюутнуудад номлолд бэлдэх болон номлол заах дадлага хийх боломж олдож байгаа юм. Энэхүү хичээлийн гарын авлага нь Мүүди прэссд хэвлэгдсэн Виллиам Эвансын “Номлол Хэрхэн Бэлдэх бэ” гэсэн номноос эх авсан болно.

1-р Хичээл - НОМЛОЛ ЮУ ГЭЖ ВЭ?

Номлол нь Бурханы сайн мэдээгээр дамжуулан хүмүүс нэг нэгэндээ авралыг тунхаглахыг хэлнэ. Номлолын үндсэн бүрэлдэхүүн нь хүн, сургааль болон зан чанар ба үнэн юм. Номлогч нь сайн мэдээг түгээх гэсэн онцгой даалгаварыг Бурханаас авсан хүн юм. Тэрээр хүмүүсийн өмнөөс Бурхантай харилцаж мөн Бурханы өмнөөс хүмүүстэй харилцдаг. Номлогч нь хүн чанартай сайн хүн байх ёстой бөгөөд агуу итгэлтэй мөн Ариун Сүнстэй ойр харилцаатай нэгэн байх ёстой. Эдгээр чанаруудыг агуулсан номлогчийн амьдралаар болон сургаалиар олон хүн Бурхан дээр ирэх учиртай билээ (Үйлс 11:24).

Сургаж буй сургаал болон номлол нь түүний амьдралын илэрхийлэл, нэгэн хэсэг бас туршлага нь байх ёстой. Номлогч хүн өөрөө үнэн дотор амьдарч, гэрчилж байж түүнийгээ сургааль номлол болгон бусдад түгээх учиртай.

Ярилцах сэдэв -Үр дүнтэй сургаал заахын тулд Номлогчийн амьдралд байх ёстой чухал чанаруудаас дурьдана уу? Номлогчийн үйлчлэлд хор хөнөөлтэй байж болох зан чанарууд юу бэ?

2-р Хичээл - СУРГААЛИЙН СЭДЭВ

1. **Тодорхой сэдвийн дагуу бэлдсэний давуу талууд их бий. Үүнд:**
 - a. Сонсогчдын анхаарлыг татах: Үүний талаар номлогч юу гэж хэлэх бол?
 - b. Сонсогчдын дунд итгэлийг бий болгоно: Энэ бол Бурханы үг!
 - c. Номлогчид эрх мэдэл болон эр зориг өгөгдөнө. “Бурхан ингэж хэлж байна” гэсэн өгүүлбэр нь тэнгэрийн орноос өгөгдсөн эрх мэдэл юм.
 - d. Номлогчийг эмх цэгцтэй бодож, ярихад туслана .
 - e. Номлогчийг Библийн дагуу ярихад чиглүүлнэ.
2. **Сэдвээ сонгоход баримтлах гол зарчимууд**
 - a. Номлогч нь сонсож буй хүмүүсийн сүнсний хэрэгцээний дагуу бэлдэх
 - b. Хоорондоо уялдаа холбоотой сэдвийн дагуу номлох. Дутуу орхигдсон сэдэв байна уу гэж эргэцүүлэх. Жилийн эхэнд номлох сэдвүүдээ жагсаан бичиж харах нь тустай.
 - c. Номлогч нь өөрийн туршлагад тохирсон сэдвийг сонгох нь чухал. Зарим сэдвүүд нь залуу номлогч нарт хэтэрхий хүнд байх тохиолдол бий.

3. **Сэдвийн сонголтонд тус болох зарим зарчмууд:**

- a. Бурханы Үгийг байнга унших нь чухал
- b. Дэвтэр ашиглах нь маш чухал
- c. Шинэ санаа өгөх сайн бичигдсэн ном унших
- d. Ариун Сүнсний чиглүүлэг бол нэн тэргүүний чухал зүйл юм. Үргэлж Ариун Сүнсний удирдлага болон нөлөөн дор амьдардаг хүн номлоход мэдлэгээр дутахгүй нь лавтай.

Даалгавар: Ойрын хугацаанд номлох сэдвүүдээсээ 10-г жагсаан бичнэ үү

3-р Хичээл НОМЛОЛЫН ҮНДСЭН САНАА

Номлох сэдвээ оновчтой сонгож зөв үгээр илэрхийлэх нь маш чухал. Танд туслаж болох санаанууд:

1. Номлогч нь зааж буй сургаалийн үндсэн санааг бүрэн ойлгох, мэдэх.
2. Номлол нь сонсож буй хүмүүст ойлгомжтой, ойр сэдэв байх.
3. Номлолын сэдэв нь хэт хөнгөн биш харин утга агуулгатай байх
4. Номлогч нь тухай сэдвийн дагуу тодорхой зорилготой байх ёстой бөгөөд сонсож буй хүмүүсийн зүрх сэтгэлд хүргэх түүнчлэн шийдвэр гаргахад нөлөөлөхүйц номлох.
5. Тус сонгосон сэдэв нь цаг үе, оршин буй газар болон тухайн үеийн үйл явдалтай нийцсэн байх.

Жишээ нь Дахин Амилсаны баярын үеэр есүс Христ Эзэний дахин амилсан тухай номлож сургааль заах гэх мэт.

Ярилцах сэдэв - Эзэний өдөр номлоход тохиромжтой сэдвүүдийн талаар ярилцана уу.

4-р Хичээл

НОМЛОЛД ХЭРЭГЛЭГДЭХ МАТЕРИАЛ ЦУГЛУУЛАХ

Ном унших нь номлогчид олон төрлийн санаа олж эргэцүүлэн бодоход тустай. Мөн түүнчлэн тэрээр өдөр бүрийн эргэн тойронд нь болж байгаа үйл явдлыг ажин Бурханы үгтэй холбож ойлгох, бодох хэрэгтэй. Номлогчид болон Христ итгэлт багш нар насан туршдаа суралцан, итгэл дотроо өсөж мөн Бурхан болон Түүний сүр жавхлангийн тухай ойлголтоо тэлж байх нь зүйтэй юм. Есүс Христ маш гярай байсан бөгөөд Түүний сургаалиуд өөрийнх нь үзэж харсан үйл явдалаас үүдэлтэй байсан билээ.

Номлогч хүн бичих дэвтэр байнга биедээ авч явж амьдралд нь өрнөж буй зүйлээс мөн сэтгэлийг нь хөдөлгөсөн үйл явдалаас бичиж тэмдэглэн үргэлж шинэ санаа, үнэнг хайж явах нь зүйтэй юм.

Ярилцах сэдэв - Өнгөрсөн сарын хугацаанд таны байгаа газар болж өнгөрсөн үйл явдалуудаас санаа авч болох номлолын сэдвийг болон амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар дэвтэрт жагсаан бичнэ үү.

5-р Хичээл

НОМЛОЛД ХЭРЭГЛЭХ БАРИМТ МЭДЭЭЛЭЛЭЭ ЦЭГЦЛЭХ

Номлолд хэрэглэх баримт, мэдээллээ цэгцлэх болон дарааллыг гаргах нь маш чухал. Номлогч номлох сургааль дээрээ ажилласнаар ярих гэсэн сэдвээ бүрэн зөв илэрхийлэх болон сургаалийн зорилгийг гаргах боломж олдоно.

Номлолыг эмх цэгцэнд оруулах нь дараах давуу талуудтай:

1. Номлогчийн хувьд ойлгомжтой цэгцтэй номлолыг цээжлэхэд хялбар.
2. Номлолоос гарах үр жимс нь хэрхэн номлолд бэлтгэж няхуур хандсанаас хамаардаг.
3. Сонсож буй хүмүүсийн хувьд сайн бэлдсэн номлол нь Библийн хичээлийг ойлгоход хялбар болгодог бөгөөд ой тогтоолтонд үлддэг. Мөн сонсогчид номлолын үед анхаарал сариналгүй сонсох гол шалтгаан нь сайн бэлтгэл юм.

Даалгавар: Ром 1:16-17-г уншиж номлолын сэдэв гаргана уу!

6-р Хичээл - САЙН БЭЛДСЭН СУРГААЛ

Номлолыг сайн бэлдсэнийг харуулах шинж чанарууд:

1. **Нэг сэдвийн дор бэлтгэгдсэн:** Номлогч нь нэг л сэдвийг гол сэдвээ болгон сонгон авч түүний дагуу баримт, нотолгоо, жишээ болон гэрчлэлийг хавсарган ярьж тухайн сэдэв дотроо номлох.
2. **Логикийн хувьд холбоотой байх:** Сургаалийн хэсэг бүр хоорондоо уялдаа холбоотой байж тухайн номлолыг **оюун ухааны** хувьд хүмүүст хүргэнэ. Үүний дараа сонсож буй хүмүүсийн **сэтгэл хөдлөлд** хүрч хамгийн сүүлд нь хүмүүст **хүсэл зоригийг** өгөх нь зөв дараалал юм.
3. **Хүний биеийн үндсэн бүтэц нь араг яс байдагтай адил номлол бүрт гол санааг нь тусгасан тоймыг заавал бэлтгэх хэрэгтэй.** Зарим номлогч нар номлолын хураангуйг бэлдэхдээ ижил төстэй үг хэрэглэн ерөнхий тойм хийдэг бол харин нь эсрэг тэсрэг утгатай үг өгүүлбэрээр бичдэг.

Номлол нь дараах гол гарчигуудыг агуулсан байж болно:

Сэдэв: **Өөрчлөлт**

- | | |
|------------|-----------|
| 1. Газар | 3. Хүмүүс |
| 2. Зорилго | 4. Хүч |

Харин өөр нэгэн номлол доорх гарчигтай байж болно:

Сэдэв: **Хэрхэн Христ итгэлт хүн болох вэ?**

- | | |
|---------------------------|---------------|
| 1. Хүлээн зөвшөөрөх | 3. Захирагдах |
| 2. Дагалдах/ тууштай байх | 4. Дамжуулах |

Даалгавар: Ижил үсгээр эхэлсэн үгээр номлолын хураангуй бэлдэнэ үү.

7-р Хичээл - НОМЛОЛЫН ТАНИЛЦУУЛГА

Сайн бэлтгэгдсэн сургаал номлол нь эхлэл, үндсэн агуулга болон дүгнэлт гэсэн 3 хэсгээс бүрддэг. Эхлэл танилцуулга хэсэг бол хоолны амт оруулагч адил чухал үүрэгтэй. Заримдаа цаг хүрэлцэхгүй байх эсвэл чөлөөт ярианы үед эхлэл хэсэг хэрэггүй боловч ерөнхийдөө эхлэл хэсэг нь юуны тухай ярих гэж байгаагаа танилцуулах цаг юм.

Эхлэл хэсгийн зорилго:

1. Тухайн сэдвийн дагуу сонсогчдийн сонирхолыг өдөөх. Номлогч нь өөрийн ярих гэж буй сэдвээ анхаарал татахуйц эхлүүлсэн үед хүмүүс дуустал нь сонсдог.
2. Цаашдаа юуны талаар ярих гэж байгаагаа мэдүүлэх.

Танилцуулах хэсэгт багтаж болох агуулгууд:

1. Тухайн сэдвийн дагуу ерөнхий холбоотой яриа өрнүүлэх. Жишээ нь Дуулал 23:4-6 талаар ярих гэж байгаа бол номлогч нь ингэж асууж болно. “Дуулал номын энэ ишлэл нь үхлийн ирмэг дээр ирсэн хүнийг хэр их сэргээж, өнчирч хоцорсон нэгнийг хэр их тайтгаруулсан болоо?”
2. Тухайн үеийн түүхэн нөхцөл байдлыг ярих (жишээ нь Матай 2:3).
3. Библийн газар зүйн талаарх мэдээлэл өгөх (жишээ нь Иохан 4:3-4).
4. Библи дээрх эртний ёс уламжлал болон заншлалыг тайлбарлах (жишээ нь Лук 2:24).
5. Номын зохиолчийн тухайн үеийн онцгой нөхцөл байдлыг дурьдах (жишээ нь 1 Иохан 1:1).
6. Тэмдэглэлт өдөр - Дахин амилсны баяр, Зул сарын баяр гэх мэт

Даалгавар: Дахин Амилсны Баярын өдрийн номлолын эхлэл танилцуулга бэлдэнэ үү.

8-р Хичээл - ТОЙМТОЙ БЭЛДСЭН ТАНИЛЦУУЛГЫН МӨН ЧАНАР

1. Хэтэрхий чанга, дуулиантай эсвэл өндөр сэтгэл хөдлөл агуулаагүй байх. Номлолын эхлэл хэсэгт сэтгэл хөдлөл оролцуулалгүй харин аядуу зөөлөн хоолойгоор яриагаа эхэлж яваандаа гол санаагаа хүргэх.
2. Хэт урт сунжирсан биш байх. Эхлэл нь урт байх тусмаа сонсогчдийн анхаарал буурдаг.
3. Цар гарган бэлдэх. зүйлээ тэмдэглэсэн байх нь зүйтэй. Анхны сэтгэгдэл маш чухал тул бариагаа сайн эхлүүлэх.

Даалгавар: Ром 1:16-17 ишлэлийн дагуу номлолын хураангуй бэлдээд ангийнхантайгаа ярилцах.

9-р Хичээл - СУРГААЛИЙН ҮНДСЭН ХЭСЭГ

Номлол нь хэд хэдэн хэсгээс болон дэд сэдвүүдээс бүрдэж болно. Заримдаа 3-7 хэсэгтэй ч байх тохиолдол бий. Номлолын бүлэг тус бүр нь хоорондоо уялдаа холбоотой, логик дараалалтай байх ёстой. Зарим үед нэг сэдвээс нөгөөрүү шилжихдээ номлогч тайлбарлах нь ч бий. Номлолын хэсэг бүр нь дараах 3 асуултанд хариулагдахуйц байх ёстой:

1. **Юу?** - Эхний өгүүлбэр нь номлолын сэдвийн тодорхойлолтыг тайлбарласан байх. Ингэснээр уг сэдвээс хазайхгүй байж чадна. Энэ нь сонсож буй хүмүүсийн бодол санаанд хүрэх хэсэг юм.
2. **Яагаад?** - Энэ хэсэгт учир шалтгаан болон баталгааг тайлбарлана. Яагаад энэ нь үнэн гэж? Яагаад би итгэх ёстой бэ? Энэ сэдэв нь батлагдсан уу? Итгэж болохоор уу? гэх мэт асуултанд хариулсан байх.
3. **Хэрхэн?** Номлолыг хэрхэн хүмүүст хүргэх, ямар арга ухаан хэрэглэж сонсож буй хүмүүстээ сургаалийн утга санааг хүргэх талаар бодох. Номлолын үндсэн хэсгийг 3 ангилж болно Бурханы тухай, хүний тухай мөн утга учрын тухай.
4. **Яаж хэрэгжүүлэх вэ?** Номлол сонссоны дараа хэрхэн амьдралдаа хэрэгжүүлэх бэ гэсэн хамгийн чухал асуулт гарна. Энэ үед хүн бүр хувь хувийнхаа амьдралтай холбож бодно. Бидний гол зорилго бол хүмүүсийг Христийн төлөө шийдвэр гаргаж Түүний өмнө ариун амьдралаар амьдрахад удирдах юм.

Даалгавар: Ром 1:16-17 ишлэлийг уншаад номлолын хураангуй бэлдэх.

10-р Хичээл - НОМЛОЛЫН ДҮГНЭЛТ ХЭСЭГ

Номлолын төгсгөлийн 5 минут бол сайн бэлдэх ёстой чухал хэсэг юм. Төгсгөл хэсэг нь сонсогчдод шинэ санаа, бодол, сэдэл төрүүлэхүйц байж богино боловч утга учиртай өгүүлбэрүүд эсвэл номлолын гол санааг агуулсан дүрслэл байвал нэн тохиролжтой. Заримдаа хүмүүсийн мэддэг шүлэг, ишлэл эсвэл магтан дууны хэсэг ч байж болно. Эсвэл номлолоо маш содон өгүүлбэрээр төгсгөсөн ч болно.

Номлолын төгсгөл хэсэг нь сонсож буй хүмүүстээ номлолыг сонсоод түүний дагуу үйлдэл хийхийг уриалсан өнгө аястай байх нь зөв. Энэхүү түүх нь яагаад номлолын дүгнэлт хэсэг нь үйлдэлд уриалсан байх ёстойг харуулах болно: Америкийн сайн мэдээ тараагч Д.Л Мүүди 1871 оны 10-р сарын 8нд Эзний өдөр Чикаго хотод номлол хийжээ. Номлолын дараа Есүс Христтэй хамт та юу хийх бэ гэсэн асуултыг танхимд байсан хүмүүсээс асууж гэртээ очоод сайн бодохыг уриалжээ. Мүүди номлогчийн гол зорилго нь Есүс Христыг өөрийн Бурхан Эзнээ болгон хүлээн авахад нь туслах байжээ. Харин яг тэр орой нь Чикаго хотод маш том гал түймэр гарч 3 өдөр үргэлжилсэн бөгөөд 300 хүн амиа алджээ. Тэр орой болсон явдлаас болж номлогч тэр өдрөө Бурханыг хүлээн авахыг уриалсангүй харин гэртээ очоод бодож үзээрэй гэж хэлсэндээ өөрийн сүүлчийн өдрөө ч ихэд харамсжээ. "Би яг тэр өдөр, тэр мөчид хүмүүсийг сайн мэдээг хүлээн авахыг уриалах байсан юм. Бурханыг хүлээн авах шийдвэр гаргах бүтэн долоо хоног өгсөндөө харамсаж хэрвээ өнгөрснийг буцааж болдог бол баруун гараа өгөхөд ч бэлэн байна хэмээн өгүүлжээ."

Сайн мэдээг номлох бүрт хурдан яаралтай хүмүүст хүргэх ёстой гэсэн мэдрэмж байх нь зохистой юм. Библид хэлэхдээ: Учир нь Тэр "Би тааламжтай цагт чамайг сонссон. Авралын өдөрт Би чамд тусалсан" (2 Коринт 6:2) Номлол хийх бүртээ энэ нь таны сүүлчийн боломж мэт номлох хэрэгтэй. Английн номлогч Ричард Бакстер, тэртээ 300 жилийн өмнө хэлэхдээ: Энэ нь миний амьд байх сүүлчийн өдөр мэт бусдад сайн мэдээг тарааж номлодог. (Сайн мэдээний номлол, Сайн мэдээний институт, Билли Грамын Төв, пп29.60-с иш татав).

Даалгавар: Ром 1:16-17 -ээс номлолын төгсгөл хэсгээ сэтгэл хөдөлгөм байдлаар бэлдэнэ үү.

11-р Хичээл - ЗҮЙРЛЭЛ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

Есүс хүмүүст хандан ярихдаа хошин яриа, дүрслэл болон харьцуулалт ашигладаг байсан. Есүс бусад хүмүүсээс илүү сургаалт зүйрлэлээр дамжуулж заадаг байсан. Номлолын жинхэнэ утга санаа, үнэнийг дүрслэлээр дамжуулан тайлбарласнаар хүмүүс илүү ойлгож амьдралдаа авч үлддэг.

Зүйрлэлийн гол зорилго:

1. Цонхоор гэрэл орж ирж байгаа мэт номлолыг амилуулдаг.
2. Тайлбарладаг.
3. Номлолыг сэдвийн дагуу баримт нотолгоо өгдөг.
4. Номлолыг сонирхолтой болгодог.
5. Итгэл үнэмшил өгдөг.

Зүйрлэлийг хаанаас олох вэ?

1. Номлогч нь хаа явсан газраа дүрслэл харьцуулалт хийх зүйлсээ эрж хайж байх нь зүйтэй. Христ номлол хийхдээ сараана цэцэг, хэрээ, давс, лаа, торх, хоёр нүүр гаргагч, ялаа, дэнгийн эрвээхий, том жижиг хаалга, зүүний үзүүр, талхны хөрөнгө, гичийн үр, загасны тор, зээлдэгч болон өр нэхэгч гэт мэт олон зүйрлэлийг ашигласан.
2. Библийн ишлэлээс сургаалт зүйрлэлийг харж болно.
3. Бусад эх сурвалжууд: сонин, түүх, амьтад, ургамал ногоо, хүүхдүүд болон бусад эд зүйлс.

Ярилцах сэдэв - Иохан 3-р бүлгийг уншаад дахин төрөх талаар зүйрлэл бэлдэнэ үү.

Тэмдэглэл: 12-35-р хичээлд оюутнууд 5 төрлийн номлолын хураангуй бэлдэнэ. Ингэхдээ номлолын хураангуй бүр бүрт танилцуулага, гол санаа, зүйрлэл төгсгөл хэсэг ба Есүс т итгэхийг уриалсан байх. Оюутан бүр өөрийн бэлдсэн товчлолоо номлох болно.

12-15-р Хичээл - БОДИТ ХҮНИЙ ТУХАЙ НОМЛОЛ

Библи дээр гардаг хүмүүс энэхүү төрлийн номлолын гол баатрууд юм. Намтрын тухай номлолын товчлол нь:

Абрахамын дөрвөн өргөл

Эх бичиг: Эхлэл 12-22

Сэдэв: Оюутан тодорхойлно

- I. **Танилцуулга:** Оюутан тодорхойлно
- II. **Номлолын гол санаа:**
 - a. Эх орноо болон төрөл саднаа орхин явах (Эхлэл 12:1). (Оюутан шинэ гэрээнээс болон өөрсдийн амьдралаас зүйрлэл олох).
 - b. Лотоос тусгаарлах (Эхлэл 13:9) (зүйрлэл олно).
 - c. Хагар болон Ишмаелийг хөөх (Эхлэл 21:10) (зүйрлэлтэй).
 - d. Исаакыг Бурханд өргөх (Эхлэл 22) (зүйрлэлтэй).
- III. **Дүгнэлт болон уриалга**

16-20-р Хичээл - ХҮҮРНЭЛ НОМЛОЛ

Хүүрнэн өгүүлсэн номлол нь Библийн ишлэлийг дүрслэн харуулдаг.
Хүүрнэн өгүүлсэн номлолын товчлол:

Арслангийн үүрэн дэх Даниел

Эх бичиг: Даниел 6:19-23

Сэдэв: Бурхан өөрийн хүүхдүүдээ халамжилдаг

- I. **Танилцуулга:** Эрх чөлөөгүй оронд амьдарч буй нэгэн залуугийн түүх
- II. **Номлолын гол санаа:**
 - a. Хорон санаатны хуйвалдаан (Даниел 6: 1-9)
 - b. Өдөр бүрийн дадлага (ишлэл 10)
 - c. Бурханы хангамж (ишлэл 21-24)
- III. **Дүгнэлт болон уриалга:** Даниел өөртөө маш их итгэлтэйгээр ямарч ч аюултай тулгарч чадах чадвартай учир нь тэрээр Бурхантай дотно харилцаатай байсан юм. Амьдралд тохиолдож болох ямар ч зүйлийг даван гарахын тулд та өөрийн Бурхантай хэр ойр дотно алхаж байгаа вэ?

21-25-р Хичээл - ИШЛЭЛ ТАЙЛБАРЛАСАН НОМЛОЛ

Ишлэл тайлбарласан номлол нь богино ишлэл сонгож аваад дэлгэрүүлж тайлбарласан номлол юм.

Бурханд тааламжтай өргөл

Ишлэл: Ром 12:1

Сэдэв: Зориулалт

- I. Танилцуулга: Зориулалт гэдэг нь зориулах, тусдаа байх, Бурханы алдрын төлөө бусдаас өөр байх гэсэн утгатай. Зориулалт гэдэг нь бидний Хаан Есүсийн таалал дүрэмд нийцүүлэн амьдрахыг хэлдэг. Тэгвэл таны амьдралын эзэн хэн бэ?
- II. Гол санаа:
 - a. Хэн зориулагдаж болох вэ?

“Иймд ах дүү нар аа” гэдэг нь Христийн цусаар ариусгагдсан Бурханы гэр бүлийн гишүүдэд хандаж хэлсэн. Энэ нь зөвхөн агуу, мундаг авьяастай нэгэнд хандаж хэлсэн бус бүх итгэгч нарт зориулсан.
 - b. Өөрсдийгөө ариун тахил болго гэсэн ингэхдээ хүчээр албаар эсвэл айдсаар бус харин “Бурханы нигүүлсээр” дамжиж хий гэсэн. Бурханы нигүүлсэл гэдэгт аврал, ариусал, Ариун Сүнсний оршихуй, өдөр бүрийн тусламж, эрүүл мэнд, үхлийн дараах тэнгэр улс, найз нөхөд, сүм чуулган орно.
 - c. Яаж ариун тахил өргөх вэ – “Өөрийн биеийг тахил болго” гэдэг нь:
 - i. Сайн дураараа - Хүчээр биш бэлэг өгч байгаа мэт сайн дураараа өргөх.
 - ii. Таны бие гэдэг нь зөвхөн таниас хамаарах хувийн асуудал гэсэн утгатай.
 - iii. Амьд тахил гэсэн - Амьд өргөл буюу Абрахам хүү Исаакаа өргөсөн шиг өөрсдийн амьдралыг тахилын ширээний өмнө өргөх.
 - d. Тахил нь туниагүй байж болохгүй. Та үнэхээр Түүгээр дамжин аврагдсан бол түүнд хамгийн сайнаа өгөхгүй гэж үү.
 - e. Би юугаар тахил өргөх вэ - өөрийн биеэр. Бидний бие бол биднийх биш Христийн цусаар аврагдсан юм.
 - i. Бидэнд махан биеийн эрч хүч; Бурханд эрүүл байгаадаа талархан Түүний төлөө ашигла.
 - ii. Бидний хөл бол сайн мэдээг хэн нэгэнд хүргэхийн төлөө бай.
 - iii. Бидний гар эелдэг байж унасан нэгнийг босгодог байх.
 - iv. Бидний нүд хүнд хэцүү байгаа нэгнийг олж харж чаддаг байх.
 - v. Бидний чих хүнд хэцүү байдалд ороод уйлж байгаа нэгнийг сонсож тэндий төлөө Бурханыг хайдаг байх.
 - vi. Бидний дотоод сэтгэлийн бэлэг тэмдэг болсон жинхэнэ хүн маань бөгөөд бидний зүрхийг Тэр өөр рүү нь хандаасай гэж маш их хүсдэг.

- III. **Хураангуй ба уриалах хэсэг** - Амьд ариун тахил байна гэдэг бол үйл явц. Энэ нь өдөр бүр, мөч бүрт өөрийн Эзэндээ бууж өгөх явдал юм. Тиймээс та одоо ч байгаа бүхнээ Аврагчдаа өргө.

Ярилцах сэдэв: Та өөрийн биеэ Христэд тахил болгон өргөсөн үү? Тийм бол таны амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ?

26-30--р Хичээл - СЭДЭВ СОНГОН НОМЛОХ

Энэ төрлийн номлол нь ямар нэг сэдэвтэй, гол санаатай байна. Библийн тайлбар номыг ийм номлолд ашиглах нь зүйтэй. Библийн олон хэсгээс ишлэл татаж болно. Сэдэв сонгож номлох номлолын хураангуй:

Над руу ирж цангаагаа тайл

Ишлэл: “Баярын их өдөр болох сүүлчийн өдөр Есүс зогсоод хашхиран Цангасан хүн байвал Над уруу ирж, уугтун” (Иох. 7:37).

Сэдэв: Амийн ус

- I. **Танилцууллага:** Та усгүй явж үзсэн үү? Ус л олж байвал бусад нь хамаагүй гэсэн байдалд орж үзсэн үү? (Ус ямар их ач тустай талаар бодлоо хэлэх)
- II. **Гол санаа:**
 - a. Амийн ус - Усаар мөн чанрыг илэрхийлсэн
 - i. Амьд (Иох 4:10).
 - ii. Тунгалаг (Илч. 22:1).
 - iii. Ариун (Илч. 22:1).
 - iv. Элбэг дэлбэг (Езек. 47:1-9).
 - v. Үнэгүй (Илч. 21:6).
 - vi. Хэнд зориулж өгөгдсөн бэ?
 - vii. Цангасан нэгэнд (Илч. 21:6).
 - viii. Хүн бүрт (Илч. 22:17).
 - ix. Яаж авах вэ?
 - x. Ирэх (Илч. 22:17).
 - xi. Авах (Илч. 22:17).
- III. **Хураангуй ба уриалах хэсэг** - Оюутнууд бэлдэх.

31-35-р Хичээл - БИБЛИЙГ ТАЙЛБАРЛАХ НОМЛОЛ

Библийг тайлбарлах номлол нь бусад номлолоос ялгаатай. Сэдэвчилсэн болон ишлэлээр бэлдсэн номлол нь агуулагаас нь санаа авч тайлбарладаг бол энэ номлол нь Библи яг юу хэлснийг ухан ойлгуулахад оршдог. Энэ утгаараа бусад номлолын төрлөөс чухалд тооцогддог.

Библийг тайлбарлах номлол нь **дараах давуу талтай**:

1. Библи-д тулгуурласан номлогч болон сонсогч нар нь Библид тулгуурлан Библийн дагуу байхад тусалдаг.
2. Есүс, Паул болсон Петр энэ зарчмаар номлодог байсан ба энэ нь Библи дээр номлол ямар байх зарчимтай нийцдэг. (Лук 4; Үйлс 7, 8, Үйлс 28; Үйлс 2, 3).
3. Энэ төрлийн номлол нь маш өргөн хүрээтэй. Сонсож байгаа хүмүүсийн амьдралд Библийг хэрэгжүүлэхэд илүү боломж өгдөг.

Мөн **учир дутагдалтай талууд** ч байна:

1. Чуулганыханд уйтгартай санагддаг.
2. Номлогч өөрөө залхаад гүн судалж заахын оронд хэдэн ишлэл уншаад ганц нэг тайлбар хийгээд явчих магадлалтай.
3. Ишлэл их урт байвал сонсогчид ойлгоход хэцүү болдог. Заримдаа судлаж байгаа хэсэг нь өдөр дутмын амьдралаас өөр байдаг. Тиймээс ишлэлээ өөр өөр хэсгээс авч амьдралд хэрэгжүүлж болхоор онлын биш бодит амьдралтай аль болох ойр байлгахыг хичээх.

Библийг тайлбарлах номлолын хураангуй жишээ:

Үхлээс амилсан нь

Ишлэл: Ром 5:6-11” Биднийг дорой байхад, сүсэг бишрэлгүй хүмүүсийн өмнөөс Христ яг л цагтаа үхсэн билээ”

Гарчиг: Есүс Христийн үхэл

- I. **Танилцууллага:** Паулын бичсэн захиас
- II. **Гол сэдэв:**
 - A. Хэн нэгэн нас барав
 - i. Үхэл хагацал хүн бүрт ирдэг энгийн зүйл
 - ii. Харин Түүний үхэл энгийн биш байсан.

- iii. Үхсэн нэгэн бусдаас өөр байсан
- iv. Тэр үхэхгүй байж болох байсан
- v. Түүний үхэл зорилготой байсан
- B. Христ хэний төлөө нас барсан бэ?
 - i. Бурхангүй, гэмтэй, сул дорой, дайсанууд
 - ii. “Тэндий төлөө нас барсан” гэсэн.
- C. Христийн үхлийн зорилго
 - i. Таагүйгээр хэлвэл Бурхан хүмүүсийг хүчээр хайрлахгүй байх
 - ii. Эерэг үр дагавар нь хүмүүс өөрчлөгдөхийн тулд:
 - 1. Зөвтгөгдөх
 - 2. Эвлэрүүлэх
 - 3. Уур хилэнгээс аврагдах
 - 4. Түүний амьдралаар аврагдах

III. Хураангуй ба уриалах хэсэг:

- A. Загалмай ямар их чухал болхыг бид мэдэх үү?
- B. Энэ нь бидэнд огт чухал биш юм уу эсвэл бидний бүх зүйл үү?
- C. Түүний үхлийн учрыг олвол бид Түүнийг агуу ихээр хайрлахгүй байхын аргагүй.

36-40-р Хичээл - НЭГТГЭСЭН БИБЛИ СУДЛАЛ

Нэгтгэсэн Библи судлал (НБС) нь бичээсийг системтэйгээр судлах арга ба пасторууд номлолоо бэлдэхэд маш хэрэгтэй. Дараах хичээлүүд нь оюутнуудыг НБС-н 3 алхамаар сурах аргыг харуулна.

36-р Хичээл - АЖИГЛАЛТ (ЮУ ХЭЛЖ БАЙНА ВЭ?)

1. Сонгосон библийн хэсгээ дахин дахин унших
2. Урд хойно байгаа хэсгийг бас унших
3. Асуулт байвал бичиж ав
4. Ямар төрлийн утга зохиол гэдгийг тодорхойлох
5. Агуулгыг нь гаргаж ирэх
6. Зохиогчийг нь судлах
7. Хэнд хандаж бичсэнийг нь судлах
8. Гарч байгаа хүмүүсийг нэрлэх
9. Гол үгнүүд болон өгүүлбэрийг тэмдэглэ
10. Хэн, хэзээ, юу, яагаад, яаж гэдэг асуултыг асуух
11. Номын гол санаа юу вэ?
12. Бүлгийн гол санаа юу вэ?
13. Номлолын ишлэлийн гол санаа нь юуг олох.

14. ** Бурхан юуг онцлохыг хүссэн тэр чиний гол санаа байх хэрэгтэй.

Даалгавар: Дээр дурдсан 14 алхамыг ашиглан Үйлс 5:17-32-г уншиж ангийхандаа ажиглалт хийснээ хуваалц. (Жич: Тухайн ишлэлийн онцлогоос хамаараад бүх асуултанд хариулах боломжгүй байж болох тул анхаарна уу).

37-р Хичээл - ТАЙЛБАРЛАХ (ЯМАР УТГАТАЙ ВЭ?)

1. Тайлбар нь таны санаа биш юм
2. Тайлбар нь зохиогч юу хэлэхийг хүссэнтэй холбоотой.
3. Тайлбарлахдаа дараах 7 зааврыг дагана уу.
4. Библийн хэсгийн агуулга
5. Бусад холбоотой ишлэлийг судлах
6. Бичээс хоорондоо зөрдөггүй.
7. Номлолоо тодорхойгүй хүмүүсийн мэдэхгүй ишлэлээр бэлдэхээс зайлхий
8. Утга нь өөр биш л бол үгчлэн тайлбарла
9. Зохиогч юу хэлэхийг хүссэн, түүнийг баталгаажуул
10. Бусад төлөвшсөн итгэгч нар эсвэл Библийн тайлбар номоор баталгаажуул.

Даалгавар - Үйлс 5:17-32-г чангаар уншаад дээрх гурван алхмыг ашиглан тайлбарла.

38-р Хичээл - ХЭРЭГЖҮҮЛЭЛТ (БИ АМЬДРАЛДАА ЯАЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?)

1. Иаков 1:22-25-т Хэрэгжүүлэх нь ямар чухал талаар гардаг.
2. Дараах 4 асуултаар хэрэгжүүлэхэд уриална.
3. Бурхан надаас одоо юу хүсч байна?
4. Тэр намайг хаана байгаасан гэж хүсч байна?
5. Түүний хийгээсэй гэсэн зүйлийг би яагаад хийх ёстой вэ?
6. Би Түүний хүслийг хэрхэн биелүүлэх вэ?

Даалгавар - Үйлс 5:17-32-г уншаад Хэрэгжүүлэх зааврын дагуу ангийнхнаа удирдах.

39-р Хичээл - НБС-Г АШИГЛАН НОМЛОЛЫН ХУРААНГУЙГ БЭЛДЭХ

Энэ материалын 36-38-р Хичээлд заасны дагуу оюутнууд Үйлс 5:17-32-г ашиглан номлол бэлдэнэ. Номлол эхлэл, гол санаа, төгсгөл хэсгийг зүйрлэлтэй хавсаргасан байна.

40-р Хичээл - НОМЛОЛЫН ХУРААНГУЙГ ХУВААЛЦАХ

Оюутнууд номлолын хураангуйгаа ангийнхантайгаа хуваалцаж тэдний санаа оноог сонсож хичээл дуусах үед багшдаа хураалгана.

БУРХАНЫ ХОНИН СҮРГИЙГ ХАРИУЛАХ

1 Петр 5:2-т Петр хэлэхдээ “та нарын дунд байгаа Бурханы хонин сүргийг хариул” гэсэн. Петр энэ ишлэлийг бичихдээ Есүс чи намайг эднээс илүү хайрладаг уу гэж асууж байсан үеийг санан хэлсэн байх. Есүс энэ асуултаа асууж дуусаад миний хургануудыг тэжээ гэсэн. Есүс өнөөдөр ч мөн Түүний хонин сүргийг хариулахаар дуудагдсан дагалагч нартаа адилхан даалгаврыг өгдөг.

Петр залуу хоньчдод хандан нэмж хэлсэн зүйл нь хонин сүргийг хариулаад зогсохгүй, тэднийг манаж, тэдэнд үлгэр жишээ бол гэдгийг сануулсан. Өөрөөр хэлвэл тэд хонин сүрэгт тулгарч байгаа асуудал, асуулт болон ачааг ямар ч үед хамт үүрэх үүрэг ба энэ үүрэг амьдралын чинь хэсэг болно гэсэн үг.

Энэ бүлэгт сургаал заах, зөвлөх гээд олон сэдвээр ярилцах ба Хамгийн Дээд Нэгний Элчин сайд байх тухай үзнэ. Энэ бүлгийг дараах хэсгүүдэд хувааж болно:

1. Хичээл 1, 5-9 - Пастор хүний хувийн амьдрал.
2. Хичээл 2, 3, 4, 10-13, 19 болон 34-40 - Чуулганы үйлчлэл.
3. Хичээл 14-18 - Сүнсний хувьд харанхуй байгаа хүмүүст хүрэх.
4. Хичээл 20-33. Байнга тохиолдоод байдаггүй үед үйлчлэх .

Петрийн хэлсэн үгнүүд энэ хичээлүүдийн гол санааг агуулдаг Миний Хонин Сүргийг Хариул.... тэгснээрээ Ахлах Хоньчин ирэх үед гандахгүй титмийг хүлээн авах юм (1 Петр. 5:4). Энэ хэсэгт Ар Стэйнлигийн бичиж Энэтхэгийн Вэллере-д байдаг Ивээлийн Номнууд хэвлэлийн газраас бэлтгэн гаргсан “Номогч ба Хүмүүс” номноос ашиглав. Энэ хэсэгт орсон маш олон үнэнг Энэтхэгт байхдаа олж мэдсэн юм.

1-р Хичээл - ҮГИЙГ НОМЛО

Бурханы үгэн дээр үндэслэн заагдсан сургаал үр жимсийг гаргадаг. Хуучин гэрээний Иосиа хааны үед 2 Хаад 22:8-11 болон Езра 7:10-д бичигдсэн сэргэлтийн гол үндэс нь Бурханы үг байсан. Амос тухай газарт өлсгөлөн ирэх гэж байгаа тухай Эзний үгийн зөгнөсөн. (Амос 8:11, 12) -т хэлэхдээ тэр өдрүүд бидний дээр аль хэдийн гэсэн. Олон номлогч нар урд гараад туршлагаа ярьдгаас бус Бурханы үгийг тунхагладаггүй.

Сүү хэдий шимтэй ч хүн мах идэхгүйгээр өсдөггүйтэй. Тиймээс Паул Үгийг тунхагла гэсэн. (2 Тим. 4:2-4). Энэ бол маш чухал.

Ярилцах сэдэв: Дээр бичигсэн сэдвээр ярилцан зөвхөн Бурханы үгэн дээр үндэслэн номлох нь ямар үр дүнтэй талаар ярилцана уу.

2-р Хичээл - ЯАГААД БИДЭНД СЭРГЭЛТ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Сэргэлт ирэх нь эцсийн зорилго биш юм харин сэргэлтээр дамжуулан сайн мэдээ тунхаглагдах нь юм. Сэргэлт нь сайн мэдээ тараах биш харин сайн мэдээг хүлээж авах хөрсийг тавьдаг. Давид Дуулал 51; 12, 13 т залбирахдаа “Авралынхаа баясгаланг надад сэргээж өгч тэгснээрээ ... нүгэлтднүүд Тан уруу буцах болно гэсэн.

Уельсийн Сэргэлтийн үед Эван Робэрт “Та чуулгануудыг бөхийлгөн дэлхийг ерөөгөөч” гэж хэлсэн.

Өнгөрсөн хугацаанд олон сэргэлтүүд болж авралын зар тараах эхлэл болсон ба сайн мэдээний хөдөлгөөнүүдийн эхлэл болсон. Тэдний дунд удаан үргэлжилж чадаагүй сэргэлтүүд ч байсан. Энэ нь юунаас болсон гэвэл удирдагч нар сэргэлтийг сайн мэдээний суваг болгон сүнснүүдийг аврах ажил дутсанаас болсон.

Бурхан Өөрийн Сүнсээ Түүний хүмүүс дээр буулгахдаа зөвхөн тэднийг баярлуулж хөөргөх гэж хүсээгүй. Огт тийм биш. Харин тэдний эргэн тойронд байгаа “дэлхийд” хүрэхийг хүссэн. Сэргэлт ирдэггүйн нэг шалтгаан нь бидэнд яагаад сэргэлт хэрэгтэйг бид мэддэггүй.

Ярилцах сэдэв - Чуулганд чинь сэргэлт хэрэгтэй байгааг илтгэх ямар асуудлууд байгаа талаар ярилцан залбирна уу.

3-р Хичээл - СЭРГЭЛТИЙН ТАЛААР ЗААХ

Танай чуулганы итгэгч нар Бурханы зүйлсийн талаар ярихаар хүйтэн хөндий ямар ч сонирхолгүй байна уу? Таны хонин сүрэг дотор хагарал, атаа чөтөө, сэргэлдөөн байна уу? Тэд худлаа хэлж хулгай хийж байна уу? Тэд итгэгч биш зан авир гаргаж байна уу? Тийм бол сэргэлт хэрэгтэй болжээ.

Сэргэлт гэдэг нь амьдралд буцаж ир гэсэн утгатай. Сэргэлт болон сайн мэдээ тараах нь ялгаатай. Гэм нүгэлтэнд сайн мэдээ тарааж Эзэн дээр ирэх нь чухал бол дахин төрсөн итгэгч хүн гэм нүгэл хүйтэн хөндий байдлаасаа эргэн сэргэх хэрэгтэй.

1. Яаж сэргэлтийг авах вэ? - 2 Шастир 7:14- т маш товч бөгөөд тодорхой алхмуудыг заадаг:
 - a. Өөрсдийгөө даруу болго
 - b. Залбир
 - c. Түүний царайг хай
 - d. Бузар муу замаасаа эргэ
2. Сэргэлтийн үр дүн:
 - a. Бурханы таны залбирлыг сонсоно
 - b. Тэр таны гэмийг уучлана
 - c. Тэр таныг эдгэдгээж амьдралыг чинь хүчирхэгжүүлнэ

Та сэргэлтээр цангаж байна уу? Тэгвэл үүний төлөө залбираад номлогтун!

Ярилцах сэдэв - Та өөрийн хонин сүрэгтээ сэргэлтээр хэрэгтэй байгаа тухай хуваалцсан уу? Тэгвэл яаж энэ уриаг бодит байдлаар тэдэнд хүргэх талаар ярилцана уу.

4-р Хичээл - СЭРГЭЛТИЙН ТӨЛӨӨ ЗАЛБИРАХ

Сэргэлтэнд бэлдэн залбирах нь зөв ч үүнээс илүү өөрөө өөрийгөө шалган, гэм нүглээ улайх нь чухал. (Илч, 2:23). Бид Бурханы өмнө амлалтаа биелүүлээгүй гэдгээ хүлээн зөвшөөрч (Ном. үгс 5:1-6) мөн бусдад хийсэн буруу үйлсээ санан эвлрэх мөчид сэргэлт ирдэг. (Матт. 5:23, 24).

Залбирал жинхэнэ даруу байдал руу чиглүүлдэг (Иса. 6:1-5) яагаад гэвэл бид Түүний Ариун оршихуйд хэн ч биш гэдгээ мэдэрдэг. Залбирал нь бид сул дорой гэдгээ хүлээн зөвшөөрч Түүнээс тусламж хүсэх юм. (Матт. 26:41).

Бурханд энэ хандлага таалагддаг бөгөөд Түүний гал тэдний дээр бууж (Дуул. 51:17-19). Елиа тахилын ширээг засах үед гал буудаг. Есүс залбирах үед тэнгэр нээгддэг. Анхны сүмүүс залбирах үед газар хөдөлсөн.

Залбирал нь Сүнсний хүчийг газар дээр буулгадаг. Бурхан өөрийн хүмүүс өвдөг сөгдөх үед нь хугалдаг бас босгодог.

Ярилцах сэдэв - Дээр гарсан ишлэлүүдийг тунгаан залбиралын үр дүнгийн талаар ярилцана уу.

5-р Хичээл - ХАЙР, ДАВХАР ҮЙЛЧЛЭЛ

Есүс тэнгэрт дээш өргөгдөхөөс өмнө Петрээс “чи намайг хайрладаг уу” гэж асуусан. (Иох, 21:15-17). Хайр бол Христ итгэлт үйлчлэлийн тулгуур хэсэг юм.

Есүс түүний анх дуудахдаа хүний загасчин бол гэж дууддаг. (Матт. 4:19). Дараа нь түүнийг миний хонин сүргийг хариул гэсэн, (Иох. 21:15-17). Та сайн мэдээг тараах болон хоньчлох хоёр ажлыг аль алиныг нь хайрлах нь чухал. Эхнийх нь төөрсөн нэгнийг хайрлах нөгөө нь итгэсэн нэгнийг хайрлах юм. Сүнсийг гардан авах өсгөн ургуулахын аль аль нь юм.

Ярилцах сэдэв - Төөрсөн нэгэнд болон итгэгч нэгэнд хайрыг харуулах бодит аргуудын талаар ярилцана уу.

6-р Хичээл - НИЙТЭД ҮЙЛЧЛЭХ

Хоньчны хамгийн том эрх бол сайн мэдээг тунхаглан заах юм. Хоньчид хувьдаа суралцаж туршлага сууж түүн дээрээ Бурханы тосолгоо ивээлийг авах нь гэмтэй хүмүүстэй ярилцах болон итгэгч нарыг хүчирхэгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй.

Тэр Бурханы тухай заахдаа сайн мэдээг тарааж, Библийн онлыг ярьж, зааж, зэмлэж, уриалж, анхааруулах хэрэгтэй. (Үйлс 20:27).

Чуулганы хоньчин олны өмнө залбирч чаддаг байх хэрэгтэй. Энэ чадвар хүнгүй газар хувьдаа залбирснаар бий болно. Пасторуудын залбирал чуулганыг Бурханы оршихуйд дагуулж магтах уур амьсгалыг авчрах залбирал юм.

Тэрээр Библийг бүх хүмүүст ойлгогдохоор чанга тодоор хүндэтгэлтэйгээр уншиж чаддаг байх хэрэгтэй. (Нех. 8:8).

Тэрээр Бурханы чуулганд номлолоор дамжуулан сонсож байгаа хүмүүсийн хэрэгцээнд тулгуурласан Библийн хичээлүүдээр “тэжээх үүрэгтэй” (Үйлс 20:28). Тэр чуулганы итгэгчдийг буруу сургаалаас хамгаалах мөн хонин сүрэг дотор байгаа ядуу нэгэнд анхаарах үүрэгтэй. (Үйлс 20:29-30),

Чуулганы хоньчин гишүүдийг төөрсөн, сүм чуулганд явдаггүй хүмүүст хүрэхэд дагуулах үүрэгтэй.

Цуглаанаас дуусах үед Бурханы ивээлийг тэдэнд дээр буулгах залбирлаар дуусгах үүрэгтэй. (Тоол. 6:23-26; Илч. 1:4-5).

2 Кор. 2:16-д “Хэн эдгээрт чадвартай вэ” гэсэн чухал асуултыг тавьдаг. “Бурхан бидэнд хангалттай юм”!

Ярилцах сэдэв - Дээр дурдсан үүргээс аль нь хамгийн хэцүү нь вэ? Таны хувьд хамгын чухал үүрэг юу вэ?

7-р Хичээл - АМЬДРАЛ ҮЙЛЧЛЭЛ ХОЁРЫН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ

1. Хувийн амьдралаа тэнцвэртэй байлгах
 - a. Номлогч нар амьдралын эрүүл зөв хэв маягтай байх хэрэгтэй. (хоолны дэглэм, амралт гэх мэт), өөрийн бие махбодь, сэтгэл санаанд анхаарал тавих.
 - b. Сүнслэг удирдагч нар өөрсдийн гэр бүлийн хэрэгцээг хангаж өөрсдийн санхүү дээр ухаалаг байх хэрэгтэй. (Матт. 6:24).
 - c. Есүс бие махбодь, мэдлэг чадвар болон сүнсээр өсч байсан шиг сүнсний удирдагч нар эдгээр талууд дээр өсөх хэрэгтэй. (Лук 2:52).
2. Өөрийн хичээл сургаалыг тэнцвэртэй байлгах. Бурханы бүх төлөвлөгөөнүүдийн талаар заах. (Үйлс 20:27). Бурханы илчлэлээс Бичээсийн дагуу Бурханы үгээс нэгийг ч гээлгүй заах нь чухал.
 - a. Бурханы хайрын тухай, Түүний ариун байдал гэм нүглийг тэвчиж чадахгүй тухай мөн тэнгэрийн улс болон тамын тухай, Бурхантай ойр байж Түүнд үйлчлэх бодит замуудын талаар болон сэргэлт, сайн мэдээ тараах тухай заах.
 - b. Та заах сургаалын сэдвээ гаргаад номлолын хуваарыг хэдэн сарын өмнө гаргавал сайн. Ингэснээр таны оюун санаа зүрх сэтгэл чинь бэлтгэгдэж Бурханы үнэнээс хазайхгүй байхад тустай.
 - c.

Даалгавар: Дараагийн 3 сарын номлолын хуваарь гаргана уу.

8-р Хичээл - ӨӨРТӨӨ ЦАГ ГАРГАХ

Жилдээ 1-2 удаа эсвэл сардаа 1 удаа өөртөө цаг гаргах нь чухал. Та өөрийн зорилгоо харж чадаж байна уу? Таны үйлчлэл хир үр жимстэй байна? Амжилт ба ивээл нь бодит байдлыг олж харах нүдийг хааж гэнэтийн асуудал гамшиг нүүрлэхэд бид ямар үр дүнтэй явснаа мартаход хүргэдэг. Үе үе үйлчлэлээ хир явж байгаа талаар дүгнэлт хийх нь маш үр дүнтэй. Хэрэв алдаа оноо байгаа бол засч болно. Элч Иохан тэнгэр элч нарыг 2 удаа магтсан нь буруу байсныг мэдэж өөрчилдөг. (Илч. 19:10; 22:8,9).

Есүс түүнд “бүү ингэ” гэсэн!

Ярилцах сэдэв - Та үйлчлэлийн эхэн үедээ ямар зорилгууд тавьж болох тухай ярилцана уу.

9-р Хичээл - ЗӨВЛӨХ ҮЙЛЧЛЭЛ

Пасторууд авралын талаар болон тэдний хувийн асуудлын талаар хүмүүстэй ярилцаж чаддаг байх нь чухал. Зарим үед буруу зүйл хийж байгаа бол ганцаарчлан уулзаж зэмлэх хэрэгтэй. (Матт. 18:15-17).

Пастор нь хүмүүсийн амьдралд санаа тавьж тэдний жаргал зовлонг хуваалцах хэрэгтэй. (Ром 12:15). Түүгээр зогсохгүй хагацал зовлонтой байгаа хүмүүсийг тайвшруулах чадвартай байх хэрэгтэй.

Та Есүс Христийн дэлхий дээрх маш онцгой элчин төлөөлөгч юм.

Ярилцах сэдэв -Таны үйлчилдэг дүүрэгт Христ итгэлт зөвлөлгөө өгдөг ямар боломжууд байна?

10-р Хичээл - УРАМ ЗОРИГ ӨГӨХ НӨХӨРЛӨЛҮҮД

Христээр холбогдон Түүний дор нэгэн гэр бүл болсон хүмүүсийн хоорондын дотно харилцааг нөхөрлөл гэнэ. Христэд итгэгч нар хамтдаа цуглаж, ярьж, залбирч, дуулж инээж уйлах хэрэгтэй. (1 Иох. 1:3, 1:7).

1. Нөхөрлөлийн зорилго

- а. Хамтдаа үйлчилж, хооллож бие биенээ хүчирхэгжүүлэх. Эрчүүд хамтдаа хооллож, эмэгтэйчүүд хуваалцлын орой гаргаж, залуучууд хөгжөөнт тоглоом тоглож Бурханы үгэн дээр нөхөрлөх. Ингэснээр итгэгч нар хүчирхэгжиж, үл итгэгч нар ийм нөхөрлөлд татагддаг.

- b. Амьдралын хэцүү үед бие биенээ дэмжих. Хэн нэгний зүрх шаналж байгаа зүрхийг анагааж чадахгүй ч ачаанаас нь үүрэлцэж чадна.
- c. Сурсан сургамжаа хуваалцах; ингэснээр таны сонсож байгаа нэгэн сургамж авч адилхан алдаа гаргахаас хамгаална.
- d. Залбирлын хариултаа авснаа хуваалцах (Дуул. 50:15). Ингэснээр бусад хүмүүс залбирах урам авна.
- e. Уйлж байгаа нэгэнтэй хамт уйлах (Ром 12:15.) Уй гашуу амссан нэгэн зовлон гунигаа хуваалцахад нөхөрлөлийн утга учир оршино.
- f. Бурханаас холдон явж буй хүмүүсийг буцаан авчрах.

2. Христ итгэлт нөхөрлөлөөс гарах үр дагавар:

- a. Бид гэрэл дотор алхаж сурдаг (1 Иох. 1:7).
- b. Бид хамтдаа зовж сурдаг (Фил. 3:10).
- c. Бид хамтдаа үйлчилж сурдаг (Кол. 4:7).
- d. Бид бие биенээ тайвшруулж сурдаг (1 Тес. 4:18).
- e. Бид бие биенийхээ төлөө залбирч сурдаг (1 Тес, 5:25).
- f. Бид бусдын ачааг үүрэлцэж чаддаг (Гал. 6:2).
- g. Баяр хөөртэй нэгэнтэй хамт баярлаж чаддаг (Ром 12:15). Баяр хөөр нь хурдан тархдаг.
- h. Бид Эзэн дотор өсч өнгө ордог (2 Пет. 3:18).
- i.

Ярилцах сэдэв - Танай чуулганд ямар нөхөрлөл хэрэгтэй байгаа вэ?

11-р Хичээл - САЙН МЭДЭЭГ ТУНХАГЛАСАН НОМЛОЛУУД

Сургаал заах маш олон сэдэв байгаа тийм болхоор ямар сэдвээр номлох талаар бодолтой байх хэрэгтэй. Бүх сургаал авралд хүргэхэд зорьсон гэж бодоод авралын талаар заахгүй байх нь итгэгч нарыг л дэмжихээс бус шинэ итгэгч нарыг гарч ирэх боломжыг хааж байгаатай адил.

Бодит байдал дээр хүмүүс тухайн чуулганд хамрагддаг ч Христийн бие болоогүй байдаг. Тэдэнд аврал үгүй бол мөнхөд төөрсөн нэгэн байх болно. Зүрх сэтгэлдээ итгээгүй гишүүдтэй чуулганд амьдрал, сайн мэдээ болон өөрчлөх хүч байдаггүй.

Сүмийн удирдагч нар Езекелийн анхааруулсан ард түмнийг сэрэмжлүүлээгүй манаачын тухай санах хэрэгтэй (Езек 33:6).

Даалгавар: Авралын зар тараах сэдэвтэй номлол болон ишлэлүүдийг жагсааж бичнэ үү.

12-р Хичээл - АВРАЛЫН БАТАЛГАА

Таны чуулганы итгэгч би үнэхээр аврагдсан болов уу гэсэн эргэлзээтэй байвал яах вэ?

Итгэгч хүн бусдад сайн мэдээ тараахыг хүсвэл өөрөө авралын баталгаатай байх шаардлагатай. Авралын баталгаа гэдэг нь би аврагдсан хэрэв би өнөөдөр нас барвал тэнгэрийн улсад очно гэдэг эргэлзээгүй итгэхийг хэлж байгаа. (Иох 10:28-29).

1. Авралын баталгааны үндэс

- a. Ариун Сүнсний гэрчлэл (Ром 8:16; Гал. 4:6).
- b. Бурханы үг (1 Иох. 5:10; 13; Иох. 5:24; Ром 10:13). Сатанд хандан: Бурхан үгэнд хэлэхдээ хэрэв би Есүст Христэд итгэвэл мөнх амьтай болно гэсэн. Би (он сараа хэлнэ)- ний өдөр Есүст итгэсэн тиймээс мөнх амьтай. Би аврагдсан, миний гэм нүгэл уучлагдсан. Би тэнгэрийн улс руу явж байгаа гэж хэлээрэй.
- c. Өөрчлөгдсөн амьдрал (1 Иох. 3:14; 2 Кор. 5:17).

2. Авралаа баталгаажуулахад саад болдог зүйлс:

- a. Бурханы үгэнд итгэхгүй байх.
- b. Энэ дэлхийн амьдралд хутгалдах.
- c. Ариун Сүнсээр дүүрээгүй үед (Иох. 7:37-39).
- d. Гэм нүгэл ба итгэлээсээ ухран явах (1 Иох. 1:19).

Анхаарулга: Бусдыг аврагдсан гэдгийг батлах гэж бүү хичээ энэ нь зүрхийг нягтлагч Ариун Сүнсний ажил юм.

Даалгавар: Хоёр хоёроороо хуваагдаад нэг нь итгэгч биш нөгөө нь Бурханы үгийг хуваалцаж байгаа болж харилцан ярилцана уу.

13-р Хичээл - ШИНЭ ИТГЭГЧДИЙГ ДАГАЛДУУЛАХ НЬ

Шинэ итгэгч нь дөнгөж төрсөн хүүхэдтэй адил маш их хайр халамж асаргаа хэрэгтэй.

Шинэ итгэгчдийн эхний долоон хоног маш чухал үе учир нь Сатан түүний зүрхэнд эргэлзээг өгөхийн тулд чадах бүхнээ хийх гэж оролдоно. Өдөр бүр тэр хүн дээр очиж Үгийг хамтдаа уншиж өгч хамтдаа залбир.

Шинээр итгэсэн нэгнээ бусадтай итгэлээ хуваалцах боломжыг гарган өгөх нь тэр хүний итгэлийг баталгаажуулж аврагдаагүй найз нартаа нөлөөлөх боломжыг олгодог.

Таны итгэдэг урсгал чиглэлд шинэ итгэгчдийг баптисм хүртээх хичээлд суулгадаг бол сайн мэдээг хүлээн авснаас хойш даруй эхлэх хэрэгтэй.

Шинэ залуу итгэгчдийг Библи судлалын групптээ урьж Бурханы үг болох сүүгээр тэжээж өсгөх хэрэгтэй (1 Пет. 2:2).

Мөн шинэ итгэгч нарыг төлөвшсөн итгэгч нард даалгаж хамтдаа залбирах дагалдуулах хүнтэй холбон өгч болно ингэхдээ эмэгтэй нь эмэгтэйтээ эрэгтэй нь эрэгтэйтэй байх нь зохистой.

Ярилцах сэдэв - Танай чуулганд байгаа шинэ итгэгчдээ яаж урамшуулж болох вэ? Том ах/Том эгч нартай холбох боломжтой юу?

14-р Хичээл - ЯАГААД ГЭРЧЛЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Бичээс Матай 10:32, 33; Ром 10:9

1. Христийг бусдад тунхаглах шалтгаан

- a. Христ тушаасан (Матт. 10:32-33).
- b. Христийг гэрчлэх нь бидний амьдралд ивээл ирэх эх үүсвэр болдог. Гэрчилж байгаа хүн түүнийг итгэх үгүйд хариуцлага хүлээхгүй.
- c. Маш олон асуулдыг шийддэг. Бусад хүмүүс таныг юунд итгэж үнэмшиж байгааг хараад хүндлэх болно.
- d. Уруу татлагатай дэлхийн зүйлс ихтэй газар очихгүй болдог. Христ таны төлөө хийсэн зүйлийг санахдаа бид гэрчилдэг.

2. Христийг тунхаглах аргууд

3. Нийтээр цугласан газар болох цуглаан, залбирлын цуглаан гэх мэт газрууд
4. Ойр дотны найз, гэр бүлийн гишүүн, хамаатан садандаа өдөр бүр хуваалцах нь хэцүү ч хамгийн үр дүнтэй.
5. Баптисм хүртэх, цуглаандаа тууштай явах болон ариун зоог барих.
6. Байнга тунхаглах (Иер. 20:9).

Ярилцах сэдэв - Таны мэдэх хамгийн сайн гэрчлэгч хэн бэ? Бусад хүмүүсийг гэрчлэгч болоход хэрхэн урамшуулж болох вэ?

15-р Хичээл - АВРАЛЫН ЗАР ТАРААГЧДЫГ БЭЛТГЭХ НЬ

Бурхан Исаяа 6:8-д “Би хэнийг явуулах вэ, Хэн бидний төлөө явах вэ?” гэсэн. Лук 1-:2-т хэлсэчлэн “Ургац арвин ч ажилчид цөөн” байна гэж хэлсэн үг өнөөдөр ч хэвээрээ. Тэгвэл та энэ талаар юу хийж чадах вэ? Таны зүгээс шалтгаалж болох бүх л аргыг хэрэглэх хэрэгтэй. Итгэгч хүн бүр сайн мэдээг тараахаас нааш Агуу Захирамж биелэгдэхгүй гэсэн.

Та дараах 4 алхмыг хийж болно:

1. Үлгэр жишээ болж харуулах.
2. Авралын зар тараах чухал сэдвээр номлолууд хийх. (Хичээл 13-15-г харна уу).
3. Хичээл зааж байхдаа бусдыг яаж сайн мэдээг тараах талаар зааж өгөх.
4. Авралын зар тараахтай холбоотой нийтлэл ярилцлага байвал чуулгандаа тараа.

Энэ дэлхийд Есүс хэрэгтэй. Бидний ажил бол Түүний хайр болон авралыг гэр бүл, найз нөхөд, хөршүүддээ тараах үр дүнтэй аргыг олж тэднийг урамшуулах явдал юм.

Даалгавар: Бусдыг гэрчлэгч нар байлгахын тулд би яаж үлгэр дуурайлал үзүүлж болох талаар 3 санаа гаргана уу.

16-р Хичээл - АВРАЛЫН ЗАР ТАРААХ ШАЛТГААН

Цөөн хүмүүс номлогч багш байхаар дуудагдсан ч итгэгч хүн бүр авралын зар тараагч байхаар дуудагдсан. Та чуулганаа авралын зар тараахын баяр хөөр рүү удирдах хэрэгтэй. Авралын зар тараана гэдэг нь бодит Аврагчыг бодит хүнд бодитоор хүргэх ажил юм. (Билли Сандэй).

1. **Авралын зар тараагч байх шалтгаанууд: (Сургаалт үгс 11:30)**
 - a. Амь үнэ цэнэтэй (Марк 8:35-38).
 - b. Там бол бодит.
 - c. Христ гэм нүгэлтэй хүн нэг бүрийн төлөө зовсон.
 - d. Энэ дэлхий бол хий хоосон.
 - e. Гэр бүлийнхээ тэнгэрийн улсад ороосой гэсэн хүсэл.
 - f. Тэнгэрийн улс бол алдартай.
 - g. Сайн мэдээг тараагч итгэмжит хүмүүст амалсан шагнал байгаа тул.

2. Сайн мэдээ тараагч хүнд байх чанрууд:

- a. Та өөрөө аврагдсан ба өөрийгөө аврагдсан гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй.
- b. Та ариун амьдралаар амьдрах хэрэгтэй.
- c. Хайрын сүнсээр бусдад ханддаг нэгэн байх.
- d. Библийн тухай зохих хэмжээний мэдлэгтэй түүнийгээ яаж ашиглахаа мэддэд байх.
- e. Та залбирагч нэгэн байх.
- f. Ариун Сүнсээр дүүргэгдсэн нэгэн байх.
- g. Төөрсөн сүнсний төлөө гэсэн сэтгэлтэй байх.

Ярилцах сэдэв: Дээр дурдсан чанрууд яагаад чухал вэ?

17-р Хичээл - ХЭРХЭН ГЭРЧЛЭХ ВЭ

1. Яаж сайн мэдээг тараах вэ?

- a. Христийн гэрч өөрөө аврагдсан байх ёстой.
- b. Өөрийн итгэсэн түүхээ товчхон ярьж амьдрал чинь яаж өөрчлөгдсөн талаар хуваалцах.
- c. Залбирлын хариу авсан гэрчлэлээ ярих (Дуул. 50:15).
- d. Христ таныг хэрхэн дүүргэдэг тухай ярих.
- e. Гэм нүгэл уруу таталтыг даван гарсан тухай гэрчлэлээ ярих.
- f. Библийн дуртай ишлэлээ хуваалцан Бурхан танд Бичээсээр дамжуулан юу ярьсан тухай хуваалцах.
- g. Найзууддаа Христийн сайн мэдээг ярьж Түүний тухай ярих.

2. Христийг тунхаглахад саад болдог зүйлс:

- a. Хүнээс айх (2 Тим. 1:7; 1 Иох. 4:18; Фил. 4:13).
- b. Ичгүүр (2 Тим. 1:8).
- c. Зүй бус амьдрал (1 Иох. 1:9).

Жич: Езекиел 33:8-д бид сайн мэдээг тунхаглахгүй бол ямар аюултайг харуулсан.

Даалгавар: Та яаж итгэгч болсон тухайгаа болон таны амьдрал хэрхэн өөрчлөгдсөн тухай гэрчлэлэ бэлдэнэ үү.

18-р Хичээл - САЙН МЭДЭЭ ТАРААХ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Сайн мэдээний дөрвөн хууль ном нь нилээн түгээмэл хэрэглэддэг ба маш үр дүнтэй.
2. Бичиггүй ном буюу хар, улаан, цагаан, алтлаг болон ногоон өнгөтэй номыг ашиглан ярих.

3. Өөр нэг арга нь сайн мэдээг ярихдаа та **таван хуруугаа ашиглаж болно**. Танд ямар нэгэн ном хэрэгсэл хэрэггүй.
 - a. Эрхий хуруу - Бурхан танд хайртай (Иох. 3:16).
 - b. Долоовор хуруу - Бүх хүн гэмтэй (Ром 3:23).
 - c. Дунд хуруу - Христ нас барснаар гэмийн төлөөсийг төлсөн (1 Кор. 15:3).
 - d. Ядам хуруу - Христ таны гэмийн төлөө нас барсанд итгэх (Иох. 1:12).
 - e. Чигчий хуруу - Та итгэвэл мөнх амьтай болно (Ром 6:23).
4. Зарим хүмүүс **Ромын Зам** буюу ишлэлээр тайлбарлах арга хэрэглэдэг.
 - a. Хүний хэрэгцээ (Ром 3:23).
 - b. Гэмийн шийтгэл (Ром 6:23).
 - c. Бурханы хангамж (Ром. 5:8).
 - d. Бурханы аврал (Ром 10:9).
5. Библийн тодруулсан хэсгүүдийг авралын зар тарааж байгаа хүнтэйгээ хамт унших нь үр дүнтэй байдаг. Та Библиэ бэлдээд бэлэн байгааг чинь үнэлэнэ. Хуваалцах ишлэлүүдээ тодруулаад, Ром 3:23 гэж тэмдэглээд олоход амархан болгон бэлдэх нь чухал. Ром 6:23-р “хуудаснаас харна уу” гээд хуудасны дугаараа бичиж тэмдэглэх. Энэ зарчмаар Иох. 1:12; 1 Иох. 1:9; Илчл. 3:20, 1 Иох. 5:10-13 -г тайлбарлах.
6. Авралын залбирал бол сайн мэдээ тараасны дараах хамгийн чухал хэсэг. Та сайн мэдээг сонсогч нарт гэм нүглээ хүлээн гэмшин, Есүсийг өөрийн Аврагч болгон хүлээн авах боломжыг гаргаж өгөх нь маш чухал.
7. Авралын залбирлыг дараах байдлаар хийж болно. “Тэнгэрлэг Аав минь, би бол гэмтэй хүн ба надад таны аврал хэрэгтэй байна. Есүс Аврагчийг илгээсэнд баярлалаа. Тэр загалмай дээр цовдлогдоод дахин амилсан гэдэгт би итгэж байна. Би Түүнийг өөрийн Аврагч Эзнээ хэмээн хүлээн авч байна. Намайг аварсанд Аавдаа баярлалаа”.

Даалгавар: Дээр дурдсан аргуудаас алийг нь ашиглан сайн мэдээ тараах тухай шийдээд оролцогч бүр ишлэлээ цээжлэн бие биедээ авралын зар тараах дадлага хийнэ үү. Сайн мэдээ тараасны дараа тэр хүн итгэхээр шийдсэн шийдвэрийг сонсож уучлалын залбирал заавал хийлгээд дуусгана уу.

19-р Хичээл - ӨГӨӨМӨР БАЙДЛЫН ТУХАЙ

Бурханд өргөл өргөх нь таны хүмүүст хэцүү даалгавар байж болох юм. Тиймээс энэ талаар зааж зүрхэнд нь үр суулгасанаар тэд баяр хөөртэйгээ өгч сурах болно.

Бурханд яаж өргөх вэ?

1. Ёс журамтайгаар (1 Кор. 16:2). “Долоо хоног бүрийн эхний өдөр” Эзэнд өргөж сурвал Бурхан таны итгэл болон өгөөмөр байдлыг шагнах болно.
2. Хувьчлан өгөх (1 Кор. 16:2) – “Хүн бүр өргө” гэсэн. Энэ үг нь зөвхөн гэрийн эзэнд хэлэгдсэн үг биш харин ээж болон хүүхдүүдэд баян болон ядуу бүх хүнд хамаатай.
3. Бололцоогоороо өгөх (1 Кор. 16:2) – “Бурханаар өгөгдсөнчлөн” өгөх гэдэг нь бид аравны нэгээ өргөөд зогсохгүй өөр бусад өргөдөг байх хэрэгтэй. Бурхан өгөөмрөөр өгсөн нэгнийг ивээдэг.
4. Баяр хөөртэйгээр өгөх (2 Кор. 9:7) - албадлагаар бус.
5. Золиос гарган өргөх (2 Кор. 8:2) - Тэд боломжгүй байхдаа ч өргөж байсан. Бэлэвсэн эмэгтэй өөрт байсан хоёр зоосоо өгдөг. Бурхан хир их өргөл өргөснөөр биш бидэнд юу үлдснээр хэмждэг. Эзэнд харамгүй өгсөн өргөлүүд нь ивээлийг дагуулдаг. (Үйлс 20:35; Матт. 6:20; Мал. 3:10).

Нэмж хэлэхэд: Та өөрөө өгөөмрөөр өгөхгүй бол таны хүмүүс бас өргөхгүй.

Ярилцах сэдэв - Танай чуулган Бичээсийн дагуу өргөл өргөдөг үү? Цаашид энэ тал дээр юун дээр анхаарах хэрэгтэй байна?

20-р Хичээл - БУСДЫГ ХЭРХЭН ЗЭМЛЭХ ВЭ?

Бурхан нигүүслээрээ гэм нүглээс бид бүхнийг угаасан. Бид гэм нүглээ улайх үед (1 Иох. 1:9), Тэр биднийг ариусгадаг. Харин гэм нүглээ гэмшихгүй байх нь зүрхийг хатууруулдаг. Евр. 3:13-т хэлэхдээ “өнөөдөр гэгдэж л байгаа бол бие биенээ зоригжуулагтун гэсэн. Эс бөгөөс та нараас хэн нэгэн чинь нүглийн мэхлэлээр хатуурах вий”. Гэм нүглээ улайх нь нөхөрлөлд маш чухал. Хэрэв ах дүүгээс чинь хэн нэгэн нь гэмд унавал бид тэдэнтэй ярилцах хэрэгтэй. Тэгвэл яаж ярих нь зүйтэй вэ?

1. Дөлгөөн байдлаар ярих (Лук 9:54-56; 1 Тес. 2:11; Матт. 12:20).

2. Даруу сэтгэлээр ярих (Ром 12:10; Ефес 4:2).
3. Бурханыг үгийг ашиглах (2 Тим. 3:16-4:2; Кол 3:15).
4. Сүнсний удирдамж доор байх (Ефес 5:18, 19).
5. Ганцаарчлан уулзаж бичээсийн үгээр дамжуулан ярих (Матт. 18:15).

Паул гурван жилийн турш өдөр шөнөгүй хүмүүст анхааруулахаа зогсоогүй. (Үйлс 20:31).

Ярилцах сэдэв - Бусдыг олны өмнө хатуу зэмлэвэл ямар үр дагаварт хүрч болох вэ? Үүнээс яаж болгоомжлох вэ?

21-р Хичээл

ЧУУЛГАНЫ ГИШҮҮДИЙН ГЭМ БУРУУТАЙ АСУУДЛЫГ ЯАЖ ШИЙДЭХ ВЭ?

1. **Библийн зарчмыг баримтлах** (Матт. 18:15-17).
 - a. Тэр хүнтэй ганцаарчлан уулзаж гэмшихийг уриалах.
 - b. Хэрэв тэр хүн үл сонсвол, хоёр юм уу гурван гэрч авч очих.
 - c. Хэрэв бүүр болохгүй бол чуулганд зарлах.
 - d. Хэрэв өөрчлөгдөхгүй бол итгэгч биш гэж тооцогдоно.
2. **Сахилгажуулах шалтгаан**
 - a. Буруу сургаал заах бол (Тит 1:13). Буруу урсгалын сургаал нь итгэгчдийг мэхэлдэг. Үүнээс тэдний хамгаалах нь чухал.
 - b. Бусдын өмнө гэм хийж байгаа бол. (2 Тим. 5:20).
 - c. Ёс суртахуунгүй байдал (1 Кор. 5:1-5).
3. **Гэм хийж байгаа ахан дүүсээ яаж залруулах вэ?**
 - a. Даруу байдлаар ярилцах (1 Кор. 10:12).
 - b. Чин сэтгэлээсээ ярилцах (Матт. 7:3-5).
 - c. Хайраар хандах (1 Кор. 13:4).
 - d. Бичээсээр зэмлэх.
 - e. Гэрчлэл бол туршлагаа хуваалцах.

Даалгавар: Танай чуулганд гэм дотор амьдарж байгаа хүн байна уу? Тийм бол хэрхэн энэ асуудлыг шийдэх вэ?

22-р Хичээл - ИТГЭЛЭЭР УНАСАН НЭГЭНД ХҮРЭХ

Нэгэн цагт хүчтэй итгэгч байж байгаад итгэлээс ухран явсан хүмүүсийг бид мэднэ. 1 Кор. 10-12 болон Сур. үгс 16:18-т энэ талаар анхааруулдаг. Хэн ч гэнэт итгэлээ орхидоггүй. Бага багаар холдсоор нэг мэдэхэд амьдрал нь өөр болсон байдаг.

Итгэлээ хаях бодит шалтгаанууд

- a. Залбирахгүй байх.
- b. Библи уншихгүй байх (2 Тим. 2:15).
- c. Сүмдээ явахгүй байх (Евр. 4:30).
- d. Ариун Сүнсэнд дуулгаваргүй хандах (Ефес 4:30).
- e. Христийг тунхаглахгүй байх (Матт. 10:33).
- f. Гэрэл дотор алхахгүй байх (1 Иох. 1:7).

2. Итгэлээс холдон явахын үр дагавар

- a. Хүч, амар тайван, баяр хөөр, аз жаргалаа алддаг.
- b. Өдөр бүрийн амьдрал нь харанхуй бухимдлаар дүүрэн болдог
- c. Шагналаа алдаж уй гашууд автдаг.
- d. Зарим хүмүүс ийм байдал нь сүнсийг хөнөөх аюултай гэж үздэг.

3. Бурхан биднийг угтан авахад бэлэн байдаг (Иер. 3:22; Хос. 14:4).

Жинхэнэ итгэгч урвадаггүй - Би нүднийхээ өмнө үл бүтэх зүйлийг байлгахгүй. (Дуул. 101:3). Христ итгэгч нэгэн Есүс рүү харах хэрэгтэй. (Евр. 12:2). Паулын зорилго бол Христийг олох байсан (Фил. 3:14).

Даалгавар: Таны эргэн тойронд дүүрэг хороололд итгэлээсээ холдон явсан хүмүүс байна уу? Тэгвэл тэднийг хэрхэн Христ руу авчрах талаар тэдний төлөө залбирч сүнсний эргэлт хийх арга замуудыг бодно уу.

23-р Хичээл - САЛАЛТ

Таны чуулганы гишүүн гэр бол салалттай нүүр тулвал яах вэ? Дэлхийн хаана ч гэр бүлд тулгардаг хамгийн том асуудал бол салалт. Энэ бол маш эмгэнэлтэй учир нь айл гэр үгүй болж нийгэм хямардаг. Энэ нь чуулганы хувьд бол давхар гамшиг юм. Учир нь Бурханы нийлүүлсэн ариун нэгдэл нь Христ ба Түүний сүмийн нэгдлийн бэлэг тэмдэг болдог ба үүнийг салгах маш эмгэнэлтэй. Тиймээс Сатан гэр бүлүүд рүү дайрдаг.

Салалт айл гэрийг бусниулж, зүрхийг шархлуулж, орон гэргүй хүүхдүүд, замбараагүй залуучуудыг болон ганцаардал нулимсыг дагуулдаг.

Библи-н Маттай 19:9-д салах нэг нөхцлийг хэлсэн ба тэр нь садар самуун явдал. Энэ нь хориотой бэлгийн бус харьцаанд орох, гуравдагч этгээдтэй байнгын харилцаатай болхыг хэлнэ. Хэдийгээр ийм нөхцөлд орсон ч салах ёстой гээгүй, бүүр ноцтой нөхцөлд л салахыг зөвшөөрсөн. Хосуудыг салгахгүйн тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй.

Санаа авах зөвлөмжүүд:

1. Матай 19:6-д хэлснээр гэрлэлт бол насан туршынх байх ёстой. Гэрлэлтээр дамжуулан Бурхан хоёр хүнийг нэг болгох гайхамшигийг хийдэг. Зөвхөн Бурхан л энэ нэгдлийг үхэл хагацлаар дамжуулан салахыг зөвшөөрдөг.

2. Хэрэв хүүхэдтэй хосууд бол хүүхдийн ирээдүйг харгалзах хэрэгтэй учир нь хүүхэд хамгийн их хэлмэгддэг.
3. Салалт бол олны өмнө хийж байгаа хамгийн том алдаа.
4. Хосууд тус тусдаа Эзний өмнө ирэх хэрэгтэй тэгээд дараа нь хоорондоо эвлэрч гэмших аваас гэр бүлээ аврах боломжтой.

Хэрэв хосууд эвлэрвэл, зовж жаргах аль ч үед үхэл салгах хүртэл хамтдаа гэсэн хуримын тангаргыг дахин өргөх хэрэгтэй. Аль аль нь чармайж, бие биедээ санаа тавьж Бурханаас бие биеэ хайрлах ариун хайрыг байнга гуйх хэрэгтэй.

Ярилцах сэдэв - Итгэгч гэр бүлийн хамгын чухал онцлог юу вэ? Түүнд ямар аюултай нөлөөнүүд байж болох вэ?

24-р Хичээл - ХАВЧЛАГА

- A. Бурханлаг хүнд хавчлага заавал ирнэ
 1. Паул хэлэхдээ Христ Есүс дотор ариун амьдрах хүсэлтэй хүн бүрд хавчлага ирнэ гэсэн. (2 Тим. 3:12).
 2. Есүс хэлэхдээ “энэ дэлхий дээр та нар зовлонтой байна” гэсэн. (Иох. 16:33).
 3. Петр зүй бусаар хавчагдаж байгаа тухай бичихдээ “Яагаад гэвэл та нарыг мөрөөрөө дагуулахын тулд та нарт үлгэр дуурайл үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн” гэсэн. (1 Петр 2:21).
- B. Элч Паул хавчлагт орсон ч Христ руу хүмүүсийг дагуулахын тулд юунд анхаарах тухай заавар өгсөн:
 1. Ром 12:9-21-т бичихдээ бузар мууг тэвчин сайныг үйлд гэсэн. Мөн зовлон дотор тэвчээртэй байж үргэлжлүүлэн залбир гэсэн.... (Ром 12:12).
 2. Паул үргэлжлүүлэн хэлэхдээ, та нарыг хавчигч нэгний ерөө гэсэн. (Ром 12:14). Өөрөөр хэлвэл бидэнд муугаар хандсан хэн нэгнээс өшөө авах, хариуг нь барих гэсэн бодол байж болохгүй тийм байх нь буруу юм гэсэн.

3. Тэрээр үргэлжлүүлэн хэлэхдээ бузар мууг бузар муугаар бүү хариул харин мууг харин сайнаар дийл гэсэн. (Ром 12:21).
- C. Бид хавчлагт орсон ч тэр дундаа баяр хөөртэй байж болно.
1. Хавчлага ирэх нь тодорхой болохоор бид түүн рүү гүйж очоод зовлонд унана гэсэн үг үү? Огт үгүй. Харин бид хавчлагыг даван гарч чадна гэсэн утгатай.
 2. Үүний тод жишээ бол Христ өөрөө юм. Тэрээр загалмайг үүрч, олны өмнө ичгүүр болж найз нөхөд олны өмнө гэмт хэрэгтний адил үхдэг.
 - i. Бурханы хүүгийн үхэл нь түүхэн дэх хамгийн том ялагдал байсан бол энэ нь үхлээс дахин амилж түүнд итгэсэн бүхэнд авралыг өгөх хамгын агуу ялалт болж хувирсан.
 - ii. Тэр өнөөдөр ч ажлаа хийж байгаа Түүний үхэлд хүргэсэн хүмүүсийн төлөө Христ өөрийгөө золиосолсон.
 - iii. Үүний адилаар, өнөөдөр сүм чуулганыг хавчиж байгаа хүмүүс нь Христийн аврал хамгийн хэрэгтэй хүмүүс юм.
- D. Бурхан хавчлагыг ашиглан олон хүмүүсийг Түүн руу ирүүлж Түүний нэрийг доромжилж бидэн руу дайрч довтолдог тэдгээр хүмүүсийг Түүн руу эргүүлэхийн төлөө залбирцгае.

25-р Хичээл - МЭРГЭ ТӨЛӨГ

Африкт хүүхдийг усан баптисм хүртээх үед хэвлий хэсгээр нь сахиустай утас зүүсэн байхыг харж болно. Ингэж болох уу? Огт үгүй. Сахиус бол дом ба энэ нь нэг төрлийн увдис юм. Библи дээр мэргэ төлөг болон ид шидэнд итгэх нь бузар сүнснийг дагаж байгаатай утга нэг гэсэн.

Дараах ишлэлүүдийг уншина уу. Гэт. 22:18; Үйлс 19:18, Гал. 5:20; Илч. 22:15.

Мэргэ төлөг, хор уулгах зэрэг заншил олон газрыг харанхуйн дарлалд оруулдаг ба зөвхөн сайн мэдээгээр гэрлийг авчрах боломжтой. Чөтгөр өнөөдөр ч хүмүүсийг хуучин амьдралаараа харанхуйд амьдруулахыг хүсдэг. Гэвч Христ харанхуйд орших боломжгүй.

Мэргэ төлөгч, ид шидтэнгүүдийн байх газар нь хүхэр галаар шатаж буй нуур юм. (Илч, 21:8.)

Хүн бүр хэнд үйлчлэхээс шийдэх хэрэгтэй учир нь хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй.

Ярилцах сэдэв - Таны амьдардаг газар ямар илбэ шидэнд итгэж шүтдэг вэ?

26-р Хичээл

ЯАГААД АРХИ УУХГҮЙ БАЙХ ТАЛААР ЗААХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Архидалт бол тухай хүнийг болон гэр бүлийг нь сүйрүүлдэг хараал гэдгийг хүн бүр мэддэг. Архи уух нь ямар буцар тухай олон ишлэл байдаг.

“Дарсан бүү согтуур харин сүнсээр дүүрэн” бай гэж Ефес 5:18-д хэлсэн. Дарс нь бидний зан авирт нөлөөлж, Бурхан бидний хэн байгаасай гэдгээс өөр хүн болгодог. Дарснаас илүү Сүнсээр дүүрэн байж, хайр, баяр хөөр, амар тайван, тэвчээр, сайн сэтгэл, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдлаар дүүрэн амьдар гэж Галат 5:22-23-т хэлсэн.

Иохан Баптистын тухай Лук 1:15-д хэлэхдээ Эзэний өмнө тэр агуу болох бөгөөд дарс ч, сархад ч ер амсахгүй байх болно гэсэн. Шинэ Гэрээнд ойнос гэдэг Грек үгийг хэрэглэсэн байдаг. Энэ нь иссэн ундаа гэсэн утгатай. Есүс хэлэхдээ, ь Бид дарсыг хуучин туламд хийдэггүй, тэгвэл шинэ дарс тулмыг зад татна гэсэн. Библийн Эхлэл 9:21 номонд анх удаа дарсны тухай гардаг. Ноа усан үзмийн дарснаас ууж согтоод майхан дотроо нүцгэн байсныг хүү нь харсан ба үүний уршиг гай гамшиг нь Хам хүүд нь ирдэг.

1. Дарс биднийг болчимгүй алхам хийхэд хүргэдэг. Өөрөөр хэлвэл мэхлэгч. (Сур. үгс 20:1; Хос 4:11).
2. Сүмийн ахлагч нар дарсанд шимтэж болохгүй (Тит 1:7). Энэ ишлэлд гардаг Грек үг нь (пара-ойнос) буюу дарснаас хол бай гэсэн утгатай.
3. Дарс донтуулдаг ба сүйтгэдэг (Сур.үгс 23:29-35).
4. Дарс таны мэргэн ухааныг, амьдралын зорилгыг болон үйлчлэлийг чинь устгах аюултай. (Иса. 28:7).
5. Согтох бусад гэмтэй адил гэж бичигдсэн байдаг. (Гал. 5:19-21; Ром. 13:13-14).

Итгэгч хүмүүс яагаад ууж болохгүй вэ?

1. Таны бие болон Ариун Сүнсний орших дуган тул ямар нэг байдлаар бохирдуулж болохгүй.

2. Та бол Христийн гэрч, хэрэв итгэлээр сул нэгэн таны ууж байхыг хараад илүү уух сорилтонд унах шалтгаан болно.
3. Эхлэл 4:9-д гардагчлан тэр ахан дүүсээ зөв амьдралаар амьдрахад нь туслах үүрэгтэй.

Зөвхөн итгэгч хүн гэлтгүй бүх хүн яагаад уух хэрэггүй вэ гэдэг талаар **зөндөө шалтгаан** байгаа.

1. Мөнгөний гарз (Дэд хууль 21:18-21; Сур. үгс 23:20).
2. Хурдны зам дээр машин барьж яваа хүмүүсийн аюулгүй байдлын төлөө.
3. Архи дарс нь гэр бүлүүдийг бусниулдаг.

Хүн амсаж эхлээд ахиад нэг хундага гэж явсаар архинд ордог тул Христ итгэлт удирдагч нар ямар ч нөхцөлд байсан огт уухгүй байх нь хамгийн зөв.

Ярилцах сэдэв - Христчин хүмүүс уухгүй байх өөр ямар шалтгаан байгаа талаар ярилцана уу.

27-р Хичээл

ЗОВЖ ШАНАЛЖ БАЙГАА ИТГЭГЧ НАРТ ТУСЛАХ НЬ

Маш олон итгэгч нар Бурхан руу хандан “Би яагаад ингэж зовох ёстой юм бэ” хэмээн хашгирдаг. Иовын найзууд нь хүртэл түүнийг шүүж чиний хийсэн гэм нүглээс болж ийм юм боллоо гэж хэлдэг. Мэргэ төлөгч нар таны зовлон хэн нэгнээс ямар нэг юмнаас болсон байна гэж хэлж болох ч жинхэнэ итгэгч хүний амьдралд Бурханы зорилго төлөвлөгөө байгаа. (Ром 8:28).

1. Зовлон зүдгүүр яагаад тохиолддог вэ?
 - a. Заримдаа энэ нь гэм нүглийн үр дагавар байдаг. (Иох. 5:14; Тоол. 12:10; 2 Шастир 16:12).
 - b. Бурханы үйлсийг харуулахын тулд. (Иох. 9:2-3).
 - c. Бурханы алдрын төлөө (Иох. 11:4; Фил. 1:29).
 - d. Бурханы зөвшөөрлөөр чөтгөр ажлаа хийдэг. (Иов; Марк 5:1-5; Лук 13:16; Үйлс 10:38). Бурхан таны хир их ачаа үүрч чадах хэмжээг мэддэг.
 - e. Сахилгажуулалт - Хүүхдээ зэмлэх сургахтай адил (Евр. 12:5-13).
2. Зовлон зүдгүүрт бид яаж ханддаг вэ?
 - a. Түүнд хандахаасаа илүү үл тоож зүрхээ хатууруулдаг.
 - b. Сэтгэлээр унаж яахаа мэдэхгүй болдог. Гэхдээ бид Түүний нигүүсэл надад хангалттай гэдгийг санах хэрэгтэй (2 Кор. 12:9).
 - c. Хүлээн зөвшөөрч хэдий гунигтай ч даван туулдаг.

- d. Бид баяр хөөртэйгээр Бурханы хүсэлд буулт хийх нь хамгийн дээд ялалт юм.

Даалгавар: Таны хонин сүрэг дотор зовж шаналж байгаа 3-7 хүний нэрийг бичнэ үү. Тэд хүмүүст хэрхэн хүрч үйлчлэх тухай болон чуулганы бусад гишүүдийг оролцуулах талаар төлөвлөгөө гаргана уу.

28-р Хичээл - ӨВЧТЭЙ ХҮМҮҮСТ ҮЙЛЧЛЭХ

Христ итгэлт хүмүүс өвдөж зовох үед Эзний боол нар Бурханы хайр халамжийг тэдэнд итгэмжтэйгээр харуулах хэрэгтэй. Өвчин зовлон тохиолдсон хүмүүст хэрхэн хүрэх арга замуудын талаар судлье.

1. Бурхан гайхамшигт эдгэрлийг хийх чадвартай юу?
 - a. Библи дээр маш олон гайхамшигт эдгэрлийн талаар өгүүлсэн байдаг. Хамгийн агуу гайхамшиг бол Христ-н дахин амилалт байсан ба түүнээс гадна маш олон гайхамшиг үйлддэгдсэн.
 - b. Бидний Бурхан бол гайхамшигийг бүтээгч Бурхан. Яавэ Рафи (Гэт. 15:26).
2. Иаков 5:14-т хэлэхдээ тосоор тослон залбир гэсэн.
 - a. Өвчтэй нэг нь чуулганы ахлагчыг дууд гэсэн.
 - b. Ахлагчид Эзэний нэрээр түүнийг тосоос тосолж түүний төлөө залбир гэсэн.
 - c. Иаков мөн бие биедээ гэм нүглээ улай гэсэн.
3. Зарим өвчин эдгэрдэггүй
 - a. Үйлс 28-р бүлэгт Паул хоёр гайхамшиг үйлддэг. Харин тэр гурван удаа өөрийнхөө төлөө гуйсан ч бүтээгүй. (2 Кор. 12:7-10)-т өвчний нэг зорилго бол Паулыг даруу болгох шалтгаан байсан.
 - b. Хэрэв бид эдгэрээд байвал хэзээ ч үхэхгүй.

Христчин үйлчлэгч хүн өвчтэй нэгэнд Бурханы үгээр дамжуулан хүч нэмэх хэрэгтэй. Зөвхөн махан бие нь өвдөөд зогсохгүй сүнс нь өвдвөл ямар аюултай вэ?

Бурханы хүсэл амар амгалангаар дотор эцсийн амьсгалаа хураах хүн бол ивээлтэй нэгэн юм. Есүс хэлэхдээ ь Миний нигүүлсэл өвчин зовлон дунд ч чамд хангалттай гэж амласан.

Ярилцах сэдэв - Өвчтэй хүнийг тайвшруулах ямар ишлэлүүдийн талаар ярилцана уу.

29-р Хичээл - ҮХЭЛ ХАГАЦАЛ ТОХИОЛДСОН ХҮМҮҮСТ ХЭРХЭН ХҮРЭХ ВЭ

Амьдрал гэдэг хорвоогын тоостой адил. Өнөөдөр энд байгаа ч маргааш үгүй болж болно. Дэлхийн бүх хүмүүс дундаас Елиа, Энох хоёр л үхлийг үзээгүй. Христийн дахин ирэлтийг харах үеийнхнээс бусад бүх хүмүүс бүгд хорвоогийн жамаар үхнэ. (Евр. 9:27).

Чуулганы хүмүүст үхэл хагацал тохиолдох үед Христчин үйлчлэгч маш хүнд хариуцлагыг хүлээдэг. Хагацал үзсэн гэр бүлийхэн нь шаналж байхад итгэгч нар хэцүү байгаа хүмүүс дээр очиж уулзах, хоол хүргэж өгөх, ажил явдалд нь туслах хэрэгтэй. Уйлж байгаа нэгэнтэй хамт уйлж Христийн нинжин сэтгэлийг шаналж байгаа хүмүүс харуулах хэрэгтэй. Хэрэв нас барсан хүн итгэгч байсан бол үлдэж байгаа хүмүүсийг тайвшруулахад арай амар. Христтэй хамт байх нь энэ дэлхийн ямар ч нөхцлөөс хамаагүй илүү тиймээс ажил явдал нь хэдийгээр хагацсандаа харамсалтай байгаа ч нөгөө талаараа баяр хөөртэй мөч болохыг гэрчилж болно.

Христэд итгэгч ахлагч удирдагч нар ажил явдлын үеэр гэр бүлийн гишүүд нь аливаа шашины үйлдлийг хийж болохгүй гэдэг дээр бат зогсох хэрэгтэй. Сүнс дуудах, алтан сав нээх, тарни ном уншуулах, ундаан идээ уух, мухар сүсэгтэй холбоотой ямар ч үйлдэл итгэгч оршуулганд байж болохгүй. Итгэгч биш найдвар байхгүй хамаатан садан нь ажил явдлаас болж элдэв шашины үйл хийх гэвэл та үүний эсрэг бат зогсох хэрэгтэй. Ажил явдал дуусах болтол Христэд итгэлтэй хүмүүсээр дамжуулан залбирч, магтаж өөрсдийн зүгээс хийж болох бүх талаар туслах хэрэгтэй.

Салах ёс гүйцэтгэх үеийн номлол нь энэ амьдрал түр зуурынх тул мөнхийн амь амьдралын тухай сэдэвтэй байвал тохиромжтой.

Нэгэн ухаант хүн дагалдагч нартаа тэд нас барахаас өмнөх өдөр үхэлдээ бэлэн бай гэдэг гэвч дагалдагч нар нь “бид маргааш үхнэ гэж үү” гээд тоодоггүй. Гэвч тэр хүн та нар “үхэлдээ бэлэн бай” гэж хэлдэг.

Ярилцах сэдэв - Таны чуулганы гишүүн нас барвал бодит байдлаар яаж туслаж болох вэ?

30-р Хичээл - СҮЙ ТАВЬСАН ХОСУУДАД ЗӨВЛӨХ НЬ

Сүй тавина гэдэг нь хосууд жилийн дотор гэр бүл болно гэдгээ нийтэд зарлаж байгаа ёслол юм. Хосуудын хувьд энэ хугацаа нь бие биенээ илүү таньж үнэхээр хамт амьдрах хань мөн үү гэдгийг мэдэх хугацаа.

Суух нь тодорхой гээд хэт дотносож болохгүй ба гэрлэхдээ ариун байх нь аз жаргалтай амьдрахад чухал үүрэгтэй. Гэр бүл болсон хосуудад өгөгдөх эрх нь гэрлэсний дараа л хүчинтэй болох ЁСТОЙ. Хэрэв тэгэхгүй бол энэ нь үзэн ядалт болж дуусах аюултай. (2Сам. 13:15).

Энэ үед чуулганы ахлагч нар хосуудад итгэгч гэр бүлийн суурийг хэрхэн тавих талаар Ефес 5; Тит 2-г үндэслэн заах хэрэгтэй. Үл ойлголцол болон санал зөрөх тал дээр хамт залбирч сурах хэрэгтэй. Хосуудад бие биенээ хайрлах хайраа насан туршдаа үгээрээ болон үйлсээрээ харуулахыг урамшуулах хэрэгтэй.

Гэрлэлт бол хүний нийгмийн хамгийн анхдагч хэсэг. Аврал авхаас гадна ханиа зөв сонгох хамгийн чухал шийдвэрүүдийн нэг. Сүнсий удирдагч энэ үед маш чухал зөвлөлгөөг өгч дэмжих нь чухал.

Аз жаргалтай гэрлэлтийн зарчмууд

1. Итгэгч хүнтэй гэрлэх. (2 Кор. 6:14-17).
2. Байнга залбирч Бурханы хүслийг хайх.
3. Суух хүнээ маш сайн таньж сайн муу талыг нь мэдэх. Яарвал даарна гэдэг шиг яаран суусан гэрлэлт аюултай.
4. Жинхэнэ хайрыг хүлээ, шохоорхлоор гэрлэх нь хангалтгүй. Насаараа гэрлэх хүнээ бурханлаг хайраар хайрлаж байж аз жаргалтай гэр бүл гардаг.
5. Гэрлэх насанд хүрч байж гэрлэ. Гэрлэлт бол хариуцлагатай тул хүүхдүүд энэ ачаар үүрч чадахгүй, насанд хүрсэн хүний үүрэг.
6. Гэрлэхээсээ өмнө асуудлаа шийд. Хүнийг өөрчлөх гэж суух нь алдаа.
7. Эмэгтэйн аав ээж зөвшөөрөх хүртэл хүлээ. Энэ бол маш чухал.
8. Санхүүгийн хувьд тогтвортой болсон үедээ гэрлэ, энэ нь баян бай гэсэн үг биш санхүүгийн суурьтай бай гэсэн үг.
9. Христчин хурим хийхийг дэмжих хэрэгтэй. Гэрлэлт нь маш ариун нандин зүйл болхоор нууцаар хурим хийхийг огт зөвшөөрч болохгүй.
- 10.

Даалгавар: Аз жаргалтай гэрлэлтийн алхмууд сэдвээр залууст зориулан хичээл бэлдэнэ үү.

31-р Хичээл - ҮР ХҮҮХЭДГҮЙ ХОСУУДАД ХЭРХЭН ЗӨВЛӨХ ВЭ

Хосууд гэр бүл болоод хүүхэдтэй болж чадахгүй удаан байвал тэдний урам дээд зэргээр хугарч Христээс ирэх ялалтыг авч чадахгүйд хүргэдэг. Чуулганд ирж байгаа хүүхдээ дагуулсан хосуудыг хараад “Бурхан яагаад миний залбиралд хариулахгүй байгаам бэ” гэж асуудаг. Зарим нь тэвчиж чадахгүй чуулганыг орхидог. Зарим хосууд мэргэч төлөгч хүмүүс дээр очиж байгаа мөнгө төгрөгөө бүгдийг нь өгч Бурхантай харилцах харилцаагаа ч золиосолдог. Үр хүүхэдгүй хосуудын төлөө залбирч, зөвлөж, туслах нь маш чухал. Тэд Эхлэл 30:1-д гардаг Рахел шиг “надад хүүхэд өг үгүй бол би үхнэ” гэдэг.

Хүүхэдгүй хосуудад Ханнагийн үргүй байсан он жилүүд тэр хугацаандаа нөхрөө хэрхэн дэмжиж байсан түүх сайн жишээ болж болно. Ханна хэдийгээр хүүхэдгүй “Бурхан түүний хэвлийг хаасан” байсан ч Елкана Ханнад хайртай байсан. (1 Сам. 1:1; 5). Эхнэр нь хүүхэдтэй болж чадахгүй байна гээд гэрт нь буцааж болохгүй. Харин ч Елкана шиг нөхөр бай!

Танай чуулганд байгаа Ханна нарт эдгээр зүйлийг сануул:

1. Ханна цөхрөлтгүй залбирч байсан шиг залбир. Бурханы түүний хэвлийг зорилготойгоор хаасан ба цаг нь болоход түүний хэвлийг нээсэн. Бурхан Абрахам Сара хоёрт насны эцэст хүүхэд өгсөн. (Эхл. 21:2). Дуулал 113:9 мөн сайн ишлэл.
2. Эзэний дотор баяртай бай тайван бай. Рахел шиг нөхөртөө бүү үглэ. Өөртөө байгаа ивээлд талархан нүүр царайндаа баяртай бай. Дүнсгэр бүүдгэр байгаа хүний хайрлах нөхрийн хайр үгүй болж та өөрөө хамгын аз жаргалгүй нэгэн болно.
3. Хэрэв Бурхан танд хүүхэд өгөхгүй бол бусад хүүхдүүдийг хайрла. Өнчин өрөөсөн хайр халамж дутсан зөндөө хүүхэд байгаа. Библи судлал юмуу эсвэл хүүхдийн цуглаанд үйлчлэх нь сүнслэг хүүхдүүдтэй байх боломжыг өгнө. Дебора Израйлийн ээж болсон. (Шүүгч 5:7).

Ярилцах сэдэв - Хүүхэд эмэгтэйчүүдэд зориулсан үйлчлэлийг эхлүүлэх тэднийг урамшуулах талаар ярилцана уу.

32-р Хичээл - БЭЛЭВСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ҮЙЛЧЛЭХ НЬ

Танай чуулганд Эзэнд хайртай, итгэмжтэй үйлчилдэг настай эмэгтэйчүүд болон бэлэвсэн хүн байгаа байх. Тэд заримдаа ганцаардаж хүнд хэрэггүй мэт бодож болно. Тэд бусдын адил бэлэг авьяасаа ашиглан Эзэнд үйлчлэх хэрэгтэй. (1 Пет. 4:10). Тэдэнд Библи дээр гардаг эдгээр бэлэвсэн эмэгтэйчүүдийн талаар хэлж өгөөрэй:

1. Наоми ач хүүгийнхээ өрлөг эх болж итгэл үнэмшлээ дараа үедээ үлдээдэг (Рүт 4:16). Өрлөг эх нар Эмээ нар ач гучаа итгэл үнэмшилд хүргэж тэдний хайрыг татан амьдардаг.
2. Зарефатын бэлэвсэн эхнэр Бурханы хүмүүсийг дайлдаг. (1 Хаад 17). Настай эмэгтэйчүүд зочлох үйлчлэлийг маш сайн хийж чадна.
3. Анна гэгч 84 настай эмэгтэй мацаг барилт болон залбирлаар өдөр шөнөгүй үйлчлэн сүмийг огт орхидоггүй. (Лук 2:36-38). Настай эмэгтэйчүүд гайхалтай залбирагчид байдаг.
4. Байгаа бүхнээ өргөсөн эмэгтэй. (Лук 21:4).
5. Цамц хийдэг байсан Доркас гэдэг эмэгтэй бусдад тусалдаг байсан. Түүний хажууд зогсож уйлж байгаа эмэгтэйчүүд бүгд бэлэвсэн байсныг бодоход тэр бас бэлэвсэн эмэгтэй байсан гэж ойлгож болно.
6. Лой түүний ач хүү Тимотыг үйлчлэлд бэлдсэн байдаг. (2 Тим. 1:5).

Бэлэвсэн эмэгтэйчүүдийн үйлчлэл маш үр дүнтэй үе байж болно. Энэ нь тэнгэрийн улсыг хүлээгээд зүгээр суухаас хамаагүй дээр.

Ярилцах сэдэв - Бэлэвсэн эмэгтэйчүүдийн үйлчлэлийн талаар хэлсэн ишлэлүүдийг дахин уншина уу. Жишээ болгон нэмэх хүн байна уу?

33-р Хичээл - АВРАГДААГҮЙ ЭХНЭР/НӨХӨРТЭЙ ИТГЭГЧИД

Өөрөө итгэгч боловч хань ижил нь итгэдэггүй хүмүүст онцгой халамж болон урам зориг хэрэгтэй. Та дараах зааврын дагуу тэдэнд зөвлөж болно.

1. Хэдийгээр эхнэр нөхрийн аль нэг нь итгэгч биш ч гэсэн гэрлэлт бол хоёр хүнийг нэг болгон нэгтгэдэг ариун холбоос юм. (1 Кор. 7:12-13).
2. Гэрлэлтээр дамжуулан итгэгч биш нэг нь аврагдах боломжтой. (1 Кор. 7:14).

3. Ямар ч нөхцөлд байдалд байсан Түүнийг алдаршуулах боломжийг хайх нь чухал. (1 Кор. 7:15-17).
4. Үл итгэгчтэй гэрлэсэн итгэгч хүн Ариун Сүнс түүнд Христийг илэрхийлж гэрэл дотор, Бурханы оршихуйд амьдрах хүчийг өгнө гэж итгэх хэрэгтэй. (1 Кор. 7:15-17).
5. 1 Петр 3:1-2-т хэлэхдээ үл итгэгч нөхөр эхнэрийнхээ бие авч явах байдлыг хараад аврагдана гэсэн.

Ярилцах сэдэв - Үл итгэгч гэр бүлтэй хүмүүстэй яаж дотно холбоотой байж болох вэ? Ямар үйл ажиллагаа явуулвал тэд чуулганд ирж аажмаар Христ рүү ирэх боломжтой вэ?

34-р Хичээл - ЭЗЭНИЙ ӨДРИЙГ САХИХ

Хуучин Гэрээний Саббат өдрөөс үүсэлтэйгээр Шинэ Гэрээнд амралтын өдрийг Эзэний өдөр буюу Ням гариг.

1. Шаббат ба Эзэний өдөр

- a. Долоо хоногийн эхний өдөр бол Шаббат. (Үйлс 20:7).
- b. Эзэний өдөр нь Бурхан зургаан өдрийн турш дэлхийг бүтээгээд долоо дахь өдөр амардаг ба энэ нь Христийн амилсан өдөр буюу Ням гариг юм.
- c. Дээгүүр өнгөрөх баярын буюу Ариун Сүнс итгэгч нар дээр буусан өдөр мөн Ням гариг байдаг.

2. Амралтын өдрийг сахих

- a. Арван хуулийн 4-т Эзэний өдрийг ариунаар сахь гэсэн. (Гэт. 20:8).
- b. Есүс хэлэхдээ амралтын өдөр нь хүн төрлөхтний төлөө юм гэсэн өөрөөр хэлвэл Амралтын өдрийг сахих нь ивээл болохоос хүнд даалгавар биш юм.
- c. Христ дотор чөлөөлөгдсөн итгэгч бид Амралтын өдрийг хэрхэн сахиснаар шүүгдэхгүй. (Кол. 2:16).

3. Эзэний өдрийг сахих

- a. Энэ өдөр Эзэнийг магтан алдаршуулж, залбирч, бусадтай нөхөрлөх цаг болгон өнгөрөөх хэрэгтэй.
- b. Энэ өдөр мөн Эзэнд өргөлөө авчрах хэрэгтэй. (1 Кор. 16:2).

- c. Энэ өдөр бол Эзэн дотор амрах өдөр. Өвчтэй хүмүүс дээр эргэж тойрох Түүний нэр дээр бусдад нигүүлсэнгүй хандах өдөр юм.
- d. Пасторуудын хувьд бүтэн сайн өдөр маш ачаалалтай байдаг тул долоо хоногын дундуур амардаг.

Ярилцах сэдэв –Есүс (Амралтын өдрийн Эзэн) Матай 11:28-29-д юун тухай ярьсан бэ?

Эхлэл номонд хэлэхдээ бүтээлийн эхний 6 өдөрт “өглөө орой” гэж байсан бол долоо дахь өдөр буюу амралтын өдөр өглөө орой гэж байгаагүй. Энэ нь Бурханы тухай болон амралтын талаар бидэнд юу хэлж байна вэ?

35-р Хичээл - ААВ НАРЫН ӨДӨР

Бурхан нөхрүүдийг гэрийн эзнээр томилсон. (Эхл. 18:19; Ефес 5:23). Итгэгч аав нар гэрийнхээ тэргүүн тахилч байх үүргээ биелүүлэхэд урам зориг хэрэгтэй. Тэгвэл чуулганы аав нарыг урамшуулах цуглаан хийж яагаад болохгүй гэж. Эртнээс төлөвлөн зар тарааж гэр бүлийн хүмүүс бүгд ирж аавтайгаа хамт нөхөрлөх боломжийг олгох хэрэгтэй. Аав нараар бичээсийг уншиж залбируулах ба хамгийн залуу аав, хамгийн настай аав болон хамгийн олон хүүхэдтэй аавуудыг танилцуулж болно. Энэ өдрийн сургаал нь Христийг хүндэлдэг аав нар эхнэрээ хайрлах (Ефес 5:25), өвчтэй ч бай, эрүүл ч жаргалтай ч үе, зовлонтой үед ч эхнэртээ итгэмжтэй байж хэцүү үед түүнийг тайвшруулах үүрэгтэй. (1 Сам. 1:8).

Аав хүн хүүхдүүдээ Бурханы тухай зааж сургах хувь нэмрээ оруулдаг нэгэн байх хэрэгтэй. (Сур. үгс. 22:6). Өдөр бүр гэр бүлийн мөргөл хийх цагыг гаргах болон хоолны өмнө талархлын залбирлыг хийх үүрэгтэй. Эцэг эхчүүд хамтдаа хүүхдээ бага балчраас нь Эзэн рүү дагуулах үүрэгтэй. (Мат. 19:13-14).

Тэрээр эхнэр хүүхдээ хайрладаг нэгэн байх ба юунаас түрүүнд Христийг илүү хайрлах хэрэгтэй. Итгэгч аав өөрийнхөө амьдралд үргэлж Бурханыг нэгт тавьдаг байна. (Лук 14:26).

Даалгавар - Аав нарын өдрийн цуглаанд тохирох сургаалын сэдвүүд бэлдэнэ үү.

36-р Хичээл - ЭЭЖ НАРЫН ӨДӨР

Сайн эхнэр, сайн ээж нар бол Бурханаас өгөгдсөн бэлэг юм. (Сур үгс. 31:10). Эхнэрүүдэд магтаал хүндэтгэл хэрэгтэй байдаг болхоор чуулган тэдний гэртээ хийж байгаа үйлчлэл болон тэдний гэрчлэлийг үнэлэх хэрэгтэй.

Ээж нарыг хүндэтгэх цуглаан дээр хүүхдээр нь дуу дуулуулж болно, том хүүхдүүд ээждээ хандан үг хэлж болно. Хүүхэд бүр ээждээ зориулж цэцэг бэлдэж болно. Энэ өдрийн номлол нь Библи-д гардаг эмэгтэйчүүдийн тухай байж болно.

Даалгавар: Ээж нарын цуглааныг хийх хөтөлбөр гаргана уу.

37-р Хичээл - ГЭР БҮЛИЙН ХҮНДЛЭХ ЦАГ

Итгэгч гэр бүлийн амжилттай байх нэг үндэс нь Христ бол манай гэрийн Эзэн гэж хүндлэн Түүний тухай сурч магтах цаг гаргах юм. Гэр бүлийн чимээгүй цаг хийхийг итгэгч гэр бүлүүдэд уриалвал зарим хүмүүс итгэж дагана, зарим нь яг яаж хийх аргаа олохгүй байж болно. Тийм болхоор тэдэнд зориулж цуглаан дээр жишээ болгон үзүүлж болохгүй гэж?

Нэг гэр бүлийг сонгож аваад тэд нартай бэлдэж байгаа яаж гэр бүлээрээ мөргөл хийж болох жишээ үзүүлж болно. Эхний хэдэн мин богинохон магтаал яваад, том болсон хүүхдүүд нь библийн ишлэл уншаад, жоохон хүүхдүүд нь цээжилсэн ишлэлээ хэлж болно. Аав нь библийн уншсан хэсгийн талаар товч тайлбарлан залбираад дуусгаж болно. Тэр гэр бүл суудалдаа суусны дараа товчхон эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт гэр бүлийн мөргөл хийх нь ямар чухал гэдэг талаар номлоод дуусгахад болно. Тайзан дээр дүрслэн харуулсан гэр бүл ивээгдэнэ, бусад гэр бүлүүд түүнийг хараад бас санаа авч амьдралдаа хэрэгжүүлнэ. Үүнээс илүү сайхан үр дүн гэж байх уу!

Даалгавар: Танхим дотор гэр бүлийн мөргөлийн цагыг дүрсэлж үзүүлнэ үү.

38-р Хичээл - ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН БҮРТ ХҮРЭХ

Маш чухал үйлчлэлүүдийн нэг бол гэр бүлийн бүх гишүүдийг тэнгэрийн улс руу дагуулах юм. Ингэхийн тулд эцэг эхчүүд нь итгэлтэй байж үр хүүхддээ заах зарчмаар үйлчлэх нь үр дүнтэй. Зарим нэг санаа болох зааврууд:

1. Хүүхдүүдээ Бурханы үгийг заах тухай нийтэд номлож хувьчлан ятга. Дэд хууль 6:6-9; Сургаалт үгс 6:20-23 болон Дуулал 119:11-с иш татан зааж болно.
2. Эцэг эхчүүдийг хүүхдийнхээ итгэгч нартай гэртээ урьж нээлттэй байх талаар заах хэрэгтэй. Хүүхдүүдээ үлгэр дууриалал болох үүднээс эрч хүчтэй, үнэнч, бүх зүрхээрээ итгэдэг байж чуулганаа дэмждэг байх хэрэгтэй. Хүчтэй гэр бүлийн нэг суурь бол Бурхан хайртай аав ээжүүд юм.
3. Гэр бүлсэг чуулганыг бий болгох. Бүх насны хүмүүс хамтдаа нөхөрлөж залбирч чаддаг орчинг бүрдүүлэх. Бурханы хүмүүс насаар зааглагдаж холдох учиргүй.
4. Том болсон хүүхдүүдтэй хүмүүст инж барих ялангуяа маш том бэлгээр бэр гуйж инж тавих ёслолоос болж гэмд унахаас хамгаалах хэрэгтэй. Зарим хүмүүс инж тавьж чадахгүйгээс хуримаа хийж чадахгүй олон жил болдог.

Үр хүүхэд бол Бурханаас ирсэн том бэлэг юм. Тэдний Эзэн руу дагуулах нь үнэхээр баяр хөөртэй хэрэг бөгөөд тэр бол мөнхөд дуусашгүй баяр хөөр юм.

Ярилцах сэдэв - Дээр дурдсан дөрвөн алхмаас танай чуулган хэрэгжүүлж болох хэсэг юу байна? Өөр санаа оноо байвал хуваалцана уу.

39-р Хичээл

НИЙГЭМД АЖИЛЛАДАГ ИТГЭГЧДИЙГ ҮЙЛЧЛЭЛД ХАМРУУЛАХ

Чуулганы ажлыг таниас өөр аваад явах хүн байхгүй мэт байж болох юм. Та чуулганыг мөрөн дээээр үүрээд бүх үүрэг хариуцлагыг даахгээд хичээж яваа бол энэ нь үнэхээр харамсалтай. Яагаад?

1Петр 4:10-т маш тодоо “хүн бүр авсан бэлгээрээ бие биедээ үйлчил” гэсэн.

Эзэн дотор өсөхийн тулд хүн бүр өөрийн бэлэг авьяасаа ашиглах ёстой хэрхэн үйлдэл болгох нь таны тэдэнд өгөх удирдамжаар зохицуулагдана. Урсдаггүй гол бохирддог. Нийгэмд ажиллаж байгаа итгэгч нараас амийн ус урсах ёстой.

Сайн мэдээний багийг бүрдүүл. Багын гишүүд зарим хөгжим тоглож, зарим нь дуулах ба гэрчлэл хуваалцаж гэсэн үүргүүдийг тус тусад нь өг. Тэдэнд цуглааны нэг хэсэгт үйлчлэх боломж олго. Зарим хүмүүст залбирлын цуглаан удирдах үүрэг өгөөд үз. Өөр нэгэнд нь Библи судлал удирдах, гэрийн групп удирдах бусад нэгэнд нь хүүхдийн цуглаанд үйлчлэх үүрэг өгөөд үз. Энэ бүхнээс хамгын гол нь хэн нэгэнд Христийн сайн мэдээ тараагч байх юм.

Ярилцах сэдэв - Нийгэмд ажилладаг итгэгч нар Түүнд үйлчилж Бурханд хайртайгаа харуулах ямар арга замууд байна?

40 итгэгчдийг ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ӨГӨГДСӨН БЭЛЭГ АВЬЯАСЫГ АШИГЛАХ

Чуулганы эмэгтэйчүүд зүгээр нэг Бурханы ажлыг хараад суудаг хүмүүс байх албагүй. Тэдэнд өгөгдсөн бэлэг авьяас нь чуулганд ивээл болж, Эзний алдрын төлөө ашиглагдаж мөн тэр хүний сүнсийг сэргээдэг.

Чуулганы эмэгтэйчүүдээ дахин нэг ажиглаарай. Дараах гурван үйлчлэлээр дамжуулан Бурханд хэрхэн үйлчилж болохыг уриалаарай.

1. Эмэгтэйчүүдийн үйлчлэл

- a. Ахлагч - өвчтэй болон уй гашуудаж байгаа хүмүүс дээр очиж үйлчлэх.
- b. Залбирлын багийг удирдах эсвэл багтай идэвхтэй байж үйлчлэх.
- c. Библи судлал удирдах.
- d. Шинэ итгэгч нарыг дагалдуулж эгч дүүсийн холбоо үүсгэх.

2. Хүүхдийн үйлчлэл

- a. Хүүхдийн цуглаанд үйлчлэх.
- b. Хөршийн үйлчлэл хийх.

3. Гэртээ хийх үйлчлэл

- a. Хүүхдүүдээ Эзэний тухай заах.
- b. Итгэгч хүмүүст болон үл итгэгч нарт найрсаг зочломтгой хандах.
- c. Нөхөртөө туслах, итгэгч хүмүүсийг урамшуулах, итгэгч биш хүмүүст хүрэх.

Ярилцах сэдэв - Чуулганы эмэгтэйчүүдээ ямар үйлчлэлийг нэмж өгч болох вэ?

АРИУН АМЬДРАЛ

АРИУН ҮЙЛЧЛЭЛД БЭЛТГЭХ

Эдгээр хичээл нь Библийн Түргэвчилсэн Сургалтуудаас хамгийн чухал нь байж магадгүй, учир нь “зүрхний бялхалаар ам ярьдаг” (Мат. 12:34). Зөвхөн ариун амьдралаас сүнсний үр жимс гардаг. Дотоод ялалтыг чинь хулгайлж, гэрчлэлийг чинь устгаж болзошгүй зүйлээс Христ итгэлт удирдагч хүн өөрийгөө байнга хамгаалж байх ёстой. Бид “усан үзмийн мод дотор байхад” (Иохан 15:1-17) Ариун Сүнс биднийг Ариун чанараараа дүүргэж байдаг. Ариун Сүнс бол ариун амьдралын эх сурвалж юм.

Энэ хичээлийн ихэнхи материалыг Дуглас Аалбаны бичсэн “Библийн 100 Хичээл”, Пастор Р. Стэнлийн “Номлогчид болон Хүмүүс”, Эрдэмтэн Лириан Стэнлийн “Өв Тэгш Эмэгтэй” номноос авсан болно.

ГАРЧИГ

1. Эзэнээс Эмээх
2. Сүнсээр Дүүрсэн Амьдрал
3. Муу Ёрын Сүнсийг Эсэргүүцэх
4. Эзэний Хүслийг Мэдэх
5. Чимээгүй Цаг
6. Гэмээс Ангижирах
7. Хувийн Амьдрал
8. Дотоод Сэдэл
9. Ахлагч Хүнд Байх ёстой Шинж Чанарууд
10. Завхайрал
11. Гэр Орноо Захирах
12. Зөвхөн Үнэнийг Ярих
13. Санхүү
14. Сахилга Баттай Суралцах
15. Эрүүл Чийрэг Байх
16. Залхуурах
17. Магтаал
18. Уруу Татлага Ирэхэд
19. Дуурайгчид
20. Ялах нь Гарцаагүй

1-р хичээл - ЭЗЭНЭЭС ЭМЭЭХ

Зөв ба буруу гэсэн 2 төрлийн айдас байдаг. “Бүү ай” гэдэг нь Библийн маш чухал ишлэл. Энэ ишлэл нь Библид 50 удаа хэрэглэгддэг бөгөөд төстэй хувилбаруудтайгаа нийлээд 366 удаа хэрэглэгддэг байна. “Би байна, Бүү айгтун!” гэдэг Эзэний үгийг санаж байна уу? Иов 28:28; Дуулал 19:9; 2-р Самуел 23:3; Дэд Хууль 6:13 ишлэлүүдийг харцгаа.

1. Дараах зүйлсээс бид айх ёсгүй:

- a. Худал шүтээн болон өөр бурхад (2 Хаад 17:38).
- b. Хүн (1 Самуел 15:24; Дуулал 29:25).
- c. Байгалийн гай гамшиг. Энэ нь бидний Аврагч эргэн ирэхийн дохио (Лук 21:25-28).
- d. Ирээдүйн шүүлт (Эврей 10:27).
- e. “Айдсаас” айх ёсгүй, учир нь итгэгч хүн айдсаа Эзэнд хаядаг (1 Петр 5:7). Зөвхөн нэг айдас үлддэг, энэ нь Эзэн Бурханаас эмээх ариун айдас.

2. Эзэнээс эмээхүй гэж юу вэ?

- a. Энэ нь ёрын мууг үзэн ядах явдал (Сургаалт үгс 8:13).
- b. Энэ нь мэргэн ухаан (Дуулал 111:10).
- c. Энэ нь эрдэнэсийн сан (Сургаалт үгс 15:16; Исаиа 33:).
- d. Энэ нь амийн ундарга (Сургаалт үгс 14:27).
- e. Энэ нь цэвэр (Дуулал 19:9).
- f. Энэ нь мөнхөд оршдог (Дуулал 19:9).
- g. Энэ нь Бурханлаг (Эврей 12:28).

3. Эзэнээс эмээвэл ямар үр дүнд хүрэх вэ?

- a. Энэ нь Эзэнд тааллыг авчирдаг (Дуулал 147:11).
- b. Эзэний өмнө хүлээн зөвшөөрөгддөг (Үйлс 10:35).
- c. Эзэн өөрийн хүүхдүүдийг өрөвдөхөд хүргэдэг (Дуулал 103:13).
- d. Энэ нь ивээлийг авчирдаг (Дуулал 112:1).
- e. Ингэснээр ёрын муугаас ангижирдаг (Сургаалт үгс 16:6).
- f. Энэ нь Христ итгэлтэнгүүдийн дунд нөхөрлөлийг бий болгодог (Малахи 3:16).
- g. Энэ нь залбирлын хариуг авчирдаг (Дуулал 145:19).
- h. Энэ нь урт удаан амьдралыг авчирдаг (Сургаалт үгс 10:27).

Ярилцах сэдэв - Айсан сэтгэлийн сул талыг хэрхэн ялах талаар ангиараа ярилцах. Дараа нь Эзэнээс эмээхүйн мэргэн ухааны тухай ярилцах.

2-Р хичээл - СҮНСЭЭР ДҮҮРСЭН АМЬДРАЛ

Итгэгч хүн бүрийн дотор Ариун Сүнс амьдардаг (Иохан 14:16-17). Гэсэн хэдий ч, биднийг Сүнсээр дүүр гэж сургадаг (Эфэс 5:18). Сүнс бидний дотор оршдог ч, амьдралын маань тэргүүн байдаггүй. Оршин суугч боловч тэргүүлэгч биш. Амьдралаа Ариун Сүнсээр удирдуулах үед, бид улам илүү Түүгээр дүүрч байдаг. (Лук 11:13). Амьдралынхаа бүх хэсгийг нэг бүрчлэн Ариун Сүнсний удирдлага дор тавьж өгөхөд, итгэгч хүн Сүнсээр дүүрдэг.

Грек эх хэл дээр энэ нь захиран үргэлжилсэн цаг дээр бичигдсэн бөгөөд үргэлжлүүлэн дүүрсээр бай гэсэн утгатай. Байнга, үргэлжлүүлэн сүнсээр дүүрч байх ёстой. Үйлс 2:4, Үйлс 4:8, мөн Үйлс 4:31-т элч Петр Сүнсээр дүүрдэг тухай өгүүлдэг. Өдөр бүр шинээр дүүрэх хэрэгтэй.

1. Ариун Сүнсээр дүүрэх урьдчилсан нөхцөл:

- a. Гэм нүглээ цагаатгуулсан байх ёстой (Үйлс 2:38).
- b. Бурханы хүүхэд байх ёстой (Галат 4:6).
- c. Сүнсээр дүүрэхийг хүсэж, гуйх ёстой (Иохан 7:37-39, мөн Исаиа 44:3).
- d. Итгэлтэй байх ёстой (Иохан 7:39).
- e. Бурханд дуулгавартай байх ёстой (Үйлс 5:32).
- f. Заримдаа бид хүлээх ёстой (Лук 24:49, Үйлс 1:4).
- g. Ариун Сүнснийг гуйн залбирах ёстой (Лук 11:13).
- h. Сүнснийг хүлээн авах ёстой (Иохан 1:12).

2. Сүнсээр дүүрсэн үед гарах үр дүн:

- a. Гэрчлэх хүчийг олно (Үйлс 1:8).
- b. Христ итгэлийн ялгуусан амьдралаар амьдрах хүчийг олно (Үйлс 20:22-24).
- c. Эзэнд алдар нь очино (Иохан 16:14).

Дүгнэлт: Бид усан сан биш усны суваг. Бид халих бялхах ёстой. Ивээл халин урсах ёстой. Ариун Сүнсний ажлыг Библид хэрхэн дүрсэлснийг анзаардаа.

1. “Мөнх амь өөд оргилох булгийн ус” (Иохан 4:14).
2. “Амийн усны гол урсах болно” (Иохан 7:37).
3. “Сүнс үхлийн биест чинь амь өгнө” (Ром 8:11).

Ярилцах сэдэв - Ангийн зарим гишүүд Сүнсээр дүүрч байгаагүй гэдгээ ухаарч магадгүй. Гэмээ хүлээн зөвшөөрч, залбирсанаар агуу ивээлийг авч болно.

3-р хичээл - МУУ ЁРЫН СҮНСИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ

Бурханы хүүхэд бүр рүү муу ёрын сүнс дайрдаг. Энэ дайралтаас хамгаалах бодит алхамуудыг энэ хичээлд заах болно.

1. Христ итгэлт хүмүүс рүү Сатаны дайрдаг замууд (2 Коринт 2:11)

- a. Биднийг залхуу болгодог.
- b. Үүрэг хариуцлагаар дамжуулан биднийг дарладаг.
- c. Санаа зоволт, гансрал, анхаарал сарниулах замаар биднийг дарамталдаг.
- d. Бид сэтгэлийн шархтай болж, бүх юманд их эмзэг болдог.
- e. Шүүмжлэлийг хүлээн авахын оронд амархан урам хугардаг болдог.
- f. Урам хугараад зогсохгүй, гутралд ордог.
- g. Сүнсний хувьд бардам болох уруу татлагад татагдан ордог.

2. Муу ёрын сүнсийг хэрхэн эсэргүүцэх тухай

- a. Тулгарч буй асуудлыг муу ёрын сүнсний дайралт гэж хүлээн зөвшөөрөх (Иаков 4:7).
- b. Эсэргүүц, тэмц, “Бурханы өвч зэвсгийг агс” (Эфес 6:10-18).
- c. Христийг өөртөө өмс (Ром 13:14).
- d. Эзэний Үгийг ашигла (Матай 4:4,7,10).
- e. “Эзэн минь ээ, би Таныг сонгож байна! Би гэм хийхгүй. Миний дотор оршигч Христийн хүчээр би гэм нүглийг ялж гарна.” хэмээн зоригтой тунхаглах.
- f. Бурханы тусламж, хүчийг гуйн залбирах (Эфес 6:18).
- g. Христийн цусаар өөрийгөө хучин залбирах. “Тэд түүнийг Хурганы цусаар ялжээ” (Илчлэл 12:11).

Ярилцах сэдэв - Муу ёрын сүнсний дайралтанд өртөж байсан уу? Муу сүнсний дайралтыг давж гарах хамгийн үр дүнтэй арга юу вэ?

4-р хичээл - ЭЗЭНИЙ ХҮСЛИЙГ МЭДЭХ

Христ итэлт хүн бүр Бурханы хүслийг хэрхэн таньж мэдэх вэ гэсэн асуудалтай тулгардаг. Хүн нэг бүрийн зан чанар, авъяас бэлэг, хэрэгцээ, орчинд тохируулан бэлтгэсэн Бурханы төлөвлөгөө бий (Эфес 2:10).

Бурханы танд зориулсан төлөвлөгөө бол хувьчилсан, зөвхөн танд хандсан төлөвлөгөө (Дуулал 32:8, 37:23).

Бурханы төлөвлөгөө маш тодорхой, нарийвчилсан төлөвлөгөө (Исаиа 30:21). Энэхүү төлөвлөгөөний тухай асууж шалгаах (Дуулал 143:8), болон амьдралын өдөр бүрийн жижиг сажиг зүйлсийн төлөө биднийг маш их залбирдаг байхыг Бурхан хүсдэг.

Итгэгч нэг бүрт зориулсан төлөвлөгөө нь үргэлж сайн, санаанд нийцсэн, төгс байдаг (Ром 12:2).

- 1. Бурханы төлөвлөгөө дараах шинж чанарыг агуулдаг:**
 - a. Гэмээс салж ариусал руу орох (1Тесалоник 4:3).
 - b. Залбирах болон талархал өргөх (1Тесалоник 5:17-18).
 - c. Сайныг үйлдэх (1 Петр 2:15).
- 2. Бурхан дараах аргаар зааварчилгаа өгдөг:**
 - a. Бурхан ихэнхидээ Библийн ишлэлээр дамжуулж зааварчилгаа өгдөг. Бурханы Үгээр өөрийгөө дүүргэ. Бурханы хүсэл хэзээ ч Библийн Үгээс зөрдөггүй.
 - b. Бурханы Сүнсээр дамжуулан бид дотоод итгэл үнэмшлийг олж авдаг (Ром 8:16; Үйлс 13:2, Иохан 16:13).
 - c. Нөхцөл байдлаар дамжуулан Бурхан биднийг удирддаг. Бурхан нэг хаалгыг хааж, нөгөө хаалгыг нээдэг. Бурханы хүүхдэд хэзээ ч санамсаргүй зүйл тохиолддоггүй.
 - d. Заримдаа, бид хяргасан ноос гарган тавьж удирдамж авдаг (Шүүгчид 6:37-39) боловч нөхцөл байдлыг өөрийн талд тааруулах гэж оролдохгүй байхад анхаарах хэрэгтэй.
- 3. Бурханаас удирдамж авах дараах загварыг Жорж Мюллер гаргасан:**
 - a. Өөрийн хүслээс татгалзах. Сүнсээр удирдуулахад бүрэн нээлттэй байх.
 - b. Бурханы Үгээр дамжуулан Сүнсний хүслийг мэдэх.
 - c. Бурханы урьдаас бэлдсэн нөхцөл байдлыг анзаарах.
 - d. Чиглүүлгийн төлөө залбирах.
 - e. Бурханыг хүлээн сонсох.

Ярилцах сэдэв - Бурханаас тодорхой чиг, заавар авч байсан тохиолдол бий юу? Бурхан удирдаж байгаа эсэхийг хэрхэн тодорхойлох вэ?

5-р хичээл - ЧИМЭЭГҮЙ ЦАГ

Христ итгэлт хүний ялалтаар дүүрэн амьдралын нууц бол чимээгүй цаг юм. Үүнгүйгээр бид сүнсний ялагдалд хүрнэ.

- 1. Өглөө чимээгүй цаг хийх Абрахамын онцгой жишээ:**
 - a. Абрахам өглөө эртлэн босдог байсан. Энэ бол маш сайн хэвшил (Эхлэл 19:27).
 - b. Түүнд Бурхантай уулздаг тусгай газар байсан (Эхлэл 12:7-8). Бид бас тийм газартай болох хэрэгтэй.
 - c. Абрахам хаяа нэг биш, байнга Бурхантай уулздаг байсан.
 - d. Тэрээр Эзэний өмнө зогсоод, Эзэн өөртэй нь ярихыг хүлээдэг байсан.
- 2. Чимээгүй цаг хийхэд хэрэглэх зүйлс:**
 - a. Библи - тогтсон төлөвлөгөөний дагуу итгэмжтэй унших.
 - b. Тэмдэглэлийн дэвтэр, үзэг - Үгээс сурсан зүйлээ бичиж тэмдэглэх.

- c. Залбирлын сэдвээ бичих дэвтэр - авсан хариултаа бичих зай үлдээх.
- 3. Чимээгүй цаг хийх төлөвлөгөө:**
- a. Боломж байвал чимээгүй цагийг тогтмол нэг цагт хийдэг байх.
 - b. Дэс дараатай төлөвлөгөө гаргах, хагас цагт нь уншиж, хагас цагт нь залбирна гэх мэтчилэн.
 - c. Хэт хатуу чанд байх хэрэггүй. Сүнс удирдвал үргэлжлүүлэн залбир. Үг шинэ гэрлээр гэрэлтэж байвал үргэлжлүүлэн уншиж, дүүр.
 - d. Дараах дарааллыг санал болгож байна. Товч залбирах, Библи унших, залбирах. Үгийг залбирал, гуйлтынхаа үндэс болгон залбирах.

6-р хичээл - ГЭМЭЭС АНГИЖИРАХ (1 Иохан 2:15)

“Хорвоо хийгээд хорвоогийн юмсад бүү дурла ...” “Хорвоо” гэдэг үг энд ямар утгатай вэ? Өнөө үеийн дэлхийн тогтолцоо Сатанаар удирдуулдаг гэж дараагийн ишлэлд нь тайлбарласан байна.

1. Бидний мэдэх буруу зүйлс:

- a. Итгэгч хүн итгэдэггүй хүнтэй гэрлэхийг хориглодог (2 Коринт 6:14-17; Амос 3:3).
- b. Бүх шударга бус зүйлс, харанхуйн бүх ажлууд (2 Коринт 6:14). Үүнд бизнес түншлэлүүдийг оруулж болно.
- c. Белиар (анхны чөтгөр, Сатаны нэг нэр) (2 Коринт 6:15).
- d. Шүтээнүүд (2 Коринт 6:16).
- e. Худал сургааль номлогчид (1 Тимот 6:5).
- f. Бүх төрлийн гэм нүгэл болон завхайрал (согтуурал гэх мэт) (1 Петр 1:16).

2. Дагавал зохих үндсэн дүрэм:

- a. Бурхан доторх итгэлийг маань үгүй хийж болох бүх зүйлээс ангижирах ёстой.
- b. Миний гэрчлэлийг устгаж болох бүх зүйлээс салах ёстой.
- c. Ёс суртахууныг маань дордуулж, гэм рүү хөтөлж болох бүгдээс салах ёстой.
- d. Ах дүүг маань бүдрүүлэх ямар ч үйлдлийг би хийх ёсгүй (1 Коринт 8:13).
- e. Махан бие, оюун ухаан, сэтгэл санааны хувьд намайг гэмтээн сүйтгэх ямар ч зүйлээс хол байх ёстой.
- f. Энэ нь есүс Христийн таалалд нийцэх зүйл үү? есүс ийм зүйл хийгээгүй бол би бас хийх ёсгүй (1 Петр 2:21).
- g. Энэ зүйл гэрчлэлийг маань бэхжүүлэх үү эсвэл сулруулах уу? (2 Коринт 6:17).

Ярилцах сэдэв - Гэмт зуршлаасаа салах гэж тэмцэж үзсэн үү? Амьдралд чинь ямар зөрчил байна? Яаж шийдэх вэ?

7-Р хичээл - ХОНЬЧИН ХҮНИЙ ХУВИЙН АМЬДРАЛ

Хувийн амьдрал бол хоньчин хүний хувьд эн тэргүүний чухал зүйл. Учир нь хүмүүс сургаалийг чинь сонсоод долоо хоногийн турш амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж байгааг чинь харах болно.

Нас ахисан Паул, залуу Тимотод бичсэн захидалдаа цэвэр ариун байдлыг сахихыг дахин дахин шаарддаг. Номлогч заасан сургаалийнхаа дагуу амьдарч чадахгүй байгааг хүмүүс амархан олж хардаг.

1. Хоньчин хүн гүн итгэл үнэмшилтэй - Эсүс Эзэнийг гэрэлтүүлсэн, ариун гэгээн хүн байх ёстой.
2. Тэрээр эхнэр, гэр бүлтэйгээ үлгэр жишээ харилцах ёстой. Хонин сүрэгтээ үлгэр дуурайл болох ёстой.
3. Хоньчин хүн залбирлын хүн байх ёстой. Хүмүүс түүнийг өдө бүр, олон цагийн турш залбирдаг гэж найддаг. Бурханы ариун байдлын бэлэг дотор үлдэхийн тулд, дайсны дайралтын эсрэг бат зогсох сүнсний хүчийн төлөө тэрээр ийнхүү залбирах ёстой.
4. Нэг ширхэг үртэс үлдэхгүй болтол тэрээр Эзэний өмнө зогсох ёстой (Исаиа 52:11).
5. Хонин сүргийнхээ төлөө залбирах ёстой (1 Самуел 12:23, Колосай 1:3,9). Боломжтой бол хүн нэг бүрийн төлөө нэрийг нь дуудан залбирах хэрэгтэй.
6. Төөрөлдсөн, мөхөж буй хүмүүсийн төлөө зүрх сэтгэлтэй хүн байх ёстой (Үйлс 20:31). “Эзэний сав суулгыг тээгчид ээ, цэвэр бай!” (Исаиа 52:11)

Ярилцах сэдэв - Үлгэр дуурайл болсон Христ итгэлт ахлагчдыг нэрлэнэ үү. Яамар гайхалтай сайн чанарууд тэдэнд байсан бэ?

8-р хичээл - ДОТООД СЭДЭЛ

Эзэнд үйлчлэгч хүн Эзэний нэрийг алдаршуулая гэсэн зөв сэдэлтэйгээр ажиллах ёстой. Паул мөнгө эсвэл нэр хүндийн төлөө биш, хүмүүсийн зүрх сэтгэл, тэдний аврал, тэдний итгэл бат бэх байхын төлөө ажилласан.

Тэрээр сайн мэдээг тунхаглах нь хойшлуулж болохгүй зүйл гэж итгэн шаргуу ажилладаг байсан (1 Коринт 9:16).

Хүмүүс итгэж байвал идэх уухаа хойш нь тавихаас буцдаггүй байсан (1 Коринт 9:4).

Паул Коринтод байхдаа хүмүүст эргэлзээ төрүүлэхгүйгээр илүү олон сүнсийг аврахын тулд цалин авалгүйгээр ажилласан. Тэрээр нийгмийн олон янзын давхаргад орж дасан зохицдог байсан (1 Коринт 9:19-23).

Аль болох олон хүнийг аврахын тулд Паул гэрлэх, гэр орон, үр хүүхэдтэй болохоос татгалзсан.

Гайхамшигтай сайн мэдээ, цаг хугацаа богино, үхэл ойрхон, Эсүс ирэх дөхөж байна гэсэн шалтгаанаар Паул бүхнийг Бурханы алдрын төлөө хийсэн (Колосцай 3:17; 1 Коринт 10:31).

Ярилцах сэдэв - Үйлчлэлийн төлөө Паул ямар золиос гаргасан бэ? Эдгээр нь чухал зүйлс үү? Энэ хичээлд дурьдсан Паулын дөрвөн шалтгааныг нэрлэнэ үү.

9-р хичээл - АХЛАГЧ ХҮНД БАЙХ ЁСТОЙ ШИНЖ ЧАНАРУУД

1. Ахлагч хүн гэм зэмгүй, шударга, зан чанар сайтай, нэр хүндтэй байх ёстой (Тит 1:6).
2. Нэг эхнэрийн нөхөр бөгөөд; дуулгавартай, тэрслүү бус хүүхдүүдтэй байх ёстой (Тит 1:6). Өөрийн гэрийг захирч чаддаг хүн чуулганыг захирч чадна гэдэг шалгуур байдаг.
3. Тэрээр биеэ барьж чаддаг; дарангуйлагч биш. Түргэн зантай биш, зодоонч биш. Дарсанд үл шимтэгч, мөнгөнд шунадаггүй байх ёстой (Тит 1:7). Чуулганы санхүү нь түүнд урхи болохгүй байг. Энэ бол их чухал.
4. Тэрээр зочломтгой; итгэгч ахан дүүс болон үл таних хүнд хайрыг харуулдаг. Эрүүл саруул, цэвэр, сайн бүхэнд дуртай байх ёстой (Тит 1:8).
5. Ахлагч хүнд байх ёстой шинж чанарын тухай 1 Тимот 3: 2-12т илүү дэлгэрэнгүй бичсэн байдаг.

Ярилцах сэдэв - (1) Тит номонд байхгүй шинж чанарууд Тимот номонд байна уу? (2) Энэ хоёр номонд бичигдсэн чанаруудыг харьцуулж үзээд яагаад эдгээр нь ахлагч хүний хувьд чухал гэдгийг тайлбарлана уу. (3) Энэ шинж чанарууд дээр нэмэх зүйл байна уу?

10-р Хичээл – ЗАВХАЙРАЛ

Завхайрлын эсрэг Бурханы анхааруулж хэлсэнийг сүнсний удирдагч байнга тунхаглах ёстой. Бурханы тогтоосон долоо дахь хууль хүчинтэй хэвээрээ (Гэтлэл 20:14,17).

Бурхан завхайрлыг хэрхэн үзэн яддагийг ойлгох тусам гэрлэлт ямар ариун нандин болохыг бид ухаардаг. Бурхан завхайрсан эр эм хоёрт хоюуланд нь алах ял оноосныг санаж байна уу (Леви 20:10)? Сүнслэг удирдагч бэлгийн харилцаатай холбоотой ямар нэгэн зохисгүй үйлдэл гаргаж, нэрээ толботуулахаас зайлсхийх ёстой.

Завхайрал, садар самуун явдал там руу хөтөлдөг нь гарцаагүй (Сургаалт үгс 7:27; 9:13-17; 1 Коринт 6:9,10).

Муу ёрын сүнс Бурханы үйлчлэгчийг унаган сүйрүүлэхийн тулд юуг ч хийхэд бэлэн бөгөөд үйлчлэлийнхээ оргилд явж байгаа хүнийг унагах нь түүнд маш их таашаалыг авчирдаг. Учир нь тэрээр маш хол, хүндээр унаад зогсохгүй Эзэнтэй хамт алхаж байсан бусад дагалдагчдыг хойноосоо дагуулна. Харамсалтай нь, эмэгтэй хүнтэй болгоомжгүй харилцсанаас болж сүнслэг олон удирдагч сүнсний ялалт болон эрх мэдлийн оргилоос харанхуй хөндийд ялагдан унадаг. Үйлчлэл нь сүйрч, нэр хүндэд нь засагдахын аргагүй толбо сууж, Эсүс Христийн сүм хүмүүсийн элэг доог болдог.

Бурханы үйлчлэгч, уруу татлаганд орохгүйн тулд байнга өөрийгөө хамгаалж байх ёстой. Уруу татлагыг бага дээр нь дарж авах хэрэгтэй. Тэрээр эмэгтэй хүнд зөвлөгөө өгч, залбирахдаа эхнэр эсвэл чуулганы ахлагчтайгаа хамт байх ёстой. Ёс суртахууны хувьд ямар ч зохисгүй үйлдэл гаргахаас зайлсхийх ёстой.

Сатаны жаднаас Бурхан чамайг хамгаалахын төлөө маш их залбирахаас гадна аюулын дохио ирэхэд маш болгоомжтой байх хэрэгтэй. Залбирахын хажуугаар сонор сэрэмжтэй байх хэрэгтэй.

Ярилцах сэдэв - Самсон, Давид хоёрын жишээг аваад үз. Эмэгтэй хүнтэй зохисгүй харилцаанд орсноос болж ямар их уй гашууг авчирдаг билээ.

11-р хичээл - ГЭР ОРНОО ЗАХИРАХ

Гэр доторх ариун байдал индэрийн ар дахь ариун байдлыг дагуулах ёстой. Абрахам гэр орноо сайн захирч чаддаг байсан учир Бурхан түүнд илүү их хариуцлага хүлээлгэдэг бол Эли үл бүтэх хөвгүүдээ захирч чадаагүй учир шийтгүүлдэг (1 Самуел 2:12).

1. **Христ итгэлт удирдагч үлгэр жишээ нөхөр байх ёстой.** Эхнэрээ хэрхэн хайрлаж халамжилж байгааг хараад эмэгтэйчүүд түүнийг уруу татаж зүрхлэхгүй. Түүний эхнэртээ хандах хандлага нь чуулганы дотор эмэгтэйчүүдийг хүндэтгэх жишиг болно.
2. **Хайраар дүүрсэн, эмх журамтай гэр бүлтэй эсэхийг хүүхдүүдээс нь харж болно** (1 Тимот 3:12). Хүүхдүүд нь дуулгавартай, эцэг эхдээ захирагддаг байх ёстой. Хүүхдүүд нь өөрийг нь хүндлэхгүй бол гадны хүн түүнийг хүндэтгэхэд хэцүү билээ.
3. **Удирдагчийн гэр нь итгэгч ахан дүүс болон танихгүй хүмүүсийн өмнө нээлттэй байх ёстой** (Тит 1:8). Гэр нь Бурханлаг уур амьсгалтай байвал ирсэн зочид энэ гэрийн тэргүүн Христ гэдгийг амархан таньж мэдэх болно.

Ярилцах сэдэв - Христ итгэлт удирдагчийн хүүхдүүд чуулганы бусад залууст ямар нөлөөтэй вэ? Хүүхдүүдээ хэзээнээс сургаж эхлэх ёстой вэ?

12-р хичээл - ЗӨВХӨН ҮНЭНИЙГ ЯРИХ!

Үг чинь “За бол за, үгүй бол үгүй” байг (Матай 5:37). Ахлагч хүн “гэмгүй худал” ярьдаггүй, итгэл даасан хүн байх ёстой. Эзэн хууран мэхлэх тухай хатуу анхааруулсан байдаг (Дуулал 101:7).

1. **Хэт дэвэргэн ярих** - Сайн мэдээ тараагчид инхэнхидээ хэт дэвэргэн ярих гэм үйлддэг. Цөөн тооны хүн байсан хэдий ч, маш олон хүн цугларч, олон хүн итгэсэн гэж мэдээлдэг. Энэ нь Бурханыг бус, өөрийгөө алдаршуулахын тулд хийж байгаа үйлдэл.
2. **Биелэгдээгүй амлалтууд** - Амласан бол амлалтаа биелүүлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол амлалт чинь худал үг болж хүвирдаг. Бурхан худалч хүнийг ивээдэггүй.

Ярилцах сэдэв - Дараах ишлэлийг уншаад, ярилцаарай. Дуулал 101:7; Сургаалт үгс 12:22; 19:5; Колоссай 3:9; Ичлэл 21:8.

13-р хичээл - САНХҮҮ

Христ итгэлт хүн, бусад хүмүүсийг бодвол, хамгийн түрүүнд итгэмжтэйгээр өр зээлээ төлнө гэж найддаг. Харамсалтай нь, тийм биш ажээ. Бизнес эрхлэгч олон хүн, Эзэний үйлчлэгч нарт зээл өгөхөөс татгалздагийн учир нь тэдэнд хууртагдагдаж үзсэн байна. Ахлагч хүн Эзэний нэрийг гутаана гэдэг ямар эмгэнэлтэй зүйл вэ.

Хайраас өөр ямар ч өргүй бай гэж Паул маш тодорхой хэлсэн байдаг (Ром 13:8). Ахлагч хүн хувийн болон чуулганы санхүүтэй үнэнч шударга харьцах ёстой. Төлнө гэсэн амлалтандаа хүрч байх ёстой. Тэгэхгүй бол түүний үйлчлэл нурж, Эзэний нэрийг гутаана.

Ярилцах сэдэв - Ром 12:7-р ишлэлийг унш. Энэ ишлэл ямар утгатай гэж та бодож байна? Мөнгө санхүүтэй болгоомжгүй, хамаагүй ханддаг ахлагчийг та мэдэх үү? Христийн үйлчлэлд энэ нь ямар нөлөөтэй вэ?

14-р хичээл - САХИЛГА БАТТАЙ СУРАЛЦАХ

Элч Паул залуу ахлагч Тимотыг “уншлагандаа анхаар” гэж зааварласан байдаг (1Тимот 4:13). Үгийг номлож байгаа хүн, өөрт байгаа бүх материалыг ашиглан Үгийг гүн гүнзгий судлах ёстой. Таныг сонсох бүрт хүмүүс наад зах нь нэг хоёр зүйлийг шинээр сурдаг байх хэрэгтэй гэдэг чухал зөвлөгөөг та сана.

Библийн тайлбар толь болон Бурханы хүмүүсийн бичсэн ном зохиолыг чөлөөтэй хэрэглэдэг байх ёстой.

Ярилцах сэдэв - Үгэн дотор таныг хүчирхэгжүүлсэн ямар ном зохиол та сүүлийн үед уншсан бэ? Ямар сэдэвтэй ном уншсанаа тоочно уу.

15-р хичээл - ЭРҮҮЛ ЧИЙРЭГ БАЙХ

Бидний бие бол Бурханы сүм бөгөөд бид биеэ сайн арчилж хамгаалах ёстой (1 Коринт 3:16). Тэнцвэртэй зөв хооллож, хэтрүүлж идэхгүй байх хэрэгтэй. Эрт унтаж, эрт бос. Өдөр бүр дасгал хий.

Эрүүл дадал зуршил нь танд Эзэнд үйлчлэх нэмэлт жилүүдийг авчирна. Энгийн хялбар амьдарч, дээгүүрх зүйлсийг бодох - гэдэг нь таны амьдралын уриа байх ёстой.

Ярилцах сэдэв - Эрүүл чийрэг байхад тустай дасгал хөдөлгөөнийг хийж үзүүлнэ үү. Эрүүл мэндэд өөр ямар зүйлс нөлөөлдөг тухай ярилц.

16-р хичээл - ЗАЛХУУРАХ

“Бид та нарыг хойргошилгүй байхыг хүсэж байна” гэж бичих шлатгаан Паулд байсан (Эврей 6:12). Христ итгэлт залхуу ахлагч ажлын цагаа шударгаар барьж байгааг шалгах хүн байдаггүй. Тэрээр индэр дээр гараад олон удаа заасан сургаалиа дахин давтдаг. Номлол нь ямар ч хүчгүй, учир нь залбиралд маш бага цаг зарцуулдаг. Чуулганы хүмүүсээ эргэн тойрч, зөвлөгөө өгдөггүй учраас хүмүүс нь хоньчингүй юм шиг байдаг.

Ургац хураах цаг богино. “Ургацын цагт нойртой хүү гутамшгийг хураана” (Сургаалт үгс 10:5). “Нойрноосоо сэрэх цаг хэдийнээ болжээ” (Ром 13:11). Та бол агуу үйлсийн төлөө дуудагдаж, эрхэм нандин үүрэгт хриуцлага хүлээсэн Христийн үйлчлэгч. Өглөө эртлэн босож, магтаал бөгөөд үйлчлэлийн хувиараа дагаж, цаг бүрийг үр дүнтэй өнгөрүүл. “Нойрсогч оо, Сэр!” (Эфес 5:14).

Ярилцах сэдэв - Номлогч хүн залхуу хойрго болоход ямар нөхцөл байдал нөлөөлдөг вэ? Залхуу номлогчтой таарч байсан уу? Чуулганы хүмүүс нь түүнийг хүндэтгэж байсан уу?

17-р хичээл - МАГТААЛ

Та сүнсний харанхуйн замаар явж байна уу? Та цөл дундуур явсаар цуцаж байна уу? Ачаандаа дарагдан таны толгой гудайж байна уу?

Түнэр харанхуй болон сүнсний ялагдлыг давж гарах түлхүүр бол магтаал юм. Магтаал бол таны эм; энэ нь таны бие махбодь, сэтгэл санаа, сүнсэнд гайхамшгийг хийнэ (Сургаалт үгс 15:13; 17:22). Магтагтун! Өөрийн нөхцөл байдалд Бурханыг болон бусдыг буруутгаж цаг, хүчээ бүү үр. Байгаа орчин, нөхцөл байдлаас харцаа холдуулж, Эзэн рүү анхаар. Зовлон шаналал, шархаа март. Энэ бол асуудлаа магтаал болгон эргүүлж, харанхуйн цагт ч магтаалыг авах зохистой НЭГЭН байгааг дэлхийд тунхаглах таны боломж.

Заримдаа магатхад хэцүү үе байдаг - энэ л үед биднийг Бурханы төлөө золиос гарган үргэлжлүүлэн магт гэж сургадаг.

Залбирахаар өвдөг сөгдөх үед гуйлт хүсэлтээ мартан Дуулал 103 эсвэл Давидын бичсэн өөр дууллыг уншиж, Бурханыг магтахад анхаар.

Дахин хэлье, Баяр хөөртэй бай!

Ярилцах сэдэв - 2 Шастирын 20:22-т магтаал яаж нөлөөлж байгааг хар. Дуулал номыг гүйлгэн хар, Бурханыг магт гэж ямар олон удаа тушааж байгааг анзаар.

18-р хичээл - УРУУ ТАТЛАГА ИРЭХЭД

Бурханд үйлчилж буй хүмүүст уруу татлага ирнэ: өөрийгөө хамгаалж чадах эсэх нь тухайн хүнээс шалтгаална. Уруу татлаганд орж гэм нүгэл рүү нэг алхам хазайх үед Ариун Сүнс дараах зүйлсийг сануулж, таныг буцаан түлхэх болтугай:

1. Бурханыг бод (Эхлэл 39:9; 1 Самуел 2:22-25; Иаков 4:4).
2. Өөрийгөө бод (1 Коринт 6:18; Сургаалт үгс 6:32).
3. Ханийнхаа тухай бод (Малахи 2:14-16).
4. Хамтран гэм нүгэл хийж байгаа хүний тухай бод (Матай 18:6).
5. Хүүхдүүдээ бод (Тооллого 14:33).
6. Гэр бүлээ бод (Эхлэл 12:17; 20:18).
7. Ирэх ичгүүр, харамсалын тухай бод (Сургаалт үгс 5:11-14; 6:32-33).
8. Чуулганаа бод (1 Коринт 5:1-6; 1 Самуел 2:24).
9. Итгэдэггүй хүмүүсийн тухай бод (Ром 2:22,24).
10. Сайн мэдээний дайснуудын тухай бод (2 Самуел 12:13-14).
11. Үйлчлэлийнхээ тухай бод (шүүгчид 16:19-20; 1 Коринт 9:27).
12. Бурханы шүүлтийн тухай бод (Эврей 13:4; Эзекиел 16:38)
13. Мөнхөд орших зүйлсийн тухай бод (Галат 5:19-21).
14. Эцэст нь, ялан дийлсэн үед ирэх алдрын тухай бод (Илчлэл 14:4).

Ярилцах сэдэв - Дээрх шалтгаануудаас аль нь хамгийн чухал гэж бодож байна? яагаад?

19-р хичээл - ДУУРАЙГЧИД

Бидний хүссэн хүсээгүй, индэрийн ард байгаа хүний сайн, муу бүхнийг хүмүүс дуурайх болно. Эфес 5:1-т, “Бурханыг дуурайгчид бай” гэж Паул хэлсэн. Энэ зөвлөмжийг дагавал бүтэлгүйтэх аюул байхгүй. Гэвч, эгэл хүн, удирдагчаа дагах дуртай. Сүнсний удирдагч хонин сүрэгтээ ямар үлгэр дуурайл үзүүлж байгаадаа хариуцлага хүлээнэ.

Тэрээр Бурхантай хамт, маш болгоомжтой алхдаг бол, бусад нь зөв шударгын замыг дагах болно. Харин тэр гэм нүглээр тоглож, Христчин зарчмаасаа бага зэрэг хазайдаг бол бусад нь гэм нүгэл рүү бүр цаашлан орно. Алдагдсан хүмүүсийг аврахад хамаг анхаарлаа хандуулдаг бол, хүмүүст гэрчлэл болохын төлөө сургагдах хүмүүс сайн дураараа гарч ирнэ. Харин удирдагч нь алдагдсан хүмүүсийг аврахад хойрго ханддаг бол чуулганы хүмүүс нь Үгийг биелүүлэгч бус

зөвхөн сонсогч, бүтэн сайны итгэгч болно. Удирдагч нь золиос гарган өргөл өргөдөг бол харамч итгэгч нар удалгүй хэтэвчээ нээн Эзэнд баяр хөөртэйгөөр өргөх болно.

Паул Тессалоник хотын итгэгчид хандан, “Та нар биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон” гэж хэлдэг (1 Тессалоник 1:6). Паул өөрөө гэм зэмгүй амьдрахаар хатуу шийдсэн бөгөөд “Та нараас гуйя. Намайг дуурайгсад бай” гэж хэлсэн байдаг (1 Коринт 4:16).

Ярилцах сэдэв - Хүмүүс таны жишгийг дагавал ямар итгэгч болох вэ?

20-р хичээл - ЯЛАХ НЬ ГАРЦААГҮЙ!

Филиппой 3, 4-р бүлгийг унш.

Эзэнд үйлчилдэг олон хүн өөрийгөө дорд үздэг энэ нь дотроос нь мэргэ, тэднийг идэвхигүй болгодог. Өөрийгөө Эзэнд үйлчилдэг гэж танилцуулахаас ичдэг. Гэтэл Бурхан тэднийг “Хамгийн Дээд Нэгэнд үйлчлэгч” гэж үздэг (Даниел 3:26). Паул яг ийм хандлагаар Бурханд үйлчилдэг байсан (1 Тимот 1:11,12).

Бурхан бидэнд хүчийн сүнсийг өгсөн. Үйлс номын 1:8-д бичигдсэн хүч гэдэг үг нь Грек хэл дээр динамит буюу тэсрэх дэлбэрэх гэсэн утгатай үг. Энэ хүчийн эсрэг ямар ч хүч зогсож чадахгүй.

Бурханаас өгөгдсөн хүчийг хэзээ ч дутуу үнэлж болохгүй. Боломжгүй зүйлийг хийхийг оролд. Боломжтой бүх талбарт хүр. Баян эсвэл өндөр боловсролтой хүнд хүрч, үйлчилж чадахгүй гэж бүү бод.

“Жижигхэн” Паул Бурханы хүчинд итгэж чадсан учраас агуу зүйлсийг хийсэн. Энэ хүчийг ухаарч, ажил. Бурхан танаар дамжуулан Өөрийн тэсэрч дэлбэрэх чадалтай тэр хүчийг үзүүлэх боломжийг олго.

ТА Бурханд хэрэгтэй.

Ярилцах сэдэв - Дараах ишлэлийг уншаад, ямар сул зүйлсийг ашиглан Бурхан Өөрийн хүчийг харуулсан тухай ярилцана уу. Гэтлэл 4:2; Шүүгчид 15:15; 1 Самуел 17:40; Зехариа 4:10; Матай 13:32; Иохан 6:9.

1 Коринт 1:27-29 ишлэлээс агуу үнэнийг олж хар. Энэ ишлэлийг цээжилнэ үү.

ХРИСТ ИТГЭЛТ УРСГАЛУУДЫН ХАРИЛЦАА

Урсгал нэг бүр өөрийн гэсэн өвөрмөц онцлог шинжтэй байдаг. Нэгэнт энэ сургалт маань бүх чуулганд зориулагдсан учир урсгал нэг бүрийн бүрэн тодорхойлолтыг хэвлэмэл хичээлд дурьдах боломжгүй юм. Хэдий тийм боловч, багш нар дараах удирдамжийн дагуу тухайн урсгалын түүх болон ялгарах онцлогийг танилцуулж заах боломжтой.

Энэ сургалтын төгсгөлд, албан бус пастор болж буй хүн тухайн үйлчилж буй талбарынхаа итгэлийн тунхаг, зан үйлтэй нарийвчлан танилцсан байх болно.

ТУХАЙН УРСГАЛЫГ СУДЛАХ

А. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1-р хичээл: Уг урсгалын гадаад улс оронд эхэлсэн түүх; үндэс суурь нь ямар урсгалаас тасарч гарсан; үүсгэн байгуулагчид болон анхны удирдагчид; үүсгэн байгуулагдсан шалтгаан.

2-р хичээл: Уг урсгал тухайн оронд бий болсон түүх; ямар улс оронд байдаг; орон нэг бүрт байгаа чуулганы хэмжээ; бусад чуулгануудын удирдагчид.

3, 4 ба 5-р хичээл: Онол, теологийн ялгаа; бусад урсгалуудаас ялгарах зүйлс, онцгой ач холбогдол өгдөг зүйлс болон үйлчлэлүүд; энэ ялгааны Библийн үндэслэл.

6-р хичээл: Тухайн урсгалыг хариуцсан үндэсний байгууллага; төв байр болон албан тушаалтангууд; ямар хугацаатай тухайн албыг хашдаг болон хэрхэн сонгогддог тухай.

7-р хичээл: Тухайн урсгалд хамаатай сургууль, эмнэлэг; салбарын захирал; жил бүр болдог хурал цуглаан болон үндэсний хэмжээнд болдог бусад уулзалтууд.

8-р хичээл: Орон нутгийн офис болон албан хаагчид; орон нутагт болдог уулзалтууд, ажлын хуваарь.

9-р хичээл: Тухайн урсгалд хамаатай боловсролын болон эрүүл мэндийн байгууламжууд; орон нутгийн чуулганууд; албан болон албан бус пастортой чуулганы тоо.

10-р хичээл: Ирээдүйн албан бус пасторуудыг бэлтгэх сургуулиуд.

Б. АЛБАН БУС ПАСТОР:

11-р хичээл: Шинээр пастор болж буй хүний үүрэг хариуцлага; хэдэн удаа чуулган хийх.

12-р хичээл: Тухайн сүмийн ёс жаягийн дагуу шинээр итгэгчдийг усан баптисмд бэлдэх;

13-р хичээл: Чуулганы гишүүд гэм үйлдсэн үед яах ёстой; тухайн урсгал энэ асуудлыг хэрхэн шийддэг тухай.

14-р хичээл: Омгийн удирдагчид болон бөө, үзмэрч нар эсэргүүцэх үед юу хийх ёстой.

15-р хичээл: Хуриманд хэрхэн бэлтгэх

16-р хичээл: Чуулганы өргөл авах болон өргөлийн мөнгөтэй хэрхэн харьцах.

17-р хичээл: Хөдөө орон нутагт чуулганы байр барих.

18-р хичээл: Зэргэлдээ баг, сумын хүмүүсийг чуулганд хамруулах.

19-р хичээл: Албан бус пасторууд тухайн орон нутаг дотроо солигдон сайн мэдээг хэдэн долоо хоногоор тараах ажилд оролцох.

20-р хичээл: Чуулган дотор шийдэхэд бэрх асуудал гарах үед хэн рүү хандаж удирдамж, зөвлөгөө авах вэ?

НОМЫН ЖАГСААЛТ

Аалбан, Дуглас. *Библийн 100 Хичээл*. Сайн Мэдээний Утга Зохиолын Үйлчлэл, Бумбай, Энэтхэг.

Балчин, Жон. *Библийн Хураангуй Судалгаа*. Бетаны Хаус хэвлэлийн газар, Минниаполис, Миннесота.

Эванс, Виллиам. *Библийн Агуу Онолууд болон Сургаальд Хэрхэн Бэлдэх*. Чикаго дахь Мууди Библийн Институт, Мууди Хэвлэх Үйлдвэр. Зөвшөөрөл авч хэрэглэв.

МкГий, Ж. Вернон. *Библийн Номууд болон Библийн Товч Танилцуулга*. Библийн Номоор Дамжуулан, Пасадена, Калифорния.

Мийд, Хэнриета. *Библи Юуны Тухай Өгүүлдэг*. Регал Ном, Сайн Мэдээний Гэрэл - н Салбар, Шуудангийн Хайрцаг 3875, Вентура, Калифорния 93006. Зөвшөөрөл авч хэрэглэв.

Стэнлий, Эрдэмтэн Лилиан. *Өв Тэгш Эмэгтэй*. Стэнлий, Пастор Р. *Номлогчид болон Хүмүүс*. Ивээлийн Номууд, Шуудангийн Уут 609, Веллоре 632006, Энэтхэг.